



МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН
ХОРОО



Schweizerische Eidgenossenschaft
Confédération suisse
Confederazione Svizzera
Confederaziun svizra

Swiss Agency for Development
and Cooperation SDC
Швейцарийн хөгжлийн агентлаг

БИЧИЛ ҮҮРХАЙ ЭРХЛЭГЧДИЙН СУДАЛГААНЫ НЭГДСЭН ТАЙЛАН, 2012



Улаанбаатар хот
2013 он



МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРОО



Schweizerische Eidgenossenschaft
Confédération suisse
Confederazione Svizzera
Confederaziun svizra

Swiss Agency for Development
and Cooperation SDC
Швейцарийн хөгжлийн агентлаг

БИЧИЛ УУРХАЙ ЭРХЛЭГЧДИЙН СУДАЛГААНЫ НЭГДСЭН ТАЙЛАН, 2012 ОН

Улаанбаатар хот
2013 он

DDC
310'517
X-822

Энэхүү тайлан нь англи хэл дээр хэвлэгдсэн болно.

МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРОО

Монгол Улс, Улаанбаатар хот
Сүхбаатар дүүрэг, Бага тойруу,
Засгийн газрын III байр
Утас: 326414, 322424
Вэб: www.nso.mn
И-мэйл: nso@magicnet.mn

ISBN 978-99962-949-0-7

АГУУЛГА

Хүснэгтийн жагсаалт	5
Зургийн жагсаалт	6
Хавсралт хүснэгтийн жагсаалт	7
Товчилсон үгийн жагсаалт	11
Өмнөх үг	12
НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. БИЧИЛ УУРХАЙ ЭРХЛЭГЧДИЙН СУДАЛГААГ ЗОХИОН БАЙГУУЛСАН ТУХАЙ	
Оршил	15
1.1. Судалгааны удирдлага, зохион байгуулалт	16
1.2. Сургалт, сурталчилгаа	16
1.3. Судалгааны хамрах хүрээ, хугацаа	17
1.4. Ойлголт, тодорхойлолт, ангилал	17
1.5. Судалгааны асуулга, түүний агуулга	22
1.6. Мэдээлэл боловсруулалт	23
1.6.1. Мэдээллийг оруулах бүрдүүлэлтийн үе шат	23
1.6.2. Мэдээллийг хянах, шалгах үе шат	23
1.6.3. Мэдээллийн чанарын үе шат.	24
1.6.4. Орхигдсон мэдээллийг тооцох арга зүй	24
1.6.5. Үр дүнгийн хүснэгт бэлтгэсэн тухай	24
ХОЁРДУГААР БҮЛЭГ. БИЧИЛ УУРХАЙ ЭРХЛЭГЧДИЙН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ	
2.1. Бичил уурхай эрхлэгчид, аймаг, нийслэлээр	29
2.2. Бичил уурхай эрхлэгчид, ашигт малтмалын төрлөөр	32
2.3. Бичил уурхай эрхлэгчдийн тоо, засаг захиргааны нэгжээр	37
2.4. Бичил уурхай эрхлэгчдийн тоо, нас, хүйсийн бүтэц, ам бүлийн тоо	38
2.5. Бичил уурхай эрхлэгчдийн тоо, боловсролын түвшингээр	42
2.6. Бичил уурхай эрхлэгчдийн ажил эрхлэлт	43
ГУРАВДУГААР БҮЛЭГ. БИЧИЛ УУРХАЙ ЭРХЛЭГЧДИЙН СУУЦ, ЦАХИЛГААН ХАНГАМЖ, УНДНЫ УСНЫ ЭХ ҮҮСВЭР	
3.1. Бичил уурхай эрхлэгчдийн сууцны төрөл	51
3.2. Бичил уурхай эрхлэгчдийн ундны усны эх үүсвэр	53
3.3. Бичил уурхай эрхлэгчдийн цахилгааны эх үүсвэр	54

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. БИЧИЛ УУРХАЙ ЭРХЛЭГЧДИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТ

4.1. Тоног, төхөөрөмж ашиглалт	59
4.2. Ашиглаж буй талбай	61
4.3. Бичил уурхай эрхлэгчдийн эдийн засгийн үндсэн үзүүлэлт	64
4.3.1. Бичил уурхай эрхлэгчдийн үйл ажиллагааны ерөнхий мэдээлэл	64
4.3.2. Нийт гаргалт, нэмэгдэл өртөг, завсрын хэрэглээ	71
4.4. Хөрөнгө оруулалт	75

**ТАВДУГААР БҮЛЭГ. АШИГТ МАЛТМАЛЫН ОЛБОРЛОЛТООС УЧИРСАН ХОХИРОЛ,
ОРОН НУТАГТ ОРУУЛСАН ХУВЬ НЭМЭР, ХҮНДРЭЛ БЭРХШЭЭЛ**

5.1. Ашигт малтмалын олборлолтоос учирсан хохирол	79
5.2. Нийгэм, орон нутагт оруулсан хувь нэмэр	86
5.3. Бичил уурхай эрхлэгчдэд тулгарч буй хүндрэл, бэрхшээл	90

ХАВСРАЛТ: АСУУЛГЫН ХУУДАС 101

ХАВСРАЛТ: ХАВСРАЛТ ХҮСНЭГТ 113

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 2.1.	Бичил уурхай эрхлэгчдийн тоо, бүсээр, хувиар	30
Хүснэгт 2.2.	Бичил уурхай эрхлэгчдийн тоо, бүсээр, ашигт малтмалын төрлөөр	33
Хүснэгт 2.3.	Бичил уурхай эрхлэгчдийн тоо, олборлосон алтны хэмжээ, бүсээр	33
Хүснэгт 2.4.	Бичил уурхай эрхлэгчдийн тоо, олборлосон нүүрсний хэмжээ, нэг тн нүүрсний дундаж үнэ, аймаг, дүүргээр	35
Хүснэгт 2.5.	Бичил уурхай эрхлэгчдийн тоо, олборлосон жоншны хэмжээ, нэг тн жоншны дундаж үнэ, аймгаар	36
Хүснэгт 2.6.	Бичил уурхай эрхлэгчдийн тоо, олборлосон гянтболдын хэмжээ, нэг кг гянтболдын дундаж үнэ, аймгаар	36
Хүснэгт 2.7.	Бичил уурхай эрхлэгчдийн тоо, аймаг, ашигт малтмалын төрлөөр	37
Хүснэгт 2.8.	Бичил уурхай эрхлэгчдийн тоо, аймаг, нийслэл, засаг захиргааны харьяаллаар	37
Хүснэгт 2.9.	Бичил уурхай эрхлэгчдийн тоо, насны бүлэг, хүйс, хүйсийн харьцаагаар	39
Хүснэгт 2.10.	Бичил уурхай эрхлэгчдийн ам бүлийн тоо, хувиар	42
Хүснэгт 2.11.	Бичил уурхай эрхлэгчдийн боловсролын түвшин, хүйсээр, хувиар	42
Хүснэгт 2.12.	Бичил уурхай эрхлэгчид, ажил, мэргэжил, хүйсээр, хувиар	46
Хүснэгт 3.1.	Бичил уурхай эрхлэгчдийн ундны эх үүсвэр, ашигт малтмалын төрөл, хувиар	54
Хүснэгт 4.1.	Бичил уурхай эрхлэгчдийн ашиглаж буй тоног төхөөрөмжийн тоо, төрлөөр	60
Хүснэгт 4.2.	Бичил уурхай эрхлэгчдийн ашиглаж буй тоног төхөөрөмжийн нийт дүнд эзлэх хувь, тоног төхөөрөмжийн төрөл, бүсээр	60
Хүснэгт 4.3.	Бичил уурхайд ашиглаж буй газрын хэмжээ, эвдрэлд орсон талбайн хэмжээ, нөхөн сэргээлт хийсэн талбайн хэмжээ, бүсээр	62
Хүснэгт 4.4.	Борлуулсан ашигт малтмалын хэмжээ, ашигт малтмалын төрлөөр	66
Хүснэгт 4.5.	Үйл ажиллагааны нийт орлого, бүсээр	68
Хүснэгт 4.6.	Бичил уурхай эрхлэгчдийн төлсөн татварын хэмжээ, бүс, зардлын төрлөөр	68
Хүснэгт 4.7.	Үйл ажиллагааны зардал, ашигт малтмалын төрөл, зардлын төрлөөр	70
Хүснэгт 4.8.	Үйл ажиллагааны зардал, бүсээр, зардлын төрлөөр	71
Хүснэгт 4.9.	Нийт үйлдвэрлэл, завсрын хэрэглээ, нэмэгдэл өртөг, бүсээр	72
Хүснэгт 4.10.	Нэмэгдэл өртөг, бүрэлдэхүүн хэсгээр, бүсээр	73
Хүснэгт 4.11.	Үйл ажиллагааны завсрын хэрэглээ, бүрэлдэхүүн хэсэг, бүсээр	74
Хүснэгт 4.12.	2011 онд хийсэн хөрөнгө оруулалтын хэмжээ, хөрөнгийн төрөл, бүсээр	76
Хүснэгт 4.13.	2011 онд хийсэн хөрөнгө оруулалтын хэмжээ, хөрөнгийн төрөл, ашигт малтмалын төрлөөр	76
Хүснэгт 5.1.	Бичил уурхай эрхлэгчдийн өртөж байсан осол, аваарын төрөл, бүсээр, хувиар	80
Хүснэгт 5.2.	Бичил уурхай эрхлэгчдийн өвчилсөн өвчин, төрлөөр, ажилласан жилээр, хувиар	82
Хүснэгт 5.3.	Бичил уурхай эрхлэгчдийн өвчлөлт, өвчний төрөл, бүс, хувиар	83

Хүснэгт 5.4.	Бичил уурхайн үйл ажиллагаа явуулж буй сум, дүүргийн эмнэлгийн зай, км-ээр	85
Хүснэгт 5.5.	Бичил уурхай эрхлэгчдийн 2011 онд даатгалд хамрагдсан байдал, даатгалын төрлөөр, бүсээр, хувиар	87
Хүснэгт 5.6.	Бичил уурхай эрхлэгчдийн төрийн болон төрийн бус байгууллагаас тусламж, дэмжлэг авсан байдал, бүсээр	89
Хүснэгт 5.7.	Бичил уурхай эрхлэгчдийн төрийн болон төрийн бус байгууллагаас авсан тусламж, дэмжлэгийн хэлбэр, бүсээр	90
Хүснэгт 5.8.	Бичил уурхай эрхлэгчдэд тулгардаг хүндрэл, бэрхшээл, бүсээр	91
Хүснэгт 5.9.	Бичил уурхай эрхлэгчдэд тулгардаг хүндрэл, бэрхшээл, ашигт малтмалын төрлөөр, хувиар	92
Хүснэгт 5.10.	Бичил уурхай эрхлэгчдийн харьцахад хүндрэлтэй байдаг байгууллагын төрөл, хувиар, бүсээр	94
Хүснэгт 5.11.	Бичил уурхай эрхлэгчдэд тулгардаг хүндрэл, бэрхшээлтэй асуудлыг шийдвэрлэсэн байдал, бүсээр	95
Хүснэгт 5.12.	Ашигт малтмал борлуулахад тулгардаг хүндрэл, бэрхшээл, ашигт малтмалын төрлөөр	96
Хүснэгт 5.13.	Бичил уурхай эрхлэгчдийн ашигт малтмал олборлолтын газрыг шийдвэрлэсэн байдал, ашигт малтмалын төрлөөр	98

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1.1.	Судалгааны мэдээлэл цуглуулах болон боловсруулах ажлын схем	25
Зураг 2.1.	Бичил уурхай эрхлэгчдийн тоо, ажил эрхлэлтийн төрлөөр	29
Зураг 2.2.	Бичил уурхай эрхлэгчдийн тоо, аймаг, нийслэл, бичил уурхай эрхлэгчдийн тооны бүлгээр	30
Зураг 2.3.	Бичил уурхай эрхлэгчдийн тоо, орд газрын тоо, аймаг, нийслэлээр	31
Зураг 2.4.	Бичил уурхайд ашиглаж буй орд газрын байршил, ашигт малтмалын төрөл, аймаг, нийслэлээр	32
Зураг 2.5.	Бичил уурхай эрхлэгчдийн борлуулсан нэг гр алтны дундаж үнэ, аймаг, нийслэлээр	34
Зураг 2.6.	Бичил уурхай эрхлэгчдийн тоо, насны бүлгээр	38
Зураг 2.7.	Бичил уурхай эрхлэгчдийн тоо, насны бүлэг, хүйсээр	40
Зураг 2.8.	Бичил уурхай эрхлэгчийн нас, хүйсийн суварга, насны бүлгээр	40
Зураг 2.9.	Бичил уурхай эрхлэгчдийн тоо, ам бүлийн тооны бүлгээр	41
Зураг 2.10.	Нөхөрлөлийн ахлагч, гишүүний тоо, аймаг, нийслэл, төрлөөр	43
Зураг 2.11.	Нөхөрлөлийн ахлагч, гишүүдийн тоо, орлого хуваарилалтын төрлөөр	44
Зураг 2.12.	Бичил уурхай эрхлэгчдийн тоо, бичил уурхайд ажилласан жилийн бүлгээр, хувиар	47
Зураг 2.13	Бичил уурхай эрхлэгчид, бичил уурхайн үйл ажиллагаа эрхэлж буй шалтгаанаар, хувиар	48
Зураг 3.1.	Бичил уурхай эрхлэгчдийн сууцны эзэмшлийн хэлбэр, сууцны төрлөөр, хувиар	51
Зураг 3.2.	Бичил уурхай эрхлэгчдийн сууцны эзэмшил, сууцны төрлөөр, хувиар	52

Зураг 3.3.	Бичил уурхай эрхлэгчдийн ундны эх үүсвэр, хувиар	53
Зураг 3.4.	Бичил уурхайн үйл ажиллагаа эрхлэгчдийн цахилгааны эх үүсвэр, төрлөөр, хувиар	55
Зураг 4.1.	Тоног төхөөрөмжийн эзэмшлийн төрөл, хувиар	59
Зураг 4.2.	Бичил уурхай эрхлэгчдийн тоо, хөдөлмөр хамгааллын хувцас хэрэглэдэг эсэхээр (хувиар), ашигт малтмалын төрлөөр	61
Зураг 4.3.	Зөвшөөрөлтэй талбайд ажиллаж байгаа бичил уурхай эрхлэгчдийн тоо, хувиар, ашигт малтмалын төрлөөр	62
Зураг 4.4.	Зөвшөөрөлтэй талбайн зөвшөөрлийн төрөл, хувиар	63
Зураг 4.5.	Бичил уурхайд ашиглаж буй газрын хэмжээ, эвдрэлд орсон талбайн хэмжээ, нөхөн сэргээлт хийсэн талбайн хэмжээ, Га-гаар	64
Зураг 4.6.	Ашигт малтмал ашиглалтын хэлбэр, төрлөөр, хувиар	65
Зураг 4.7.	Бичил уурхай эрхлэгчдийн үйл ажиллагааны идэвхи, голлох ашигт малтмалын төрлөөр	65
Зураг 4.8.	Бичил уурхай эрхлэгчдийн гол нийлүүлэгч, бүс, хувиар	66
Зураг 4.9.	Бичил уурхай эрхлэгчдийн үйл ажиллагааны нийт орлого, аймгаар	67
Зураг 4.10.	Бичил уурхай эрхлэгчдийн татвар төлөлтийн хувь, ашигт малтмалын төрлөөр	69
Зураг 4.11.	Бичил уурхай эрхлэгчдийн 2011 онд хөрөнгө оруулалт хийсэн байдал, хувиар, бүсээр	75
Зураг 5.1.	Бичил уурхай эрхлэгчдийн өртөж байсан осол, аваарын төрөл, хувиар	79
Зураг 5.2.	Бичил уурхай эрхлэгчдэд учирсан хохирлын төрөл, хувиар	80
Зураг 5.3.	Бичил уурхай эрхлэгчдийн туссан өвчин, өвчний төрлөөр, хувиар	81
Зураг 5.4.	Бичил уурхай эрхлэгчдийн даатгалд хамрагдсан байдал, даатгалын төрлөөр, хувиар	86
Зураг 5.5.	Бичил уурхай эрхлэгчдийн амьжиргаанд гарсан өөрчлөлт, хүйсээр, хувиар	87
Зураг 5.6.	Бичил уурхай эрхлэгчдийн орон нутагтаа оруулсан хувь нэмэр, төрлөөр, хувь, хүний тоогоор	88
Зураг 5.7.	Бичил уурхай эрхлэгчдийн нийгэм, орон нутагт оруулсан хувь нэмэр, ашигт малтмалын төрлөөр, хувиар	89
Зураг 5.8.	Орон нутгийн засаг, захиргааны байгууллагатай харилцахад хүндрэлтэй байдаг асуудлын төрөл, хувиар	94
Зураг 5.9.	Ашигт малтмал олборлож буй газрын асуудлыг шийдвэрлэсэн байдал, төрлөөр, хувиар	97

ХАВСРАЛТ ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1.	Бичил уурхай эрхлэгчдийн тоо, аймаг, нийслэл, бүсээр	115
Хүснэгт 2.	Бичил уурхай эрхлэгчдийн тоо, аймаг, нийслэл, бүсээр, насны бүлгээр	116
Хүснэгт 3.	Бичил уурхай эрхлэгчдийн тоо, ам бүлийн тооны бүлэг, аймаг, нийслэл, бүсээр	118
Хүснэгт 4.	Бичил уурхай эрхлэгчдийн тоо, боловсролын түвшин, аймаг, нийслэл, бүсээр	119

Хүснэгт 5.	Бичил уурхай эрхлэгчдийн тоо, бичил уурхайд ажилласан жилийн бүлэг, аймаг, нийслэл, бүсээр	120
Хүснэгт 6.	Бичил уурхай эрхлэгчдийн тоо, ажил, мэргэжлийн ангилал, аймаг, нийслэл, бүсээр	121
Хүснэгт 7.	Бичил уурхай эрхлэгчдийн тоо, ажил, мэргэжлийн ангилал, ажилласан жилийн бүлгээр	123
Хүснэгт 8.	Бичил уурхай эрхлэгчдийн тоо, олборлож буй ашигт малтмалын төрөл, аймаг, нийслэл, бүсээр	124
Хүснэгт 9.	Олборлосон ашигт малтмалын хэмжээ, ашигт малтмалын төрөл, аймаг, нийслэл, бүсээр	125
Хүснэгт 10.	Бичил уурхай эрхлэгчдийн тоо, бүс, аймаг, нийслэл, ажил эрхлэлтийн байдлаар	126
Хүснэгт 11.	Бичил уурхайн туслах үйл ажиллагаа эрхлэгчдийн тоо, бүс, аймаг, нийслэл, бичил уурхайн үйл ажиллагаанд оролцож буй үүргээр	127
Хүснэгт 12.	Бичил уурхайн туслах үйл ажиллагаа эрхлэгчдийн тоо, хүйс, бичил уурхайн үйл ажиллагаанд оролцож буй үүргээр	128
Хүснэгт 13.	Бичил уурхайн туслах үйл ажиллагаа эрхлэгчдийн тоо, насны бүлэг, бичил уурхайн үйл ажиллагаанд оролцож буй үүргээр	128
Хүснэгт 14.	Бичил уурхай эрхлэгчдийн тоо, ашигт малтмалын ашиглалтын хэлбэр, ашигт малтмалын төрлөөр, давхардсан тоогоор	129
Хүснэгт 15.	Бичил уурхай эрхлэгчдийн тоо, бүс, аймаг, нийслэл, бичил уурхайн үйл ажиллагааг эрхэлж буй шалтгаанаар, давхардсан тоогоор	130
Хүснэгт 16.	Бичил уурхайн олборлолтын үндсэн үйл ажиллагаа эрхлэгчдийн тоо, бүс, аймаг, нийслэл, үйл ажиллагаа эрхэлж буй газрын цахилгааны эх үүсвэрээр	131
Хүснэгт 17.	Бичил уурхайн олборлолтын үндсэн үйл ажиллагаа эрхлэгчдийн тоо, бүс, аймаг, нийслэл, ундны усны эх үүсвэрээр	132
Хүснэгт 18.	Бичил уурхайн олборлолтын үндсэн үйл ажиллагаа эрхлэгчдийн тоо, бүс, аймаг, нийслэл, өртөж байсан осол, аваарын төрлөөр, хувиар	133
Хүснэгт 19.	Бичил уурхайн олборлолтын үндсэн үйл ажиллагаа эрхлэгчдийн тоо, бүс, аймаг, нийслэл, өвчилсөн өвчний төрлөөр	134
Хүснэгт 20.	Бичил уурхайн олборлолтын үндсэн үйл ажиллагаа эрхлэгчдийн тоо, өвчилсөн өвчний төрөл, насны бүлгээр	136
Хүснэгт 21.	Бичил уурхайн олборлолтын үндсэн үйл ажиллагаа эрхлэгчдийн тоо, өвчилсөн өвчний төрөл, хүйсээр	136
Хүснэгт 22.	Бичил уурхайн олборлолтын үндсэн үйл ажиллагаа эрхлэгчдийн тоо, бүс, аймаг, нийслэл, даатгалд хамрагдсан байдлаар	138
Хүснэгт 23.	Бичил уурхайн олборлолтын үндсэн үйл ажиллагаа эрхлэгчдийн тоо, ашигт малтмалын төрөл, даатгалд хамрагдсан байдал	139
Хүснэгт 24.	Бичил уурхайн олборлолтын үндсэн үйл ажиллагаа эрхлэгчдийн тоо, бүс, аймаг, нийслэл, нийгэм, орон нутагт оруулсан хувь нэмэрээр	140
Хүснэгт 25.	Бичил уурхайн олборлолтын үндсэн үйл ажиллагаа эрхлэгчдийн тоо, бүс, аймаг, нийслэл, төрийн болон төрийн бус байгууллагаас тусламж, дэмжлэг авсан эсэхээр	141
Хүснэгт 26.	Бичил уурхайн олборлолтын үндсэн үйл ажиллагаа эрхлэгчдийн тоо, бүс, аймаг, нийслэл, тулгарч буй хүндрэл бэрхшээлийн төрлөөр	142
Хүснэгт 27.	Бичил уурхайн олборлолтын үндсэн үйл ажиллагаа эрхлэгчдийн тоо, тулгарч буй хүндрэл бэрхшээл, ашигт малтмалын төрлөөр	144

Хүснэгт 28.	Бичил уурхайн олборлолтын үндсэн үйл ажиллагаа эрхлэгчдийн тоо, ажилласан жилийн бүлэг, амьжиргаанд орсон өөрчлөлтийн төрлөөр	145
Хүснэгт 29.	Бичил уурхайн олборлолтын үндсэн үйл ажиллагаа эрхлэгчдийн тоо, ажилласан жилийн бүлэг, амьжиргаанд орсон өөрчлөлт, хүйс, насны бүлгээр	146
Хүснэгт 30.	Бичил уурхайн олборлолтын үндсэн үйл ажиллагаа эрхлэгчдийн тоо, бүс, аймаг, нийслэл, засаг, захиргааны байгууллагатай харилцахад хүндрэлтэй асуудал тулгардаг эсэхээр	147
Хүснэгт 31.	Засаг, захиргааны байгууллагатай харилцахад хүндрэлтэй асуудалтай тулгардаг бичил уурхайн олборлолтын үндсэн үйл ажиллагаа эрхлэгчдийн тоо, бүс, аймаг, нийслэл, хүндрэл, бэрхшээлийг хэрхэн шийдвэрлэсэн байдлаар	148
Хүснэгт 32.	Засаг, захиргааны байгууллагатай харилцахад хүндрэлтэй асуудалтай тулгардаг бичил уурхайн олборлолтын үндсэн үйл ажиллагаа эрхлэгчдийн тоо, ашигт малтмалын төрөл, хүндрэл, бэрхшээлийг хэрхэн шийдвэрлэсэн байдлаар	149
Хүснэгт 33.	Бичил уурхайн олборлолтын үндсэн үйл ажиллагаа эрхлэгчдийн тоо, бүс, аймаг, нийслэл, ашигт малтмал борлуулахад тулгардаг хүндрэл, бэрхшээлийн төрлөөр	150
Хүснэгт 34.	Бичил уурхайн олборлолтын үндсэн үйл ажиллагаа эрхлэгчдийн тоо, ашигт малтмалын төрөл, ашигт малтмал борлуулахад тулгардаг хүндрэл, бэрхшээлийн төрлөөр	151
Хүснэгт 35.	Бичил уурхайн олборлолтын үндсэн үйл ажиллагаа эрхлэгчдийн тоо, бүс, аймаг, нийслэл, ашигт малтмал олборлож буй газрын асуудлыг шийдвэрлэсэн байдлаар	152
Хүснэгт 36.	Бичил уурхайн олборлолтын үндсэн үйл ажиллагаа эрхлэгчдийн тоо, ашигт малтмалын төрөл, ашигт малтмал олборлож буй газрын асуудлыг шийдвэрлэсэн байдлаар	153
Хүснэгт 37.	Бичил уурхайн олборлолтын үндсэн үйл ажиллагаа эрхлэгчдийн тоо, бүс, аймаг, нийслэл, бичил уурхайн үйл ажиллагаа явуулахад төрийн болон төрийн бус байгууллагаас авахыг хүсч буй тусламж дэмжлэгээр	154
Хүснэгт 38.	Тоног төхөөрөмжийн тоо, төрлөөр, бүс, аймаг, нийслэлээр	156
Хүснэгт 39.	Бичил уурхайн олборлолтын үндсэн үйл ажиллагаа эрхлэгчдийн тоо*, хөдөлмөр хамгааллын хувцас хэрэглэдэг эсэх, хүйсээр	157
Хүснэгт 40.	Бичил уурхайн олборлолтын үндсэн үйл ажиллагаа эрхлэгчдийн тоо*, хөдөлмөр хамгааллын хувцас хэрэглэдэг эсэх, насны бүлгээр	157
Хүснэгт 41.	Бичил уурхайн олборлолтын үндсэн үйл ажиллагаа эрхлэгчдийн тоо*, хөдөлмөр хамгааллын хувцас хэрэглэдэг эсэх, боловсролын түвшингээр	158
Хүснэгт 42.	Бичил уурхайн олборлолтын үндсэн үйл ажиллагаа эрхлэгчдийн тоо*, хөдөлмөр хамгааллын хувцас хэрэглэдэг эсэх, бүс, аймаг, нийслэлээр	159
Хүснэгт 43.	Бичил уурхайн олборлолтын үндсэн үйл ажиллагаа эрхлэгчдийн тоо*, бүс, аймаг, нийслэл, ашиглаж байгаа талбайн төрлөөр	160
Хүснэгт 44.	Бичил уурхайн олборлолтын үндсэн үйл ажиллагаа эрхлэгчдийн тоо*, ашигт малтмалын төрөл, ашиглаж байгаа талбайн төрлөөр	161
Хүснэгт 45.	Бичил уурхайн олборлолтын үндсэн үйл ажиллагаа эрхлэгчдийн тоо*, бүс, аймаг, нийслэл, нөхөн сэргээлт хийсэн эсэхээр	162
Хүснэгт 46.	Бичил уурхайн олборлолтын үндсэн үйл ажиллагаа эрхлэгчдийн тоо*, ашигт малтмалын төрөл, нөхөн сэргээлт хийсэн эсэхээр	163

Хүснэгт 47.	2011 оны үйл ажиллагааны зардлын хэмжээ, ашигт малтмалын төрлөөр	164
Хүснэгт 48.	2011 оны үйл ажиллагааны зардлын хэмжээ, төрөл, бүс, аймаг, нийслэлээр	165
Хүснэгт 49.	Бичил уурхайн олборлолтын үндсэн үйл ажиллагаа эрхлэгчдийн тоо*, бүс, аймаг, нийслэл, татвар төлсөн эсэхээр	167
Хүснэгт 50.	Бичил уурхайн олборлолтын үндсэн үйл ажиллагаа эрхлэгчдийн тоо*, ажил эрхлэлтийн байдал, татвар төлсөн эсэхээр	168
Хүснэгт 51.	Бичил уурхайн олборлолтын үндсэн үйл ажиллагаа эрхлэгчдийн тоо*, ашигт малтмалын төрөл, татвар төлсөн эсэхээр	168
Хүснэгт 52.	2011 онд төлсөн татварын хэмжээ, бүс, аймаг, нийслэл, татварын төрлөөр	169
Хүснэгт 53.	2011 онд төлсөн татварын хэмжээ, ашигт малтмалын төрөл, татварын төрлөөр	170
Хүснэгт 54.	Бичил уурхайн олборлолтын үндсэн үйл ажиллагаа эрхлэгчдийн тоо*, бүс, аймаг, нийслэл, хөрөнгө оруулалт хийсэн эсэхээр	171
Хүснэгт 55.	Бичил уурхайн олборлолтын үндсэн үйл ажиллагаа эрхлэгчдийн тоо*, ашигт малтмалын төрөл, хөрөнгө оруулалт хийсэн эсэхээр	172
Хүснэгт 56.	2011 онд хийсэн хөрөнгө оруулалтын хэмжээ, ашигт малтмалын төрөл, хөрөнгө оруулалтын төрлөөр	172
Хүснэгт 57.	2011 онд хийсэн хөрөнгө оруулалтын хэмжээ, бүс, аймаг, нийслэл, хөрөнгө оруулалтын төрлөөр	173
Хүснэгт 58.	Нийт гаргалт, завсрын хэрэглээ, нэмэгдэл өртөг, бүс, аймаг, нийслэлээр	174
Хүснэгт 59.	Нийт гаргалт, завсрын хэрэглээ, нэмэгдэл өртөг, ашигт малтмалын төрлөөр	178

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

АМГ	Ашигт малтмалын газар
АР	Архангай
БОАЖЯ	Байгаль орчин, аялал жуулчлалын яам
БӨ	Баян-Өлгий
БУ	Булган
БУЭ	Бичил уурхай эрхлэгч
БХ	Баянхонгор
ГА	Говь-Алтай
ГС	Говьсүмбэр
ДА	Дархан-Уул
ДД	Дорнод
ДО	Дорноговь
ДУ	Дундговь
ЗА	Завхан
МБТГ	Мэдээлэл боловсруулалт, технологийн газар
МЭЗСГ	Макро эдийн засгийн статистикийн газар
НХХЯ	Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам
ӨВ	Өвөрхангай
ӨМ	Өмнөговь
СҮ	Сүхбаатар
СЭ	Сэлэнгэ
СЯ	Сангийн яам
SPSS	Statistical Package for the Social Sciences
ТБУТ	Тогтвортой бичил уурхай төсөл
ТЕГ	Татварын ерөнхий газар
ТӨ	Төв
УБ	Улаанбаатар
УВ	Увс
ҮСХ	Үндэсний статистикийн хороо
ХО	Ховд
ХӨ	Хөвсгөл
ХЭ	Хэнтий
ШХА	Швейцарийн хөгжлийн агентлаг
ЭБЭХЯ	Эрдэс баялаг, эрчим хүчний яам
ЭЗСХ	Эдийн засгийн статистикийн хэлтэс

ӨМНӨХ ҮГ



Монгол Улсын Үндэсний статистикийн хороо, Швейцарийн хөгжлийн агентлагийн “Тогтвортой бичил уурхай” төсөл хамтран уул уурхайн салбарт бичил уурхай эрхлэгч иргэдийн судалгааг амжилттай зохион байгуулж, явууллаа. Манай улсын эдийн засагт уул уурхайн салбар голлох байр суурь эзлэх болсон энэ цаг үед уг судалгааг нэгдсэн арга зүй, зарчмаар явуулж, үр дүнг нэгтгэсэн нь салбарын үйл ажиллагааг бүхэлд нь тооцож, эдийн засагт оруулж буй хувь нэмрийг тодорхойлоход ихээхэн чухал ач холбогдолтой боллоо.

Үндэсний статистикийн хороо нь хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэдийн бүртгэлийг 2006 онд аж ахуйн нэгжийн тооллоготой хамтатган явуулсан бөгөөд түүнээс хойш энэ чиглэлийн албан ёсны судалгааны ажил хийгдээгүй байлаа. Энэ удаагийн судалгаа нь уул уурхайн салбарт албан болон албан бусаар хөдөлмөр эрхэлж буй иргэдийг хамарсан тусгайлсан судалгаа болж, судалгааны үр дүнд үндэслэн газарзүйн мэдээллийн санг бүрдүүлж чадсанаараа судалгааны чухал үр дүн, онцлог нь болж байна.

Манай Улсын нутаг дэвсгэрт гар аргаар ашигт малтмал олборлож буй иргэд болон тэдгээртэй хамааралтай бүхий л үйл ажиллагааг газар зүйн байршлаар нь үнэн зөв тогтоож, улс орны эдийн засаг, нийгмийн хөгжилд тэдний оруулж буй хувь нэмрийг бодитой тодорхойлсон энэхүү судалгааны үр дүн нь бодлого боловсруулагчдад шийдвэр гаргах суурь мэдээлэл болно гэдэгт итгэлтэй байна.

Судалгааг удирдан зохион байгуулж, амжилттай явуулсан ҮСХ-ны МЭЗСГ-ын ажлын баг, судалгааг удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажилласан удирдах хорооны гишүүд болон уг судалгааг явуулахад санхүүгийн дэмжлэг үзүүлэн хамтарч ажилласан Швейцарийн хөгжлийн агентлагийн “Тогтвортой бичил уурхай” төслийн хамт олонд гүн талархал илэрхийлж байна.

ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН
ХОРООНЫ ДАРГА,



С.МЭНДСАЙХАН

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

БИЧИЛ УУРХАЙ ЭРХЛЭГЧДИЙН
СУДАЛГААГ ЗОХИОН БАЙГУУЛСАН
ТУХАЙ

ОРШИЛ

Үндэсний статистикийн хороо нь дэлхийн улс орны статистикийн байгууллагуудын нэгэн адил улс орны эдийн засаг дахь албан бус секторын үйл ажиллагааны үр дүнг дотоодын нийт бүтээгдэхүүнд тусгах талаар цогц ажлыг үе шаттайгаар авч хэрэгжүүлж ирсэн билээ.

Улсын Их Хурлын 2011 оны 59 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын статистикийн салбарыг 2011-2015 онд хөгжүүлэх үндэсний хөтөлбөр”-ийн 3.4 хэсэгт “Дотоодын нийт бүтээгдэхүүний тооцоо, хамралт, мэдээллийн чанар, аргачлал, арга зүйг сайжруулах” зорилт тавьж, уг зорилтын хүрээнд “Далд эдийн засгийн хэмжээг тодорхойлно” гэж тусгагдсан. Энэхүү зорилтын хүрээнд Швейцарийн хөгжлийн агентлагийн санхүү, техникийн дэмжлэгтэйгээр уул уурхайн салбарт бичил уурхай эрхлэгч иргэдийн судалгааг амжилттай зохион байгуулж, явууллаа.

Манай улсын ашигт малтмалын илрэл бүхий орд, газруудад бичил уурхайн үйл ажиллагаа эрхэлж байгаа иргэдийн тоо, тэдгээрийн байршил, эдийн засагт оруулж буй хувь нэмрийг тооцох, түүнчлэн тэдний өмнө тулгарч буй хүндрэл бэрхшээлийг тодорхойлохуйц мэдээллийн нэгдсэн сан, эх үүсвэрийг бүрдүүлэхэд судалгааны зорилго чиглэгдсэн.

Судалгааны үр дүн нь манай улсын эдийн засагт голлох байр эзэлдэг салбаруудын нэг уул уурхай, олборлох салбарт албан бус хөдөлмөр эрхлэгчдийн өнөөгийн дүр төрх, хөгжлийн чиг хандлагыг тодорхойлоход шаардлагатай суурь мэдээллийг бүрдүүлж байгаагаараа онцлог юм.

Судалгаанд нийт 13.4 мянган иргэд хамрагдсан бөгөөд энэ нь 2012 оны эцсийн нийт эдийн засгийн идэвхтэй хүн амын 1.2 хувь, нийт ажилгүй иргэдийн 14.1 хувийг эзэлж байна. Ашигт малтмал олборлож буй нийт иргэдийн 78.2 хувь, нийт орлогын 73.8 хувь, нэмэгдэл өртгийн 73.3 хувийг алт олборлолтын үйл ажиллагаа бүрдүүлж байна. Энэ утгаараа алт олборлодог иргэд их байгаа нь харагдаж байна.

Монгол Улсын Засгийн газар бичил уурхайн салбарыг төрөөс зохицуулах, энэ салбарыг үндэсний эдийн засгийг бүрдүүлэгч идэвхитэй хэсэг болгох талаар явуулж буй арга хэмжээний хүрээнд бичил уурхайд чиглэсэн бодлого эрх зүйн таатай орчинг бий болгох, албан ёсны, хариуцлагатай бичил уурхайн үйл ажиллагааг хөгжүүлэх үүднээс “Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам”-ыг Засгийн газрын 2010 оны 308 дугаар тогтоолоор баталсан. Энэ нь тус салбарт хууль эрх зүйн орчинг бүрдүүлэхэд түлхэц болсон бөгөөд энэхүү судалгааны үр дүнд үндэслэн бичил уурхай эрхлэгчдийн талаар бодлого, боловсруулж, шийдвэр гаргахад үндсэн суурь мэдээлэл нь болно гэдэгт итгэлтэй байна.

Үр дүнгийн тайлан нь үндсэн 5 бүлэг болон судалгааны нэгдсэн үр дүнг харуулах хавсралт хүснэгтүүдээс бүрдэж байна. Тайлангийн нэгдүгээр бүлэгт судалгааны удирдлага зохион байгуулалт, сурталчилгаа, мэдээлэл боловсруулалт зэрэг зохион байгуулалттай холбоотой арга хэмжээнүүдийг цогц байдлаар тусгасан бол хоёрдугаар бүлэгт бичил уурхай эрхлэгчдийн талаарх ерөнхий мэдээлэл, гуравдугаар бүлэгт бичил уурхай эрхлэгчдийн ахуйн нөхцөл, дөрөвдүгээр бүлэгт бичил уурхай эрхлэгчдийн үндсэн үйл ажиллагаа, тавдугаар бүлэгт ашигт малтмалын олборлолтоос учирсан хохирол, бичил уурхай эрхлэгчдийн орон нутгийн хөгжилд оруулсан хувь нэмэр, хүндрэл бэрхшээл зэрэг асуудлыг авч үзсэн.

1.1 СУДАЛГААНЫ УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Бичил уурхай эрхлэгчдийн судалгааг хамралт сайтай явуулах, судалгааны ажлыг дүгнэх, үнэлгээ хийх, нэгдсэн удирдлагаар хангах, арга зүйн дэмжлэг үзүүлэх, судалгааны үр дүнг тайлагнах ажлын хэсгийг Үндэсний статистикийн хороо, Швейцарийн хөгжлийн агентлагийн 'Тогтвортой бичил уурхай' төсөл, ЭБЭХЯ, БОАЖЯ, НХХЯ, АМГ зэрэг 6 байгууллагын 13 хүний бүрэлдэхүүнтэй байгуулж, ажиллалаа.

Түүнчлэн судалгааг орон нутагт удирдан зохион байгуулах, судалгааны явц болон тулгарч буй асуудлын талаар ажлын хэсгийн гишүүдэд танилцуулж байх, холбогдох арга хэмжээ авч ажиллах үүрэг бүхий аймаг, нийслэлийн ажлын дэд хэсгүүдийг 20 аймаг, нийслэлд байгуулан ажилласан. Шат шатанд ажлын хэсгийг байгуулж ажилласан нь цаг үеийн холбогдолтой хүндрэл, бэрхшээл болон бусад асуудлыг цаг алдалгүй шийдвэрлэх боломжийг олгосон.

Мэдээллийн нууцлалыг Монгол Улсын "Статистикийн тухай" хуулийн 22 дугаар зүйлийн 3 дугаар заалтын дагуу хадгалж, цуглуулсан мэдээллийг бодлого боловсруулах, хэрэгжилтийг дүгнэхэд ашиглана гэсэн итгэл үнэмшлийг бичил уурхай эрхлэгчдэд төрүүлж, тэдэнтэй хамтарч ажилласан. Уг заалтыг мэдээлэл цуглуулах, боловсруулах бүх шатанд мөрдсөн.

1.2 СУРГАЛТ, СУРТАЛЧИЛГАА

Судалгааны бэлтгэл ажлын хүрээнд чанартай сайн зохион байгуулах ажлын нэг нь орон нутагт судалгааг зохион байгуулах ахлагч нарын сургалт болон судалгааны ажлыг орд газруудад гардан зохион байгуулах судлаач нарын сургалт байсан бөгөөд 2 шатны сургалтыг зохион байгуулсан. Үүнд:

- Аймаг, нийслэлийн статистикийн хэлтсийн ахлагч нарын буюу судлаач бэлтгэх, сургагч багшийн сургалтыг 2012 оны 7 дугаар сарын 16-17-ны өдрүүдэд Улаанбаатар хотод,
- Орон нутагт ажиллах судлаач нарын сургалтыг 2012 оны 7 дугаар сарын 22-25-ны өдрүүдэд орон нутагт зохион байгуулсан.

Сургалтын үеэр сургалтанд хамрагдсан ажилтнуудад дараах мэдээллийг өгсөн. Үүнд:

1. Судалгааны ерөнхий зохион байгуулалт;
2. Судлаач, шалгагч нарын үүрэг, баримтлах зарчим, тэдний үйл ажиллагаанд хориглох зүйл;
3. Асуулгын хуудсыг нөхөхөд шаардагдах ангилал, код;
4. Асуулга нөхөх заавар;
5. Асуулга үнэн зөвийг шалгах аргачлал;
6. Газрын зураг, түүнийг тэмдэглэх заавар;

Бичил уурхай эрхлэгчдийн судалгааг нэгдсэн удирдлага, аргазүйгээр хангах ажлын хэсэг, судалгааг орон нутагт зохион байгуулах ажлын багууд сурталчилгааны ажлын тусгайлсан төлөвлөгөө боловсруулж ажилласан. Судалгааны сурталчилгааг 2 үе шаттайгаар, 3 төрлөөр явуулсан бөгөөд "TV5", "TV25", "TV8" болон бусад орон нутгийн телевиз, радиогоор шторк цацаж, судалгааны явц болон ач холбогдлын талаар хэд хэдэн удаагийн ярилцлага, мөн "Зууны мэдээ", "Өнөөдөр сонин", интернэт вэб сайтуудад судалгааны талаарх холбогдох мэдээллийг нийтлүүлэх, бичил уурхайн судалгаа явагдаж байгаа тухай мэдээллийг багтаасан фостер хэвлүүлж, бичил уурхайчид олонтой сумдын төвд байрлуулсан.

1.3 СУДАЛГААНЫ ХАМРАХ ХҮРЭЭ, ХУГАЦАА

Судалгааг хүйтний улирлаас үл хамаарсан алт, жонш зэрэг ашигт малтмал олборлодог аймгуудад 8 дугаар сард, хүйтний улиралд үйл ажиллагаа нь идэвхждэг иргэдийн судалгааг 10-11 дүгээр сард нийт 20 аймгийн 76 сум, нийслэлийн 1 дүүргийн ашигт малтмалын илрэл бүхий 238 орд, газарт зохион байгууллаа. Судалгаанд 10 ба түүнээс дээш насны хүүхдийг хамруулсан.

Орон нутагт сургалтанд хамрагдаж бэлтгэгдсэн судлаач нар сонгогдсон сумынхаа ашигт малтмалын илрэл бүхий орд, газруудад биечлэн очиж бичил уурхай эрхлэгчдээс асуулгын дагуу судалгааг авсан бөгөөд судалгаа явагдах үеэр бичил уурхай эрхлэгчдийг аль болох бүрэн хамруулах зорилгоор судлаач нар олон удаагийн давтамжтайгаар орд газруудад очиж мэдээллийг цуглуулсан.

Бичил уурхайн үйл ажиллагааг байнга эрхэлдэг боловч судалгаа явагдах хугацаанд тухайн орд газарт ажиллаагүй иргэдийг орхигдуулахгүй байх чиглэлийг аймаг, нийслэлийн ажлын багт өгч ажилласны дагуу шат шатны ажлын багууд сум, дүүрэг, баг, хорооны анхан шатны бүртгэлд тулгуурлан тулгалтыг хийж судалгаанд хамруулсан. Үүний үр дүнд судалгааны хугацаанд 13.4 мянган бичил уурхай эрхлэгчдийг судалгаанд хамруулж чадлаа.

1.4 ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ, АНГИЛАЛ

Бичил уурхай эрхлэгчдийн судалгаанд дараах тодорхойлолт, ангилалыг ашигласан. Үүнд:

Ажил эрхлэлтийн байдал ба тодорхойлолт	
Ойлголт	Тодорхойлолт
Бичил уурхай	Монгол Улсын “Газрын тухай” хуулийн 16.1.11-д заасан зориулалтаар олгосон ашигт малтмалын үйлдвэрлэлийн бус агуулгатай эдийн засгийн үр ашиггүй орд, ашиглалтын болон технологийн хаягдлаар бий болсон үүсмэл орд, илрэл бүхий талбайд ашигт малтмал олборлох зорилгоор Монгол Улсын “Иргэний хууль”-ийн 481.1-д заасны дагуу бүртгэгдээгүй нөхөрлөлийн хэлбэрээр зохион байгуулагдсан иргэдийн эрхэлж байгаа үйл ажиллагаа” юм.
Бичил уурхайн нөхөрлөл	Монгол Улсын “Иргэний хууль”-ийн 481.1-д заасны дагуу хамтран ажиллах гэрээний үндсэн дээр бүртгэгдээгүй нөхөрлөл хэлбэрээр зохион байгуулагдаж “Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох” журамд зааснаар үйл ажиллагаа явуулж байгаа бүлэг хүмүүсийг хэлнэ.
Нөхөрлөлийн ахлагч/ ажил олгогч	Нөхөрлөлийн зарчмаар, хэсэг бүлэг хүнийг нэгдсэн удирдлагаар хангах, цалин хөлс олгох, орлогоо хуваарилах, нөхөрлөлийн гишүүдийн өмнөөс гэрээ байгуулах, хариуцлага хүлээх чадвар бүхий этгээдийг хэлнэ.

Ойлголт	Тодорхойлолт
Нөхөрлөлийн гишүүн	Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журмын 7.4-д заасан шаардлага хангасан, ашигт малтмал олборлох зорилгоор хамтран ажиллах гэрээ байгуулсан иргэнийг хэлнэ.
Хувиараа/дангаараа ашигт малтмал олборлогч	Ямар нэгэн нөхөрлөлд харьяалагддаггүй, хувиараа/дангаараа ашигт малтмал олборлож буй иргэнийг хамруулна.
Бичил уурхайн туслах үйл ажиллагаа эрхлэгч	Бичил уурхайн үйл ажиллагаанд ашигт малтмал худалдан авах, хүнс, барааны худалдаа эрхлэх, зоогийн газрын үйл ажиллагаа эрхлэх, тээврийн хэрэгслээр үйлчлэх зэрэг ашигт малтмалын олборлолтонд шууд гардан оролцдоггүй, туслах үйл ажиллагаа эрхлэгчийг хамруулна.
Гэр бүлийн бизнест цалин хөлсгүй оролцогч	Бичил уурхайн үйл ажиллагаанд цалин хөлсгүй оролцогч гэр бүлийн гишүүнийг хамруулна.

Боловсролын ангилал ба тодорхойлолт	
Ойлголт	Тодорхойлолт
Боловсролгүй	Ерөнхий боловсролын сургуулийн 4 дүгээр анги (1975 он хүртэл болон 1997-2004 онд), 3 дугаар ангийг (1975-1996 онд), 5 дугаар ангийг (2005 оноос хойш) төгсөөгүй хүнийг боловсролгүй гэж үзнэ. Өөрөөр хэлбэл ЕБС-ийн 1-5 дугаар ангид одоо сурч байгаа хүүхдүүд болон 3, 4-р ангийг төгсөөгүй хүмүүс боловсролгүй гэдэгт багтана.
Бага	Ерөнхий боловсролын сургуулийн 4-р анги /1975 он хүртэл болон 1997-2004 онд 3-р анги (1975-1996 оныг дуустал), 2004 оноос хойш 5-р анги төгссөн хүмүүсийг бага боловсролтой гэж үзнэ.
Суурь	Ерөнхий боловсролын 7-р анги (1975 он хүртэл хуучин системээр), 8-р анги (1975-2004 он дуустал), 9-р анги (2005 оноос хойш) төгссөн үнэмлэхтэй хүмүүсийг суурь боловсролтой гэж үзнэ.
Бүрэн дунд	Ерөнхий боловсролын сургуулийн 10-р анги (2005 он дуустал), 11-р ангийг (2006 оноос хойш) өдөр, оройгоор төгссөн үнэмлэхтэй хүмүүсийг бүрэн дунд боловсролтой гэж үзнэ.
Техникийн болон мэргэжлийн	Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв (хуучнаар техник, мэргэжлийн сургууль - ТМС) төгссөн, мэргэжлийн үнэмлэхтэй хүмүүсийг техникийн болон мэргэжлийн боловсролтой гэж үзнэ.

Ойлголт	Тодорхойлолт
Тусгай мэргэжлийн дунд	Гадаад, дотоодын тусгай мэргэжлийн дунд сургууль (хуучнаар техникум), түүнтэй адилтгах сургууль төгссөн, үнэмлэх, дипломтой хүмүүсийг тусгай мэргэжлийн дунд боловсролтой гэж үзнэ.
Дээд	Гадаад дотоодын их, дээд сургууль, коллежийг өдөр, орой, эчнээгээр төгссөн, дипломын дээд, бакалавр, магистр, докторын зэргийн диплом болон түүнтэй адилтгах боловсролын баримт бичиг бүхий хүмүүсийг дээд боловсролтой гэж үзнэ.

Ажил, мэргэжлийн ангилал ба тодорхойлолт	
Ойлголт	Тодорхойлолт
Менежер	Менежер нь засгийн газар, аж ахуйн нэгж, байгууллага, түүний дотоод нэгжийн үйл ажиллагааг төлөвлөх, удирдан чиглүүлэх, зохицуулах, үнэлэх, бодлого, журам боловсруулж хэрэгжилтэнд хяналт тавих ажлыг гүйцэтгэнэ.
Мэргэжилтэн	Шинжлэх ухаан, урлагийн онол, үзэл баримтлалыг ашиглах, эдгээрийг системчилсэн хэлбэрээр заан сургах буюу тус үйл ажиллагааны аливаа хослолыг мэргэжлийн өндөр түвшинд хийж гүйцэтгэнэ.
Техникч болон туслах дэд мэргэжилтэн	Уул уурхай, аж үйлдвэр, барилга болон бусад салбарын инженерийн үйл ажиллагаатай холбоотой техникийн болон үйлдлийн үйл ажиллагааг хянах, удирдах, тоног төхөөрөмж ажиллуулах үүрэг бүхий шинжлэх ухаан, инженерийн чиглэлээр хийх судалгаа, практикт хэрэгжүүлэхэд холбогдох техник шинжтэй ажил гүйцэтгэнэ.
Контор үйлчилгээний ажилтан	Таталган бичиж тэмдэглэл хөтлөх, бичгийн машинаар бичих, компьютер болон бичиг хэргийн бусад төхөөрөмжийг ажиллуулах, мэдээллийг компьютерт оруулах, нарийн бичгийн даргын үүрэг гүйцэтгэх, тоон мэдээллийг тэмдэглэх ба тооцоолон бодох, үйлдвэрлэл, тээврийн холбогдох тэмдэглэл хөтлөх, номын сан, мөнгөний гүйлгээ, холбоо, шуудангийн холбоотой ажлыг гүйцэтгэх, аялал жуулчлал зохион байгуулах, үйлчлүүлэгчийг мэдээллээр хангах, уулзалт товлох зэрэг ажил, үүрэг гүйцэтгэнэ.
Худалдаа, үйлчилгээний ажилтан	Үйлчилгээ, худалдааны ажилтан нь аялал жуулчлал, гэр ахуйн ажил эрхлэх, нийтийн хоолоор үйлчлэх, хувь хүн асрах, гал түймрээс сэргийлэх, хамгаалах эсвэл бөөний ба жижиглэн худалдаа, бусад төстэй байгууллагад, тэрчлэн зах, мухлагаар, бараа таваар дэлгэн үзүүлэх, худалдаж борлуулахад холбогдсон хувийн болон хамгаалалтын шинжтэй үйлчилгээ үзүүлэх үүрэгтэй.

Ойлголт	Тодорхойлолт
Хөдөө аж ахуй, ой, загас агнуурын мэргэжилтэн	Хөдөө аж ахуй, ой, загас агнуурын мэргэшсэн ажилтан нь үр тариа, мод, бут, малын тэжээл ургуулах, зэрлэг жимс, ургамал түүх, ан амьтан үржүүлэх, харж хамгаалах, агнах, төрөл бүрийн амьтны гаралтай бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ашиглах, гэр бүлийнхээ хоол хүнсэнд зориулан загас үржүүлэх буюу барих, усны бусад төрөл зүйлийг өсгөж үржүүлнэ.
Үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил, үйлчилгээний ажилтан	Үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил, үйлчилгээний ажилтан нь барилга барих, арчлах, металл хэлбэр оруулах, металл бүтээцийг босгох, автомат бүтээцийг босгох, автомат багаж хэрэгслийг тохируулах, машин механизм, тоног төхөөрөмж, багаж хийх, тааруулах, засварлах, хэвлэх ажлын бүтээгдэхүүн гаргах, хүнсний зүйл, нэхмэл эдлэл, модон, металл, бусад эд бараа, түүний дотор гар урлалын зүйл үйлдвэрлэх үйл ажиллагааг гүйцэтгэнэ.
Машин механизм, төхөөрөмжийн операторч, угсрагч	Уул уурхайн аж үйлдвэрийн бусад салбар тухайлбал металл боловсруулах, эрдэс, шил, керамик, мод, цаас болон химийн үйлдвэрийн тоног төхөөрөмжийг ажиллуулах, хянах, ус цэвэрлэх, цахилгаан эрчим хүч үйлдвэрлэх, тоног төхөөрөмжийг монтажлах, ажиллуулах, хянах зэрэг ажил, үүрэг гүйцэтгэнэ.
Энгийн ажил, мэргэжил	Олон нийтийн газар, гудамж талбайд буюу айл дамжиж бараа худалдаалах, гудамжинд төрөл бүрийн үйлчилгээ хийх, цэвэрлэгээ, угаалга хийх, индүүдэх, айлын орон гэр, зочид буудал, албан тасалгаа, болон бусад байрыг арчилж тордох, цонх, барилга, байшингийн бусад үйл ажиллагааг гүйцэтгэнэ.
Зэвсэгт хүчний ажил, мэргэжил	Зэвсэгт хүчний ажил, мэргэжилд зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүний гүйцэтгэдэг бүх ажил орно. Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүн нь цэргийн алба хаагч болон цэргийн анги байгууллагад гэрээгээр ажиллагчдаас бүрдэнэ. Энэ бие бүрэлдэхүүнд зэвсэгт хүчний жанжин штаб, ерөнхий зориулалтын болон агаарын довтолгооноос хамгаалах цэргийн командлал, төрөл, мэргэжлийн цэргийн ба ар тал техникийн нэгтгэл, ангиуд, цэргийн сургууль, сургалт эрдэм шинжилгээ, соёл урлаг, эмнэлэг, хэвлэл мэдээлэл, аж ахуй, үйлчилгээний байгууллагуудад цэргийн алба хааж буй болон хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж байгаа хүмүүс багтана.

Сууцны төрөл, цахилгаан, ундны эх үүсвэрийн ангилал ба тодорхойлолт	
Ойлголт	Тодорхойлолт
Гэр	Бүх төрлийн монгол гэр, цаатны урц хамаарна.
Байшин	Байшинд нэг болон олон өрөөтэй, дээвэртэй, гадуураа ханатай, сууринаас дээвэр хүртэл хананаас хуваагдсан талбай бүхий орон байр багтана.
Майхан	Бүх төрлийн майхныг энд хамруулна.
Түр оромж	Анхнаасаа хүн амьдрахад зориулж бариагүй эсвэл хүн амьдрахад засаж тохижуулан өөрчилсөн, хүн амьдарч байгаа түр оромжийг хамруулна.
Нүхэн сууц	Анхнаасаа хүн амьдрахад зориулж бариагүй эсвэл хүн амьдрахад засаж тохижуулан өөрчилсөн, хүн амьдарч байгаа нүхэн сууцыг хамруулна.
Бусад сууц	Дээрх сууцны төрлөөс бусад сууцны төрлийг хамруулна.
Төвлөрсөн систем	Улсын цахилгаан болон усан станцаас цахилгаан хэрэглэж байвал тухайн сууцыг төвлөрсөн системтэй гэж үзнэ. Төвлөрсөн цахилгаан станцад холбогдсон дэд станцыг төвлөрсөн гэж үзнэ.
Дизель станц	Тухайн орон нутгийн хувьд бие даасан дизель станцтай холбогдсон болон цахилгааны сүлжээтэй холбогдсон орон сууцыг хамруулна.
Сэргээгдэх эрчим хүчний төхөөрөмж	Нар, салхины эрчим хүчийг хуримтлуулан цахилгаан эрчим хүч бий болгодог төхөөрөмжийг хамруулна.
Бага оврын цахилгаан үүсгүүр	Тухайн өрх нэг болон хэсэг өрхийн хэрэгцээг хангах зорилгоор шатах болон бусад материалаар ажилладаг бага оврын мотор, цахилгаан үүсгүүрийг хамруулна.
Төвлөрсөн ус түгээх систем	Улсын болон тухайн орон нутгийн усан хангамжийн төвлөрсөн системээс бие даасан тохилог сууц, сууцны тусдаа байшин, орон сууцны байшин, нийтийн эзэмшлийн бусад байранд төвлөрсөн байдлаар ус түгээж байгаа усны системийг хэлнэ.
Төвлөрсөн системд холбогдсон ус түгээх байр	Хот суурин газрын гэр хорооллын төвлөрсөн усан хангамжийн системд холбогдсон ус түгээх байр орно.
Хамгаалагдсан худаг	Зураг төслийн дагуу баригдсан мотор буюу бусад төхөөрөмжөөр усаа шууд авдаг, дээгүүрээ байгууламжтай, эрүүл ахуйн бүс тогтоож хашсан, хамгаалалтанд байдаг, мал амьтан орох боломжгүй худгийг хамруулна. Үүнд өрөмдмөл гүний худаг орно.

Ойлголт	Тодорхойлолт
Хамгаалагдсан булаг, шанд	Тусгай хамгаалалтанд байдаг, засаж тохижуулсан, хашиж хамгаалсан, мал, амьтан орох боломжгүй булаг, шандыг хамгаалагдсан гэж үзнэ.
Цэвэршүүлэн савласан ус	Аж ахуйн нэгжүүд зөвшөөрөл авч, стандартад нийцүүлэн, цэвэршүүлэн савласан ундны зориулалтаар бэлтгэгдсэн усыг хэлнэ.
Төвлөрсөн системд холбогдоогүй ус түгээх байр	Эрх бүхий байгууллага, аж ахуйн нэгжийн зориулалтын авто машинаар ус түгээх байрт зөөвөрлөн түгээдэг байр багтана.
Зөөврийн ус	Эрх бүхий байгууллага, хувийн аж ахуйн нэгж, иргэд хувиараа машин болон ердийн хөсгөөр айл өрхөд шууд зөөвөрлөн түгээдэг бол энд орно.
Гол, мөрөн, нуур, хамгаалагдаагүй худаг, булаг, шанд	Иргэд өөрсдөө ухаж гаргасан, хамгаалалтгүй уурхайн худаг, булаг, шанд орно. Мөн гол, мөрөн, нуур, бороо, цасны болон тогтоол усыг хамруулна.

1.5 СУДАЛГААНЫ АСУУЛГА, ТҮҮНИЙ АГУУЛГА

Судалгааны асуулга нь судалгааны зорилготой шууд уялдаж, бичил уурхай эрхлэгчдийн үйл ажиллагааны онцлог, хэрэглэгчдийн хэрэгцээ, шаардлага зэргийг харгалзаж боловсруулагдсан бөгөөд тэдний өнөөгийн дүр төрхийг харуулж чадахуйц 7 бүлэг, 74 үндсэн үзүүлэлт бүхий маягт, орон нутагт судалгааг зохион байгуулах судлаач нарт зориулсан маягт нөхөх зааврын хамт боловсрогдсон.

Судалгааны асуулгын эхний хувилбарыг боловсруулсны дараа нийслэлийн Налайх дүүрэгт гар аргаар нүүрс олборлодог иргэд, Сэлэнгэ аймгийн Мандал сумын үндсэн ордод алт олборлодог иргэд, Төв аймгийн Заамар сумын шороон ордод алт олборлодог иргэдээс асуулга авч, туршин санал, зөвлөмжийг тусгасан.

Түүнчлэн 21 аймаг, нийслэлийн статистикийн хэлтэс, газар болон Швейцарийн хөгжлийн агентлагийн “Тогтвортой бичил уурхай” төсөл, Эрдэс баялаг, эрчим хүчний яам, Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам зэрэг холбогдох байгууллагын саналыг авч, санал, зөвлөмжийг тусгасан.

Дээрх байгууллага, иргэдийн санал зөвлөмжийг тусган ҮСХ-ны Аргазүйн байнгын зөвлөл болон даргын зөвлөлийн хуралд хэлэлцүүлэн ҮСХ-ны даргын 2012 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн 1/184 тоот тушаалаар эцэслэж батлуулсан.

Судалгааны асуулга нь дараах бүтэцтэй. Үүнд:

Бүлэг 1. Хаягийн хэсэг: Бичил уурхай эрхлэгчдийн байршлын мэдээллийг аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хороо, ашигт малтмалын орд газрын түвшинд цуглуулахуйц 9 асуулт;

Бүлэг 2. Ерөнхий мэдээллийн хэсэг: Судалгаанд хамрагдсан бичил уурхай эрхлэгчдийн засаг, захиргааны үндсэн харьяалал, нас, хүйс, боловсрол, мэргэжил зэрэг ерөнхий мэдээллийг агуулсан 24 асуулт;

Бүлэг 3. Ашигт малтмалын олборлолтоос учирсан хохирол: Бичил уурхай эрхлэх явцад өртөж байсан осол, учирсан хохирлын талаарх 4 асуулт;

Бүлэг 4. Нийгэм, орон нутагт оруулсан хувь нэмэр: Бичил уурхай эрхлэгчдийн хамрагдсан даатгал, түүний төрөл, орон нутагт оруулсан хувь нэмэр зэрэг 3 асуулт;

Бүлэг 5. Тулгарч буй хүндрэл, бэрхшээл: Бичил уурхай эрхлэх явцад тулгарч буй хүндрэл, бэрхшээл, түүнийг хэрхэн шийдвэрлэсэн талаарх 10 асуулт;

Бүлэг 6. Тоног, төхөөрөмж: Бичил уурхайн үйл ажиллагаандаа ашигладаг тоног, төхөөрөмж, хөдөлмөр хамгааллын хувцас хэрэглэдэг эсэхийг багтаасан 4 асуулт;

Бүлэг 7. Үйл ажиллагааны талаарх мэдээлэл: Бичил уурхай эрхлэгчдийн үйл ажиллагаанаас олсон орлого, зарцуулсан зардал, төлсөн татвар, хураамж зэрэг эдийн засгийн холбогдолтой үзүүлэлтийг багтаасан 20 асуултаас бүрдэж байна (маягтыг хавсралт 1-ээс харна уу).

1.6 МЭДЭЭЛЭЛ БОЛОВСРУУЛАЛТ

1.6.1 Мэдээллийг оруулах, бүрдүүлэлтийн үе шат

Судалгааны мэдээллийг компьютерт оруулах, шалгах, засварлах програм хангамжийн бодлогын даалгаврыг ҮСХ-ны МЭЗСГ-ын ажилтнууд, програм хангамжийг МБТГ-ын ажилтнууд боловсруулсан.

Цуглуулсан судалгааны асуулгыг ҮСХ-нд ирүүлэх ажлыг аймаг, нийслэлийн судалгааны ажлын хэсэг хариуцан ажилласан. Судалгааны мэдээллийг компьютерт шивэх ажлыг гэрээт ажилтнуудаар гүйцэтгүүлж, мэдээллийг шалгах, засварлах ажлыг ҮСХ-ны ажлын баг хариуцан ажилласан.

Мэдээллийг компьютерт оруулах програм хангамжийг CSPRO програм хангамжийн тусламжтайгаар боловсруулж, анализ, дүн шинжилгээг статистикийн шинжилгээний SPSS 18.0 програм хангамжийг ашиглаж боловсрууллаа. Судалгаа явуулсан БУС-I маягтын мэдээлэл хадгалах хэсгүүд болон програмд ашиглагдах бүх төрлийн код, утгуудыг агуулсан файл үүсгэж, Microsoft Access програм дээр мэдээллийн санг байгуулсан.

1.6.2 Мэдээллийн алдааг хянах, шалгах үе шат

Судалгааны асуулгад тусгагдсан үзүүлэлт хоорондын уялдаа, тэдгээрийн бүрэн нөхөгдсөн эсэх, шалгалтуудыг хийж, холбогдох засварыг хийсэн. Тухайлбал, хаягийн хэсгийн бүрдэлт, нас, хүйс, регистрийн дугаарын уялдаа, боловсрол, ажил, мэргэжлийн уялдаа, ажил эрхлэлт, орлого, зардал зэрэг үзүүлэлтийг үнэн зөв нөхөгдсөн эсэхийг статистик анализ дээр тулгуурласан хамаарлын болон логик шалгалтуудыг хийж, холбогдох засварыг хийхэд чиглэгдсэн.

1.6.3 Мэдээллийн чанарын үе шат

ҮСХ-ны зүгээс мэдээлэл цуглуулалт, боловсруулалтын үе шат бүрт мэдээллийн чанарт ихээхэн анхаарч ажилласан бөгөөд Архангай, Хөвсгөл, Дархан-Уул аймагт статистикийн хэлтсийн мэргэжилтнүүд орд газруудад баг болж ажилласан. Мөн ҮСХ-ны багийн гишүүд Сэлэнгэ, Төв, Баянхонгор, Хэнтий, Сүхбаатар аймагт судалгааны хамралтыг сайжруулах, орон нутагт дэмжлэг үзүүлэх, мэдээллийн үнэн зөв байдлыг хянах зорилгоор ажилласан.

1.6.4 Орхигдсон утгыг тооцох арга зүй

Судалгааны маягт нь 7 бүлэг 74 үзүүлэлтээс бүрдэж байгаа бөгөөд судалгаанд хамрагдсан зарим иргэдийн хувьд хариулах боломжгүй асуултыг бусад мэдээллийн эх сурвалж, холбогдох хуулийн заалтыг ашиглан орлуулан тооцлоо.

Тухайлбал, бичил уурхай эрхлэгчдийн эрүүл мэндийн даатгалд даатгуулсан, эс даатгуулсан байдлыг Монгол Улсын “Эрүүл мэндийн даатгалын тухай хууль”-д зааснаар эрүүл мэндийн даатгалыг үнэ төлбөргүй авах эрх бүхий этгээд, тэдэнд төлж буй даатгалын мэдээллээр, мөн ОТБТБАҮХЭИ-ийн албан татварыг Монгол Улсын “Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч иргэний орлогын албан татварын тухай хууль”-ийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх заалтын дагуу хянаж, холбогдох засварыг хийв.


Судалгааны хугацаанд иргэдийн хувьд хариулахад хүндрэлтэй байсан асуултын нэг нь олборлолт хийж буй газрын хэмжээ, эвдрэлд орсон талбайн хэмжээ, нөхөн сэргээлт хийсэн талбайн хэмжээ байсан бөгөөд үүнийг судалгаа явагдсан сум, дүүргийн Засаг даргаар сум, дүүргийн хэмжээнд орд, газраар “БУС 1-1г” маягтаар цуглуулан холбогдох тооцооллыг хийлээ.

1.6.5 Үр дүнгийн хүснэгт бэлтгэсэн тухай

Судалгааны үр дүнгийн 100 гаруй хүснэгтийг боловсруулж гаргав. Үр дүнгийн хүснэгтийг эцэслэхийн өмнө үр дүнг “Ашигт малтмалын газар”-ын бичил уурхай эрхлэгчдийн холбогдох мэдээлэл, Монгол Улсын эрдэнэсийн санд худалдсан алтны мэдээ, Стандартчилал хэмжил зүйн газрын Улсын сорьцын хяналтын хэлтсийн лабораториар сорьц тогтоолгосон алтны мэдээ, Татварын ерөнхий газрын бичил уурхай эрхлэгч иргэдийн төлсөн татварын мэдээ, ҮСХ-ны нийгэм, эдийн засгийн судалгааны үр дүнгээс, Улаанбаатар хотын иргэдийн нүүрсний хэрэглээ, ажиллах хүч, хөдөлмөр эрхлэлтийн албан ёсны статистик мэдээллийн эх үүсвэрүүдтэй тулгаж шалгасан.

Судалгааны үр дүнгийн хүснэгтэнд үндэслэн нэгдсэн тайланг бэлтгэж, ажлын хэсгийн хуралд танилцуулж, хэлэлцүүлснээр холбогдох шийдвэрийг гаргуулав. Судалгааны мэдээлэлд дүн шинжилгээ хийх, тайлан бичих ажлыг ҮСХ-ны Макро эдийн засгийн статистикийн газар гүйцэтгэсэн ба мэдээлэлд дүн шинжилгээ хийх, тайлан бичих ажлыг дараах үе шатаар явуулсан.

ЗУРАГ 1.1. СУДАЛГААНЫ МЭДЭЭЛЭЛ ЦУГЛУУЛАХ БОЛОН
БОЛОВСРУУЛАХ АЖЛЫН СХЕМ



ХОЁРДУГААР БҮЛЭГ


БИЧИЛ УУРХАЙ ЭРХЛЭГЧДИЙН
ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

БИЧИЛ УУРХАЙ ЭРХЛЭГЧДИЙН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

2.1. БИЧИЛ УУРХАЙ ЭРХЛЭГЧИД, АЙМАГ, НИЙСЛЭЛЭЭР

Бичил уурхай эрхлэгчдийн судалгаанд нийт 13.4 мянган иргэн хамрагдаж, тэдгээрийн 14.4 хувь нь нөхөрлөлийн ахлагч буюу гишүүн, 14.7 хувь нь бичил уурхайн туслах үйл ажиллагаа эрхлэгч, 20.3 хувь нь гэр бүлийн бизнест цалин хөлсгүй оролцогч, 50.6 хувь нь хувиараа/дангаараа ашигт малтмал олборлогч иргэн байна.

ЗУРАГ 2.1. БИЧИЛ УУРХАЙ ЭРХЛЭГЧДИЙН ТОО, ажил эрхлэлтийн төрлөөр



Аймаг, нийслэлийн нутаг дэвсгэрийн хэмжээ харилцан адилгүйн зэрэгцээ газар зүйн янз бүрийн бүсэд оршдог, байгалийн баялаг нь орон нутагт жигд бус тархсан, уур амьсгал эрс тэс ялгаатай байдлаас хамааран аймаг, нийслэлийн хүн ам, тэр дундаа бичил уурхай эрхлэгчдийн төвлөрөл, үйл ажиллагааны хөгжлийн түвшин харилцан адилгүй байна.

Бичил уурхай эрхлэгчдийн судалгаанд нийт 13.4 мянган иргэн хамрагдаж, үүний 3.4 мянга буюу 25.3 хувь нь баруун бүсэд, 4.0 мянга буюу 29.7 хувь нь хангайн бүсэд, 4.4 мянга буюу 32.9 хувь нь төвийн бүсэд, 0.4 мянга буюу 2.7 хувь нь зүүн бүсэд, 1.3 мянга буюу 9.4 хувь нь Улаанбаатар хотод байршилтай байна.


Бичил уурхай эрхлэгчид Орхон аймгаас бусад 20 аймаг, нийслэлийн 1 дүүрэгт үйл ажиллагаа явуулж байгаагийн 1926 буюу 14.4 хувь нь Баянхонгор аймагт, 1750 буюу 13.1 хувь нь Төв аймагт, 1705 буюу 12.7 хувь нь Увс аймагт, 1260 буюу 9.4 хувь нь Налайх дүүрэгт, 1254 буюу 9.4 хувь нь Сэлэнгэ аймагт, 1059 буюу 7.9 хувь нь Хөвсгөл аймагт үйл ажиллагаагаа явуулж байгаа нь нийт судалгаанд хамрагдсан иргэдийн 66.9 хувийг эзэлж, үлдсэн 33.1 хувь нь бусад 15 аймагт байна.

ХҮСНЭГТ 2.1. БИЧИЛ УУРХАЙ ЭРХЛЭГЧДИЙН ТОО, бүсээр, хувиар

Бүс	Бичил уурхай эрхлэгчид		Судалгаанд хамрагдсан сум, дүүргийн тоо
	тоо	%	
БҮГД	13 375	100.0	77
Баруун бүс	3 380	25.3	28
Хангайн бүс	3 967	29.7	13
Төвийн бүс	4 403	32.9	26
Зүүн бүс	365	2.7	9
Улаанбаатар	1 260	9.4	1

Бичил уурхай эрхлэгчдийн тоог манай улсын нутаг дэвсгэрийн байршлаар нь авч үзвэл дараах дүр зураг харагдаж байна.

ЗУРАГ 2.2. БИЧИЛ УУРХАЙ ЭРХЛЭГЧДИЙН ТОО, аймаг, нийслэл, бичил уурхай эрхлэгчдийн тооны бүлгээр




Энэ удаагийн судалгаанд 20 аймгийн 76 сум, нийслэлийн 1 дүүргийн ашигт малтмалын илрэл бүхий 238 орд, газарт үйл ажиллагаа явуулж байгаа иргэдийг хамруулав.

Ашигт малтмалын илрэл бүхий нийт 238 орд, газарт бичил уурхайн үйл ажиллагаа явагдаж байгаагийн 181 буюу 76.1 хувь нь 8 аймагт байршиж, тэдгээрийн 44 нь Төв аймагт; 33 нь Говь-Алтай аймагт; 25 нь Дорноговь аймагт; 20 нь Хэнтий аймагт; 17 нь Ховд аймагт; Сэлэнгэ, Өмнөговь аймагт тус бүр 16 нь; 10 нь Увс аймагт байна.

Ашигт малтмалын орд олонтой дээрх 8 аймгийн 7.0 мянган бичил уурхай эрхлэгчдийн 1.8 мянга буюу 25.0 хувь нь Төв аймагт; 1.7 мянга буюу 24.4 хувь нь Увс аймагт; 1.3 мянга буюу 17.9 хувь нь Сэлэнгэ аймагт; 0.8 мянга буюу 10.7 хувь нь Говь-Алтай аймагт; 0.6 мянга буюу 9.0 хувь нь Ховд аймагт; үлдсэн 0.9 мянга буюу 13.0 хувь нь Дорноговь, Өмнөговь, Хэнтий аймагт байна.


Нэгж орд газарт ногдох бичил уурхай эрхлэгчдийн тоог аймаг, нийслэлээр авч үзвэл Улаанбаатар хотод 420, Баянхонгор аймагт 321, Хөвсгөл аймагт 212, Увс аймагт 171, Дархан-Уул аймагт 148, Өвөрхангай аймагт 108, Сэлэнгэ аймагт 78, Дундговь аймагт 52, Говьсүмбэр аймагт 52 ногдож байна. Харин Өмнөговь аймагт 11, Дорнод аймагт 12, Хэнтий аймагт 14 ногдож, нэгж орд газарт ногдох бичил уурхай эрхлэгчдийн тоогоор нягтаршил багатайд орж байна.

ЗУРАГ 2.3. БИЧИЛ УУРХАЙ ЭРХЛЭГЧДИЙН ТОО, ОРД ГАЗРЫН ТОО, аймаг, нийслэлээр



Бичил уурхай эрхлэгчдийн тоогоор уул уурхайн салбарын голлох нэр төрлийн бүтээгдэхүүн болох алт, нүүрсний илрэл бүхий орд газар ихтэй Баянхонгор, Төв, Увс, Улаанбаатар, Сэлэнгэ, Хөвсгөл зэрэг аймгууд тэргүүлж байна. Харин жонш, гянтболд зэрэг ашигт малтмалын илрэл бүхий орд газартай зүүн бүсийн аймгууд доогуур байранд орж байна. Эндээс харахад бичил уурхай эрхлэгчдийн төвлөрөл нь ашигт малтмалын төрлөөс шууд хамааралтай хандлага харагдаж байна.

ЗУРАГ 2.4. БИЧИЛ УУРХАЙД АШИГЛАГДАЖ БУЙ ОРД ГАЗРЫН БАЙРШИЛ, ашигт малтмалын төрөл, аймаг, нийслэлээр



2.2. БИЧИЛ УУРХАЙ ЭРХЛЭГЧИД, АШИГТ МАЛТМАЛЫН ТӨРЛӨӨР

Бичил уурхай эрхлэгчдийн судалгаагаар ашигт малтмалыг алт, нүүрс, жонш, гянтболд, цагаан тугалга, шохойн чулуу, үнэт чулуу, давс гэсэн 8 төрлөөр судаллаа.

Судалгаанд хамрагдсан 13.4 мянган бичил уурхай эрхлэгчдийн 10.5 мянга буюу 78.2 хувь нь алт, 1.4 мянга буюу 10.2 хувь нь нүүрс, 1.0 мянга буюу 7.6 хувь нь жонш, 0.3 мянга буюу 2.3 хувь нь гянтболд, 47 буюу 0.4 хувь нь цагаан тугалга, 10 буюу 0.1 хувь нь шохойн чулуу, 0.1 мянга буюу 1.0 хувь нь үнэт чулуу, 49 буюу 0.4 хувь нь давс олборлож байна.

ХҮСНЭГТ 2.2. БИЧИЛ УУРХАЙ ЭРХЛЭГЧДИЙН ТОО, бүсээр, ашигт малтмалын төрлөөр

Бүс	БҮГД	Ашигт малтмалын төрөл							
		Алт	Нүүрс	Жонш	Гянт-болд	Цагаан тугалга	Шохойн чулуу	Үнэт чулуу	Давс
БҮГД	13 375 10 458	1 368	1 010	305	47	10	128	49	
Баруун бүс	3 380	2 946	108	-	270	-	10	-	46
Хангайн бүс	3 967	3 899	-	-	-	-	-	68	-
Төвийн бүс	4 403	3 557	-	786	-	-	-	60	-
Зүүн бүс	365	56	-	224	35	47	-	-	3
Улаанбаатар	1 260	-	1 260	-	-	-	-	-	-

Алт олборлолт:

Судалгаанд хамрагдсан алт олборлогчид 2011 онд нийт 354.6 кг алт олборлож, нэг гр-ийг дунджаар 52.9 мянган төгрөгөөр борлуулсан байна.

Алт олборлох үйл ажиллагаанд оролцогч нийт 10.5 мянган иргэний 75.8 хувь нь хувиараа/дангаараа алт олборлогч буюу гэр бүлийнхээ алт олборлолтын үйл ажиллагаанд оролцогч, үлдсэн 24.2 хувь нь нөхөрлөлийн зохион байгуулалтанд орсон нөхөрлөлийн ахлагч/гишүүн, бичил уурхайн туслах үйл ажиллагаа эрхлэгч байна.


Судалгаанд хамрагдсан 20 аймгийн 17 аймагт бичил уурхайн алт олборлолтын үйл ажиллагаа явагдаж, нийт алт олборлогчдын 1.9 мянга буюу 18.4 хувь нь Баянхонгор аймагт, 1.8 мянга буюу 16.7 хувь нь Төв, 1.6 мянга буюу 15.2 хувь нь Увс, 1.3 мянга буюу 12.0 хувь нь Сэлэнгэ, 1.0 мянга буюу 9.5 хувь нь Хөвсгөл, 0.7 мянга буюу 6.9 хувь нь Говь-Алтай, үлдсэн 2.2 мянга буюу 21.3 хувь нь Өвөрхангай, Ховд, Дархан-Уул, Булган, Өмнөговь, Архангай, Дорноговь, Дорнод, Завхан, Баян-Өлгий, Дундговь аймгуудад байна. Харин Сүхбаатар, Хэнтий, Говьсүмбэр аймгуудад болон нийслэл Улаанбаатарт алтны орд, газар байдаггүйтэй холбоотойгоор алт олборлодог иргэд байхгүй байна.

ХҮСНЭГТ 2.3. БИЧИЛ УУРХАЙ ЭРХЛЭГЧДИЙН ТОО, ОЛБОРЛОСОН АЛТНЫ ХЭМЖЭЭ, бүсээр

Бүс	Алт олборлогчид		Олборлосон алт	
	тоо	%	хэмжээ, кг	%
БҮГД	10 458	100.0	354.6	100.0
Баруун бүс	2 946	28.2	71.7	20.2
Хангайн бүс	3 899	37.3	139.6	39.4
Төвийн бүс	3 557	34.0	141.9	40.0
Зүүн бүс	56	0.5	1.4	0.4

Алт олборлох үйл ажиллагаанд оролцогч бичил уурхайчдын 80.0 орчим хувь нь 5-10 дугаар саруудад үйл ажиллагаагаа явуулж байна. Бичил уурхай эрхлэгчдийн борлуулсан алтны дундаж үнийг улсын дундажтай харьцуулан, аймгаар авч үзвэл, Булган аймагт 11.7 мянган төгрөг, Өвөрхангай аймагт 17.3 мянган төгрөгөөр илүү, Архангай аймагт хамгийн хямд буюу 12.4 мянган төгрөгөөр бага байна.

ЗУРАГ 2.5. БИЧИЛ УУРХАЙ ЭРХЛЭГЧДИЙН БОРЛУУЛСАН НЭГ ГР АЛТНЫ ДУНДАЖ ҮНЭ, аймаг, нийслэлээр, мян.төг



Нүүрс олборлолт:

Судалгаанд хамрагдсан бичил уурхай эрхлэгчид 2011 онд нийт 142.0 мян.тн нүүрс олборлож, 1тн-ыг дунджаар 22.0 мянган төгрөгөөр борлуулсан байна.

Нүүрс олборлож байгаа бичил уурхай эрхлэгчдийн 93.8 хувь нь 10-аас 3-р саруудад үйл ажиллагаагаа явуулж байна.

Нүүрс олборлох үйл ажиллагаанд оролцогч нийт 1.4 мянган иргэдийн 51.8 хувь нь хувиараа/дангаараа нүүрс олборлогч, 45.8 хувь нь бичил уурхайн туслах үйл ажиллагаа эрхлэгч, үлдсэн 2.3 хувь нь гэр бүлийн бизнест цалин хөлсгүй оролцогч байна.

Нийт нүүрс олборлох үйл ажиллагаанд оролцогч 1.4 мянган иргэний 1.3 мянга буюу 92.1 хувь нь нийслэлийн Налайх дүүрэгт, 74 буюу 5.4 хувь нь Увс аймагт, 29 буюу 2.1 хувь нь Говь-Алтай аймагт, 5 буюу 0.4 хувь нь Баян-Өлгий аймагт байна. Харин бусад аймагт нүүрс олборлолтын чиглэлээр бичил уурхайн үйл ажиллагаа явагдахгүй байгаа болно.

Бичил уурхай эрхлэгчдийн борлуулсан нүүрсний дундаж үнийг улсын дундажтай харьцуулж үзвэл, Баян-Өлгий аймагт 60.2, Увс аймагт 37.9, Говь-Алтай аймагт 13.3 мянган төгрөгөөр илүү, харин Налайх дүүрэгт 0.3 мянган төгрөгөөр хямд байна.

ХҮСНЭГТ 2.4. БИЧИЛ УУРХАЙ ЭРХЛЭГЧДИЙН ТОО, ОЛБОРЛОСОН НҮҮРСНИЙ ХЭМЖЭЭ, НЭГ ТН НҮҮРСНИЙ ДУНДАЖ ҮНЭ, аймаг, дүүргээр

Аймаг, дүүрэг	Нүүрс олборлогчид		Олборлосон нүүрс		1 тн нүүрсний дундаж үнэ, мян.төг
	тоо	%	хэмжээ, мян.тн	%	
БҮГД	1 368	100.0	142.0	100.0	22.0
Баян-Өлгий	5	0.4	0.1	0.0	82.2
Говь-Алтай	29	2.1	0.9	0.6	35.3
Увс	74	5.4	0.8	0.6	59.9
Налайх	1 260	92.1	140.2	98.8	21.7

Жонш олборлолт:

Жонш олборлох үйл ажиллагаанд оролцогч 1.0 мянган иргэн судалгаанд хамрагдсан бөгөөд 2011 онд нийт 38.5 мян.тн жонш олборлож, тэдгээрийн 0.4 мянга нь буюу 40.2 хувь нь Дундговь аймагт, 0.3 мянга буюу 32.5 хувь нь Дорноговь аймагт, 0.2 мянга нь буюу 22.2 хувь нь Хэнтий аймагт, 0.1 мянга нь буюу 5.1 хувь нь Говьсүмбэр аймагт байна. Хэдийгээр Говьсүмбэр аймагт жоншны орд байхгүй хэдий ч бусад аймагт олборлосон жоншийг хагалж, бэлтгэдэг туслах чанарын үйл ажиллагаа эрхлэгч бичил уурхайчид байдаг байна.

Жонш олборлох чиглэлээр бичил уурхай эрхлэгчид нь 2011 онд 1 тн жоншийг дунджаар 54.0 мянган төгрөгөөр борлуулсан байна.

ХҮСНЭГТ 2.5. БИЧИЛ УУРХАЙ ЭРХЛЭГЧДИЙН ТОО, ОЛБОРЛОСОН ЖОНШНЫ ХЭМЖЭЭ, НЭГ ТН ЖОНШНЫ ДУНДАЖ ҮНЭ, аймгаар

Аймаг	Жонш олборлогчид		Олборлосон жонш		1 тн жоншны дундаж үнэ, мян.төг
	тоо	%	хэмжээ, мян.тн	%	
БҮГД	1 010	100.0	38.5	100.0	54.0
Говьсүмбэр	52	5.1	-	-	-
Дорноговь	328	32.5	21.4	55.7	46.4
Дундговь	406	40.2	8.0	20.8	63.7
Хэнтий	224	22.2	9.1	23.5	63.4

Гянтболд олборлолт:

Гянтболд олборлох үйл ажиллагаанд оролцогч 305 иргэн бичил уурхай эрхлэгчдийн судалгаанд хамрагдсаны 213 нь буюу 69.8 хувь, нийт олборлосон гянтболдын 87.8 хувь нь Баян-Өлгий аймагт байна. Харин гянтболд олборлогчдын 92 буюу 30.2 хувь, олборлосон гянтболдын 12.2 хувь нь Ховд, Сүхбаатар аймагт байна.

Бичил уурхай эрхлэгчид нь олборлосон гянтболдоо нэг кг-ийг нь дунджаар 9.3 мянган төгрөгөөр зах зээлд борлуулдаг байна.

ХҮСНЭГТ 2.6. БИЧИЛ УУРХАЙ ЭРХЛЭГЧДИЙН ТОО, ОЛБОРЛОСОН ГЯНТБОЛДЫН ХЭМЖЭЭ, НЭГ КГ ГЯНТБОЛДЫН ДУНДАЖ ҮНЭ, аймгаар

Аймаг	Гянтболд олборлогчид		Олборлосон гянтболд		1 кг гянтболдын дундаж үнэ, мян.төг
	тоо	%	хэмжээ, тн	%	
БҮГД	305	100.0	108.3	100.0	9.3
Баян-Өлгий	213	69.8	95.0	87.8	9.7
Ховд	57	18.7	10.4	9.6	6.4
Сүхбаатар	35	11.5	2.8	2.6	5.9

Бусад төрлийн ашигт малтмал:

Судалгаанд хамрагдсан 13.4 мянган бичил уурхай эрхлэгчдийн 0.2 мянга буюу 1.7 хувь нь цагаан тугалга, шохойн чулуу, үнэт чулуу, давс олборлодог байна.

ХҮСНЭГТ 2.7. БИЧИЛ УУРХАЙ ЭРХЛЭГЧДИЙН ТОО, аймаг, ашигт малтмалын төрлөөр

Аймаг	БҮГД		Ашигт малтмалын төрөл							
			Цагаан тугалга		Шохойн чулуу		Үнэт чулуу		Давс	
	тоо	%	тоо	%	тоо	%	тоо	%	тоо	%
БҮГД	234	100.0	47	100.0	10	100.0	128	100.0	49	100.0
Баян-Өлгий	10	4.3	-	-	10	100.0	-	-	-	-
Увс	46	19.7	-	-	-	-	-	-	46	93.9
Хөвсгөл	68	29.1	-	-	-	-	68	53.1	-	-
Дорноговь	60	25.6	-	-	-	-	60	46.9	-	-
Дорнод	3	1.3	-	-	-	-	-	-	3	6.1
Хэнтий	47	20.1	47	100.0	-	-	-	-	-	-

Бичил уурхай эрхлэгчид нь 2011 онд 66.6 тн шохойн чулуу олборлож, дунджаар 1 тн-ыг 408.1 мянган төгрөгөөр, 5.5 тн цагаан тугалга олборлож, дунджаар 1 кг-ыг 10.6 мянган төгрөгөөр, 14.7 тн үнэт чулуу олборлож, дунджаар 1 кг-ыг 21.5 мянган төгрөгөөр, 1062.3 тн давс олборлож, дунджаар 1 тн-ыг 37.4 мянган төгрөгөөр борлуулсан байна.

2.3. БИЧИЛ УУРХАЙ ЭРХЛЭГЧДИЙН ТОО, ЗАСАГ ЗАХИРГААНЫ НЭГЖЭЭР

Бичил уурхай эрхлэгчдийг засаг захиргааны харьяаллаар авч үзвэл Дорнод, Дундговь, Булган аймгуудад үйл ажиллагаа явуулж буй иргэд тухайн нутгийн харьяат иргэд байж, харин Сэлэнгэ, Говьсүмбэр, Ховд, Сүхбаатар, Дархан-Уул, Өвөрхангай, Хөвсгөл, Увс, Баянхонгор, Архангай, Баян-Өлгий, Говь-Алтай аймгуудад үйл ажиллагаа явуулж байгаа бичил уурхай эрхлэгчдийн 90.0-99.7 хувь нь тухайн нутгийн харьяат, Завхан, Төв, Дорноговь, Хэнтий, Өмнөговь аймаг, Налайх дүүрэгт үйл ажиллагаа явуулж байгаа бичил уурхай эрхлэгчдийн 60.0-88.9 хувь нь тухайн үйл ажиллагаа явуулж байгаа аймгийнхаа харьяат иргэд байна.

ХҮСНЭГТ 2.8. БИЧИЛ УУРХАЙ ЭРХЛЭГЧДИЙН ТОО, аймаг, нийслэл, засаг захиргааны харьяаллаар

Аймаг, нийслэл	БҮГД	Засаг, захиргааны харьяалал																					
		АР	БӨ	БХ	БУ	ГА	ДО	ДД	ДУ	ЗА	ӨВ	ӨМ	СҮ	СЭ	ТӨ	УВ	ХО	ХӨ	ХЭ	ДА	УБ	ОР	ГС
	13 375	155	255	1 936	275	783	363	69	433	46	666	158	46	1 176	1 382	1 692	630	1 083	229	351	1 418	151	78
АР	120	119		1																			
БӨ	253		251			1								1									
БХ	1 926	3		1 902										2	5					1	11	2	
БУ	216				216																		
ГА	751					749				2													
ДО	461	1		1			357		7		16		7				1	7	4	4	25	8	23
ДД	59							59															
ДУ	416								416														
ЗА	40					15				24												1	
ӨВ	646			3		1			1		630	1		2	1						6	1	
ӨМ	175			18								153		1								3	
СҮ	35												34									1	
СЭ	1 254	2		2	8				1		1	3		1 135	7					35	41	19	
ТӨ	1 750	16			46		1	2	3	16	11	1		26	1 336		1	25	3	16	145	102	
УВ	1 705				1												1 681	8			11	4	
ХО	631			1		12											3	612			3		
ХӨ	1 059			5	1													1 038			7	8	
ХЭ	271						3	2				4	1					3	213		42		3
ДА	295										2			1						287	3	2	
УБ	1 260	14	4	3	3	5	2	6	2	4	2		4	8	32	8	8	10	9	8	1 120	4	4
ГС	52								3						1								48

Бичил уурхай эрхлэгчид нь бие дааж дангаараа, эсвэл гэр бүлийн гишүүд, ах, эгч, хамаатан садан, найз нөхдөөрөө хамтран, эсвэл гаднаас ажилтан хөлслөн нөхөрлөлийн зарчмаар үйл ажиллагаа явуулдаг байна.

Ийм төрлийн үйл ажиллагаа эрхэлдэг иргэд, ялангуяа алт олборлогч иргэдийн үйл ажиллагааны онцлог нь ашигт малтмалын олдцоос шалтгаалан үйл ажиллагаа явуулдаг газрынхаа байршлыг байнга өөрчилдөг нь харагдаж байна.


2.4. БИЧИЛ УУРХАЙ ЭРХЛЭГЧДИЙН ТОО, НАС, ХҮЙСИЙН БҮТЭЦ, АМ БҮЛИЙН ТОО

Бичил уурхай эрхлэгчдийн тоо, нас, хүйсийн бүтэц:

Бичил уурхай эрхлэгчдийг насны бүлгээр авч үзвэл, 1.8 хувь нь 10-14 насных, 5.2 хувь нь 15-19 насных, 89.3 хувь нь 20-54 насных, үлдсэн 3.7 хувь нь 55 ба түүнээс дээш насны иргэд, харин бичил уурхай эрхлэгчдийн дундаж нас 35 байна.

Эндээс харахад нийт бичил уурхай эрхлэгчдийн дийлэнх нь эдийн засгийн идэвхтэй хүн ам буюу 20-54 насных байгаа нь орон нутагт ажлын байр хомс байгааг харуулж байна.

ЗУРАГ 2.6. БИЧИЛ УУРХАЙ ЭРХЛЭГЧДИЙН ТОО, насны бүлгээр



Бичил уурхай эрхлэгчдийн 70.7 хувь нь эрэгтэй, 29.3 хувь эмэгтэй, хүйсийн харьцаа 100 эмэгтэй тутамд 242 эрэгтэй ногдож байна. Харин уг үзүүлэлтийг насны бүлгээр авч үзвэл, нас ахих тутам мэдэгдэхүйцээр нэмэгдэж, 30 наснаас эхлэн дахин буурч байснаа 55 наснаас нэмэгдэж байна. Харин 10-14 насны хүүхдүүдийн хувьд харьцангуй тэнцвэртэй байна.

Бичил уурхай эрхлэгчдийн хүйс, насны бүлгээрх дэлгэрэнгүй үзүүлэлтийг дараах хүснэгтэд харуулав.


ХҮСНЭГТ 2.9. БИЧИЛ УУРХАЙ ЭРХЛЭГЧДИЙН ТОО, насны бүлэг, хүйс, хүйсийн харьцаагаар

Насны бүлэг	БҮГД		Хүйс				Хүйсийн харьцаа
			Эрэгтэй		Эмэгтэй		
	тоо	%	тоо	%	тоо	%	
БҮГД	13 375	100.0	9 460	70.7	3 915	29.3	241.6
10-14	236	1.8	125	53.0	111	47.0	112.6
15-17	329	2.5	227	69.0	102	31.0	222.5
18-19	363	2.7	255	70.2	108	29.8	236.1
20-24	1 765	13.2	1 346	76.3	419	23.7	321.2
25-29	2 011	15.0	1 536	76.4	475	23.6	323.4
30-34	2 090	15.6	1 530	73.2	560	26.8	273.2
35-39	2 013	15.1	1 411	70.1	602	29.9	234.4
40-44	1 787	13.4	1 171	65.5	616	34.5	190.1
45-49	1 439	10.8	948	65.9	491	34.1	193.1
50-54	844	6.3	553	65.5	291	34.5	190.0
55-59	355	2.7	255	71.8	100	28.2	255.0
60-64	94	0.7	72	76.6	22	23.4	327.3
65-69	37	0.3	23	62.2	14	37.8	164.3
70 +	12	0.1	8	66.7	4	33.3	200.0

Дээрх хүснэгтээс харахад 20-29, 55-64 насны бичил уурхай эрхлэгч иргэдийн дийлэнх нь эрэгтэй байгаа хэдий ч хөдөлмөрийн насны иргэдийн хувьд 100 эмэгтэйд насны бусад бүлэгтэй харьцуулахад бага тооны эрэгтэй ногдож байна.


Улсын хэмжээнд 70 ба түүнээс дээш насны 12 иргэн бичил уурхайн үйл ажиллагаа эрхэлж, тэдний 7 нь Төвийн бүсэд, 5 нь Баруун, Хангай, Зүүн бүсэд байна.

ЗУРАГ 2.7. БИЧИЛ УУРХАЙ ЭРХЛЭГЧДИЙН ТОО, насны бүлэг, хүйсээр



Бичил уурхай эрхлэгчдийн тоог ижил интервалтай насны бүлгээр авч үзвэл эрэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлт бүх насны бүлэгт эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтээс илүү байгаа нь эрэгтэйчүүд бичил уурхайн үйл ажиллагаанд илүү давамгайл байдлаар оролцдог болохыг дараах нас, хүйсийн суварга харуулж байна.

ЗУРАГ 2.8. БИЧИЛ УУРХАЙ ЭРХЛЭГЧДИЙН НАС, ХҮЙСИЙН СУВАРГА, насны бүлгээр




Бичил уурхай эрхлэгчид, ам бүлийн тоо:

Энд бичил уурхай эрхлэгчдийн ам бүлийн тоо, түүнээс бичил уурхайд ажиллаж байгаа гишүүдийнх нь тоог авч үзлээ.

Нийт судалгаанд хамрагдсан 13.4 мянган бичил уурхай эрхлэгчдийн 73.5 хувь нь 2-5 ам бүлтэй, 21.7 хувь нь 6-9 ам бүлтэй, 4.1 хувь нь 1 ам бүлтэй, 0.7 хувь нь 10 ба түүнээс дээш ам бүлтэй, ам бүлийн дундаж тоо 4 байна.

ЗУРАГ 2.9. БИЧИЛ УУРХАЙ ЭРХЛЭГЧДИЙН ТОО, ам бүлийн тооны бүлгээр



Нийт бичил уурхай эрхлэгчдийн ам бүлийн тоог бүсээр авч үзвэл 61.6-79.5 хувь нь 2-5 ам бүлтэй байна. Ам бүлийн дундаж тоо баруун бүсэд хамгийн өндөр байгаа бөгөөд улсын дунджаас нэг хүнээр илүү байна. Үүнд, ам бүлийн дундаж тоо өндөр байдаг Баян-Өлгий, Ховд, Увс аймгууд баруун бүсэд хамаардагтай холбоотой нь байна.

ХҮСНЭГТ 2.10. БИЧИЛ УУРХАЙ ЭРХЛЭГЧДИЙН АМ БҮЛИЙН ТОО, хувиар

Бүс	БҮГД	Ам бүлийн тооны бүлэг				Ам бүлийн дундаж тоо
		1 ам бүлтэй	2-5	6-9	10 ба түүнээс дээш	
БҮГД	100.0	4.1	73.5	21.7	0.7	4
Баруун бүс	100.0	1.7	61.6	36.2	0.5	5
Хангайн бүс	100.0	4.2	75.5	19.4	0.9	4
Төвийн бүс	100.0	5.0	79.5	14.7	0.7	4
Зүүн бүс	100.0	9.3	75.3	15.1	0.3	4
Улаанбаатар	100.0	5.3	77.8	16.6	0.3	4

Өрхийн ам бүлийн гишүүдээс бичил уурхайд ажиллаж байгаа өрхийн гишүүдийн тоог авч үзвэл, 2-5 ам бүлтэй өрхийн гишүүдийн 42.2 хувь нь, 6-9 ам бүлтэй өрхийн 38.8 хувь нь, 10 ба түүнээс дээш ам бүлтэй өрхийн 30.4 хувь нь бичил уурхайн үйл ажиллагаа эрхэлж байна.

2.5. БИЧИЛ УУРХАЙ ЭРХЛЭГЧДИЙН ТОО, БОЛОВСРОЛЫН ТҮВШИНГЭЭР

Хүн амын хөдөлмөр эрхлэлт, орлогын түвшин, нийгэм, эдийн засгийн үзүүлэлтүүд нь боловсролын түвшингээс ихээхэн хамаардаг бөгөөд судалгаанд хамрагдсан бичил уурхай эрхлэгчдийн 0.6 мянга буюу 4.1 хувь нь боловсролгүй, 1.9 мянга буюу 14.0 хувь нь бага боловсролтой, 3.7 мянга буюу 27.9 хувь нь суурь боловсролтой, 5.4 мянга буюу 40.4 хувь нь бүрэн дунд боловсролтой, 0.9 мянга буюу 6.8 хувь нь техникийн болон мэргэжлийн, 0.4 мянга буюу 2.6 хувь нь тусгай мэргэжлийн дунд, харин 0.6 мянга буюу 4.2 хувь нь дээд мэргэжилтэй байна.

ХҮСНЭГТ 2.11. БИЧИЛ УУРХАЙ ЭРХЛЭГЧДИЙН БОЛОВСРОЛЫН ТҮВШИН, хүйсээр, хувиар

Боловсролын түвшин	БҮГД	Хүйс	
		Эрэгтэй	Эмэгтэй
БҮГД	100.0	100.0	100.0
Боловсролгүй	4.1	4.2	4.0
Боловсролтой	95.9	95.8	96.0
Бага	14.0	14.9	11.7
Суурь	27.9	28.6	26.4
Бүрэн дунд	40.4	39.3	42.8
Техникийн болон мэргэжлийн	6.8	7.3	5.3
Тусгай мэргэжлийн дунд	2.6	2.0	4.3
Дээд	4.2	3.7	5.5

Бичил уурхай эрхлэгчдийн боловсролын түвшинг ажилласан жилээр авч үзвэл, бүрэн дундаас доош боловсролтой иргэдийн 46.9 хувь нь 4 ба түүнээс дээш жил бичил уурхайн үйл ажиллагаа эрхэлсэн байна.

Бичил уурхай эрхлэгчдийн 0.6 мянга буюу 4.2 хувь дээд боловсролтой байгаагийн 0.2 мянга буюу 1.7 хувь нь 1 хүртэлх жил, 0.2 буюу 1.3 хувь нь 2-3 жил, 0.1 мянга буюу 0.6 хувь нь 4-5 жил, 33 буюу 0.2 нь 6-7 жил, 13 буюу 0.1 хувь нь 8-9 жил, 18 буюу 0.1 хувь нь 10-11 жил, 22 буюу 0.2 хувь нь 12 ба түүнээс дээш жил бичил уурхайн үйл ажиллагаа эрхэлсэн байна.

2.6. БИЧИЛ УУРХАЙ ЭРХЛЭГЧДИЙН АЖИЛ ЭРХЛЭЛТ


Бичил уурхай эрхлэгчдийг ажил эрхлэлтийн байдал, ажил, мэргэжлийн ангилал, ажилласан жил, бичил уурхайн үйл ажиллагаанд оролцож буй үүрэг роль, уг үйл ажиллагааг эрхлэх болсон шалтгаан зэрэг үзүүлэлтийг авч судалсан.

Бичил уурхай эрхлэгчдийн ажил эрхлэлт:

Бичил уурхай эрхлэгчдийн судалгаанд нийт 13.4 мянган иргэн хамрагдсаны 50.6 хувь нь бие даан хувиараа/дангаараа ашигт малтмал олборлогч, 20.3 хувь нь гэр бүлийн бизнест цалин хөлсгүй оролцогч, 14.7 хувь нь бичил уурхайн туслах үйл ажиллагаа эрхлэгч, 14.4 хувь нь нөхөрлөлийн зохион байгуулалтад орсон нөхөрлөлийн ахлагч, гишүүд байна.

Нөхөрлөлийн ахлагч, гишүүн: Бичил уурхай эрхлэгчдийн 0.3 мянга буюу 2.2 хувь нь нөхөрлөлийн ахлагч/ажил олгогч, 1.6 мянга буюу 12.2 хувь нь нөхөрлөлийн гишүүн байна. Харин нөхөрлөлийн зохион байгуулалтад орсон иргэдийн 15.3 хувь нь нөхөрлөлийн ахлагч/ажил олгогч, 84.7 хувь нь нөхөрлөлийн гишүүд байна.

ЗУРАГ 2.10. НӨХӨРЛӨЛИЙН АХЛАГЧ, ГИШҮҮНИЙ ТОО, аймаг, нийслэл, төрлөөр




Зохион байгуулалтад орсон нөхөрлөлийн ахлагч/гишүүдийн 70.7 хувь нь алт, 28.0 хувь нь жонш, 1.2 хувь нь үнэт чулуу, үлдсэн 0.1 хувь нь цагаан тугалга, нүүрс болон бусад төрлийн ашигт малтмал олборлож байна. Үүнээс үзэхэд алт олборлогчид нь илүү нөхөрлөл хэлбэрээр хоршоолсон байдлаар хамтран ажиллаж байна.

Нөхөрлөлийн ахлагч, гишүүдийн 76.2 хувь нь эрэгтэй, 23.8 хувь нь эмэгтэй байна. Харин судалгаанд хамрагдсан нөхөрлөлийн ахлагч, гишүүн бичил уурхай эрхлэгчдийн 77.5 хувь нь 20-44 насныхан байна.

Нөхөрлөлийн орлого хуваарилалтын байдлыг авч үзвэл 746 буюу 38.7 хувь нь бичил уурхайгаас олсон орлогоо гишүүддээ тэнцүү хуваарилдаг, 36.7 хувь нь хийснээрээ хуваарилдаг, 24.6 хувь нь орлого хуваарилдаггүй байна. Мөн нөхөрлөлийн ахлагч, гишүүдийн 60.7 хувь нь төрийн бус байгууллагад харьяалагдаж байна.

ЗУРАГ 2.11. НӨХӨРЛӨЛИЙН АХЛАГЧ, ГИШҮҮДИЙН ТОО, орлого хуваарилалтын төрлөөр



Хувиараа/дангаараа ашигт малтмал олборлогч: Хувиараа/дангаараа ашигт малтмал олборлогч 6772 иргэний 5.8 мянга буюу 86.3 хувь нь эрэгтэй, 0.9 мянга буюу 13.7 хувь нь эмэгтэй байна.

Бичил уурхайн туслах үйл ажиллагаа эрхлэгч болон гэр бүлийн бизнест цалин хөлсгүй оролцогч: Нийт 1960 бичил уурхайн туслах үйл ажиллагаа эрхлэгч судалгаанд хамрагдсаны 65.8 хувь нь эрэгтэй, 34.2 хувь нь эмэгтэй, 76.7 хувь нь бүрэн дундаас доош боловсролтой байна. Харин гэр бүлийн бизнест цалин хөлсгүй оролцогчдын ихэнхи нь буюу 68.4 хувь нь эмэгтэй, 90.0 орчим хувь нь бүрэн дундаас доош боловсролтой байна.

Бичил уурхайн туслах үйл ажиллагаа эрхлэгчдийг үйл ажиллагаанд оролцдог үүргээр авч үзвэл, 26.8 хувь нь шороо ухах, ачих зэрэг бичил уурхайн туслах ажил эрхлэх, 24.6 хувь нь тээврийн хэрэгсэлээр үйлчлэх, 17.8 хувь нь хүнс барааны худалдаа эрхлэх, 17.1 хувь нь олборлосон ашигт малтмал худалдан авах, 13.5 хувь нь зоогийн газрын үйл ажиллагаа эрхэлдэг байна.

Бичил уурхай эрхлэгчдийн ажил, мэргэжлийн ангилал:

Судалгаанд хамрагдсан 13.4 мянган бичил уурхай эрхлэгчдийн 8.2 мянга буюу 61.3 хувь нь мэргэжилгүй, 2.0 мянга буюу 14.7 хувь нь машин механизм, төхөөрөмжийн операторч, угсрагч, 0.9 мянга буюу 6.8 хувь нь үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил, үйлчилгээний ажилтан, 0.9 мянга буюу 6.6 хувь нь хөдөө аж ахуй, ой, загас агнуурын мэргэшсэн ажилтан, 0.8 мянга буюу 6.2 хувь нь мэргэжилтэн, 4.4 хувь нь худалдаа, үйлчилгээний ажилтан, техникч болон туслах/дэд мэргэжилтэн, контор, үйлчилгээний, энгийн ажил болон бусад мэргэжилтэй иргэд байна.

Дээрх үзүүлэлтийг бүсээр авч үзвэл мэргэжилгүй иргэдийн 31.0 хувь нь баруун бүсэд, 30.0 хувь нь төвийн бүсэд, 29.6 хувь нь хангайн бүсэд, 6.6 хувь нь Улаанбаатарт, 2.7 хувь нь зүүн бүсэд, харин машин механизм, төхөөрөмжийн операторч, угсрагчийн мэргэжилтэй бичил уурхай эрхлэгчдийн 41.2 хувь нь төвийн бүсэд, 23.4 хувь нь хангайн бүсэд, 18.9 хувь нь Улаанбаатарт, 13.8 хувь нь баруун бүсэд, 2.8 хувь нь зүүн бүсэд байна.

Бичил уурхай эрхлэгчдийн ажил, мэргэжлийн онцлогоос хамаарч эрэгтэй, эмэгтэйчүүдийн ялгаа ажил, мэргэжлийн ангилал бүрт өөр өөр байгаа нь ажиглагдаж байна.

ХҮСНЭГТ 2.12. БИЧИЛ УУРХАЙ ЭРХЛЭГЧИД, ажил, мэргэжил, хүйсээр, хувиар

Ажил, мэргэжлийн бүлэг	БҮГД	Хүйс		Нийт тоонд эзлэх хувь			Ажил, мэргэжлийн дүнд эзлэх хувь		
		Эрэгтэй	Эмэгтэй	Дүн	Эрэгтэй	Эмэгтэй	Дүн	Эрэгтэй	Эмэгтэй
Дүн	13 375	9 460	3 915	100.0	100.0	100.0	100.0	70.7	29.3
Зэвсэгт хүчний ажил, мэргэжил	3	3	-	0.0	0.0	-	100.0	100.0	-
Менежер	10	7	3	0.1	0.1	0.1	100.0	70.0	30.0
Мэргэжилтэн	832	487	345	6.2	5.1	8.8	100.0	58.5	41.5
Техникч болон туслах/дэд мэргэжилтэн	86	55	31	0.6	0.6	0.8	100.0	64.0	36.0
Контор, үйлчилгээний ажилтан	45	17	28	0.3	0.2	0.7	100.0	37.8	62.2
Худалдаа, үйлчилгээний ажилтан	395	46	349	3.0	0.5	8.9	100.0	11.6	88.4
Хөдөө аж ахуй, ой, загас агнуурын мэргэшсэн ажилтан	883	579	304	6.6	6.1	7.8	100.0	65.6	34.4
Үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил, үйлчилгээний	907	654	253	6.8	6.9	6.5	100.0	72.1	27.9
Машин механизм, төхөөрөмжийн операторч, угсрагч	1 961	1 877	84	14.7	19.8	2.1	100.0	95.7	4.3
Энгийн ажил, мэргэжил	56	51	5	0.4	0.5	0.1	100.0	91.1	8.9
Мэргэжилгүй	8 197	5 684	2 513	61.3	60.1	64.2	100.0	69.3	30.7


Бичил уурхайн үйл ажиллагаа эрхлэгчдийн ажил, мэргэжлийг боловсролын түвшингээр авч үзвэл үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил, үйлчилгээний, хөдөө аж ахуй, ой, загас агнуурын мэргэшсэн ажилтан, машин механизм, төхөөрөмжийн операторч, угсрагч, худалдаа, үйлчилгээний ажилтан, энгийн ажил, мэргэжил болон мэргэжилгүй иргэдийн 59.7-96.5 хувь нь бүрэн дундаас доош боловсролтой байна.

Бичил уурхайн үйл ажиллагаа эрхэлсэн жил:

Бичил уурхайн судалгаанд хамрагдсан 13.4 мянган бичил уурхай эрхлэгчдийн 2.9 мянга буюу 22.0 хувь нь нэг хүртэлх жил, 4.2 мянга буюу 31.8 хувь нь 2-3 жил, 2.6 мянга буюу 19.3 хувь нь 4-5 жил, 1.2 мянга буюу 8.8 хувь нь 6-7 жил, 0.7 мянга буюу 5.6 хувь нь 8-9 жил, 0.9 мянга буюу 7.0 хувь нь 10-11 жил, 0.7 мянга буюу 5.6 хувь нь 12 ба түүнээс дээш жил ажилласан байна.

Бичил уурхайн үйл ажиллагаа эрхлэгчдийн дийлэнх нь буюу 4.2 мянга буюу 31.8 хувь нь 2-3 жил ажилласан байгаа нь сүүлийн 3 жил иргэд бичил уурхайн салбарт шинээр татагдан орж байгааг илэрхийлж байна.

ЗУРАГ 2.12. БИЧИЛ УУРХАЙ ЭРХЛЭГЧДИЙН ТОО, бичил уурхайд ажилласан жилийн бүлгээр, хувиар




Машин, механизм, төхөөрөмжийн операторч, угсрагч мэргэжилтэй 1 хүртэлх жил ажилласан 0.3 мянга, 2-3 жил ажилласан 0.5 мянга, 4-5 жил ажилласан 0.4 мянга, 6-7 жил ажилласан 0.2 мянга, 8-9 жил ажилласан 0.2 мянга, 10-11 жил ажилласан 0.2 мянга, 12 ба түүнээс дээш жил ажилласан 0.1 мянган бичил уурхайн үйл ажиллагаа эрхлэгч байна.

Бичил уурхайн үйл ажиллагаа эрхэлж буй шалтгаан:

Бичил уурхай эрхлэгчдийг ямар шалтгаанаар уг үйл ажиллагааг эрхэлж байгааг судалж үзэхэд 51.6 хувь нь байнгын ажлын байр олдоогүйгээс, 32.4 хувь нь нэмэлт орлого олох зорилгоор, 12.0 хувь нь малгүй болсон учраас, 4.0 хувь нь өөрийн бизнесээ болгох болон бусад зорилгоор бичил уурхайн үйл ажиллагаа эрхэлж байна.

ЗУРАГ 2.13. БИЧИЛ УУРХАЙ ЭРХЛЭГЧИД, бичил уурхайн үйл ажиллагаа эрхэлж буй шалтгаанаар, хувиар



Дээрх шалтгааныг бүсээр авч үзвэл Төвийн бүс болон Улаанбаатарын бичил уурхай эрхлэгчдийн 63.3-77.3 хувь нь байнгын ажлын байр олдоогүйгээс уг бичил уурхайн үйл ажиллагааг эрхэлсэн гэж хариулжээ.

Ажлын байр олдоогүйгээс бичил уурхайн үйл ажиллагаа эрхэлж байгаа иргэдийн 59.3 хувь, нэмэлт орлого олох зорилгоор тус үйл ажиллагааг эрхэлж байгаа иргэдийн 59.9 хувь, малгүй болсон иргэдийн 62.4 хувийг мэргэжилгүй иргэд эзэлж байна.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

БИЧИЛ УУРХАЙ ЭРХЛЭГЧДИЙН
СУУЦ, ЦАХИЛГААН ХАНГАМЖ,
УНДНЫ УСНЫ ЭХ ҮҮСВЭР

БИЧИЛ УУРХАЙ ЭРХЛЭГЧДИЙН СУУЦ, ЦАХИЛГААН ХАНГАМЖ, УНДНЫ УСНЫ ЭХ ҮҮСВЭР

Бичил уурхай эрхлэгчдийн үйл ажиллагаагаа эрхлэх хугацаанд амьдарч буй сууцны төрөл, сууцны эзэмшил, ундны усны эх үүсвэр, цахилгааны эх үүсвэрийн талаар энэхүү хэсэгт авч үзэх бөгөөд бичил уурхайн үйл ажиллагаанд туслах үйл ажиллагаа эрхлэгч, гэр бүлийн бизнест цалин хөлсгүй оролцогчын талаарх мэдээлэл энд ороогүй болно.

3.1. БИЧИЛ УУРХАЙ ЭРХЛЭГЧДИЙН СУУЦНЫ ТӨРӨЛ

Судалгаанд хамрагдсан бичил уурхай эрхлэгчдийн 7.1 мянга буюу 81.3 хувь нь ямар нэгэн хэлбэрийн сууцанд амьдардаг гэж хариулсан бол үлдсэн 1.6 мянга буюу 18.7 хувь нь бичил уурхайн үйл ажиллагаа эрхлэх явцад ямар нэгэн сууцанд амьдардаггүй гэж хариулсан байна.

ЗУРАГ 3.1. БИЧИЛ УУРХАЙ ЭРХЛЭГЧДИЙН СУУЦНЫ ТӨРӨЛ, ЭЗЭМШЛИЙН ХЭЛБЭР, сууцны төрлөөр, хувиар




Сууцанд амьдардаг гэж хариулсан хүмүүсийн 53.9 хувь нь гэрт, 4.8 хувь нь байшинд, 22.4 хувь нь майханд, 10.3 хувь нь түр оромжинд, 0.8 хувь нь нүхэн сууцанд, 7.8 хувь нь бусад хэлбэрийн сууцанд амьдардаг байна. Үүнээс харахад сууцанд амьдардаг хүмүүсийн 40 гаруй хувь нь зориулалтын бус сууцанд амьдарч байна.

Сууцны төрлийг эзэмшлийн төрлөөр нь авч үзвэл 4458 хүн буюу 63.0 хувь нь өөрийн эзэмшлийн, 2461 хүн буюу 34.8 хувь нь хамтын эзэмшлийн, харин 154 хүн буюу 2.2 хувь нь түрээсийн сууцанд амьдардаг байна. Үүнээс гэрт суудаг 3814 бичил уурхай эрхлэгчдийн 63.6 хувь нь өөрийн эзэмшлийн, 33.7 хувь нь хамтын эзэмшлийн, 2.7 хувь нь түрээсийн гэрт амьдардаг бол майханд амьдардаг 1582 хүний 67.6 хувь нь өөрийн эзэмшлийн, 31.5 хувь нь хамтын эзэмшлийн, 0.9 хувь нь түрээсийн майханд амьдардаг байна.

Өөрийн эзэмшлийн сууцны 54.4 хувь нь гэр, 6.2 хувь нь байшин, 24.0 хувь нь майхан, 7.0 хувь нь түр оромж, 0.9 хувь нь нүхэн сууц, 7.5 хувь нь бусад хэлбэрийнх байгаа бол хамтын эзэмшлийн сууцны 52.2 хувь нь гэр, 2.1 хувь нь байшин, 20.2 хувь нь майхан, 16.5 хувь нь түр оромж, 0.5 хувь нь нүхэн сууц, 8.4 хувь нь бусад хэлбэрийнх байна. Харин түрээсийн сууцны 68.2 хувь нь гэр, 7.8 хувь нь байшин, 9.7 хувь нь майхан, 4.5 хувь нь түр оромж, 0.6 хувь нь нүхэн сууц, 9.1 хувь нь бусад хэлбэрийнх байна.

ЗУРАГ 3.2. БИЧИЛ УУРХАЙ ЭРХЛЭГЧДИЙН СУУЦНЫ ЭЗЭМШИЛ, сууцны төрлөөр, хувиар




3.2. БИЧИЛ УУРХАЙ ЭРХЛЭГЧДИЙН УНДНЫ УСНЫ ЭХ ҮҮСВЭР

Энэ хэсэгт бичил уурхай эрхлэгчдийн үйл ажиллагаа явуулж байгаа газрын ундны усны эх үүсвэрийг тодорхойлно.

Судалгаанд хамрагдсан бичил уурхай эрхлэгчдийн дийлэнх нь 5164 хүн буюу 59.3 хувь нь гол, мөрөн, нуур, хамгаалагдаагүй худаг, булаг, шанднаас ундны усаа хангаж байна.

Харин 2589 бичил уурхай эрхлэгч буюу 29.8 хувь нь зөөврийн усаар ундны усны хэрэгцээгээ хангадаг бол 637 бичил уурхай эрхлэгч буюу 7.3 хувь нь хамгаалагдсан худгийн усаар ундны эх үүсвэрээ хангадаг гэж хариулжээ. Үлдсэн 3.6 хувь нь хамгаалагдсан булаг, шанд, цэвэршүүлсэн савласан ус зэрэг бусад эх үүсвэрээс ундны усны хэрэгцээгээ хангадаг байна.

ЗУРАГ 3.3. БИЧИЛ УУРХАЙ ЭРХЛЭГЧДИЙН УНДНЫ ЭХ ҮҮСВЭР, хувиар



Бусад эх үүсвэрээс ундны усны хэрэгцээгээ хангадаг иргэдийн 135 хүн буюу 1.6 хувь нь хамгаалагдсан булаг, шандны ус, 110 хүн буюу 1.3 хувь нь цэвэршүүлэн савласан ус, 39 хүн буюу 0.4 хувь нь төвлөрсөн системд холбогдсон ус түгээх байрны ус, 28 хүн буюу 0.3 хувь нь төвлөрсөн системд холбогдоогүй ус түгээх байрнаас ундны усаа авч хэрэглэдэг байна.

Бичил уурхай эрхлэгчдийн ундны усны эх үүсвэрийг ашигт малтмалын төрлөөр нь авч үзвэл алт олборлогчдын 68.3 хувь нь гол, мөрөн, нуур, хамгаалагдаагүй худаг, булаг, шанднаас, 23.6 хувь нь зөөврийн уснаас, 8.1 хувь нь бусад эх үүсвэрээс (хамгаалагдсан худаг, хамгаалагдсан булаг, шанд, цэвэршүүлэн савласан ус, төвлөрсөн системд холбогдсон ус түгээх байр, төвлөрсөн системд холбогдоогүй ус түгээх байр) ундны усны хэрэгцээгээ хангасан байна.

ХҮСНЭГТ 3.1. БИЧИЛ УУРХАЙ ЭРХЛЭГЧДИЙН УНДНЫ ЭХ ҮҮСВЭР, ашигт малтмалын төрөл, хувиар

Ашигт малтмалын төрөл	БҮГД	Ундны усны эх үүсвэрийн төрөл						Зөөврийн ус
		Гол, мөрөн, нуур, хамгаалагд-аагүй худаг, булаг, шанд	Төвлөрсөн системд холбогдсон ус түгээх байр	Хамгаалагдсан худаг	Хамгаалагдсан булаг, шанд	Цэвэршүүлэн савласан ус	Төвлөрсөн системд холбогдоогүй ус түгээх байр	
Алт	100.0	68.3	0.3	4.5	1.6	1.4	0.3	23.6
Нүүрс	100.0	7.6	0.4	0.4	-	0.1	-	91.4
Жонш	100.0	23.3	0.4	37.6	0.3	0.9	1.0	36.5
Гянтболд	100.0	78.0	0.8	9.4	0.4	-	-	11.4
Цагаан тугалга	100.0	24.4	14.6	19.5	36.6	-	-	4.9
Шохойн чулуу	100.0	100.0	-	-	-	-	-	-
Үнэт чулуу	100.0	62.2	1.8	2.7	5.4	4.5	-	23.4
Давс	100.0	94.4	-	5.6	-	-	-	-
БҮГД	100.0	59.3	0.4	7.3	1.6	1.3	0.3	29.8

Харин нүүрс олборлогчдын 91.5 хувь нь зөөврийн усаар, 7.6 хувь нь гол, мөрөн, нуур, хамгаалагдаагүй худаг, булаг, шанднаас ундны усаа авдаг бол жонш олборлогчдын 37.6 хувь нь хамгаалагдсан худагнаас, 36.5 хувь нь зөөврийн уснаас, 23.3 хувь нь гол, мөрөн, нуур, хамгаалагдаагүй худаг, булаг, шанднаас ундны усаа хангадаг байна.


3.3. БИЧИЛ УУРХАЙ ЭРХЛЭГЧДИЙН ЦАХИЛГААНЫ ЭХ ҮҮСВЭР

Энэ хэсэгт бичил уурхай эрхлэгчдийн үйл ажиллагаа явуулж байгаа газрын сууцных нь цахилгааны эх үүсвэрийг тодорхойлно. Цахилгааны эх үүсвэр нь бичил уурхай эрхлэгчдийн ая тухтай ажиллаж, амьдрах нэг чухал үзүүлэлт бөгөөд үүнтэй холбоотойгоор бичил уурхайчдын үйл ажиллагаа явуулж буй газрынх нь цахилгааны эх үүсвэрийн мэдээллийг төвлөрсөн систем, дизель станц, сэргээгдэх эрчим хүчний төхөөрөмж, бага оврын цахилгаан үүсгүүр, цахилгааны эх үүсвэргүй гэж ангилан судаллаа.

Судалгаанд хамрагдсан бичил уурхай эрхлэгчдийн талаас илүү нь буюу 55.7 хувь нь цахилгааны ямар нэгэн эх үүсвэргүй газар бичил уурхайн үйл ажиллагаа явуулж байна.

Цахилгааны эх үүсвэртэй нөхцөлд үйл ажиллагаа явуулдаг бичил уурхайчдын 45.6 хувь нь сэргээгдэх эрчим хүчний төхөөрөмж ашиглан цахилгаанд холбогддог бол 30.3 хувь нь төвлөрсөн системээс цахилгаан хэрэглэдэг байна. Үлдсэн 22.9 хувь нь бага оврын цахилгаан үүсгүүр ашиглан цахилгаан хэрэглэж, харин дөнгөж 1.2 хувь нь дизель станцтай холбогдсон байна.

ЗУРАГ 3.4. БИЧИЛ УУРХАЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭГЧДИЙН ЦАХИЛГААНЫ ЭХ ҮҮСВЭР, төрлөөр, хувиар



Бичил уурхай эрхлэгчдийн цахилгааны эх үүсвэрийг ашигт малтмалын төрлөөр нь авч үзвэл үнэт чулуу болон цагаан тугалганы бичил уурхай эрхлэгчдийн 83.9 болон 68.3 хувь нь, алт олборлогчдын 63.7 хувь нь, жонш, гянтболд, шохойн чулуун бичил уурхай эрхлэгчдийн 32.1-33.9 хувь нь тус тус цахилгааны эх үүсвэргүй газар амьдарч байна.

Нүүрс олборлогчдын 86.1 хувь нь, шохойн чулуун бичил уурхай эрхлэгчдийн 33.3 хувь нь төвлөрсөн системд холбогдсон цахилгаан хэрэглэдэг бол давс олборлодог бичил уурхай эрхлэгчдийн 77.8 хувь нь, гянтболд олборлогчдын 64.6 хувь нь, алт, жонш, цагаан тугалга, шохойн чулуу олборлогчдын 12.2-33.3 хувь нь сэргээгдэх эрчим хүчний төхөөрөмж ашиглан цахилгаанд холбогддог байна.

Жонш олборлогчдын 33.9 хувь нь, үнэт чулуу олборлогчдын 14.4 хувь нь, алт, цагаан тугалга олборлогчдын 7.3-8.6 хувь нь тус тус бага оврын цахилгаан үүсгүүр ашиглаж байна.

Бичил уурхай эрхлэгчдийн цахилгааны эх үүсвэрийг бүсийн түвшинд авч үзвэл баруун бүсийн бичил уурхай эрхлэгчдийн 62.4 хувь нь, хангайн бүсийн бичил уурхай эрхлэгчдийн 60.4 хувь нь, төвийн бүсийн бичил уурхай эрхлэгчдийн 60.5 хувь нь, зүүн бүсийн бичил уурхай эрхлэгчдийн 37.1 хувь нь ямар нэгэн цахилгааны эх үүсвэргүй газар амьдарч байна.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

БИЧИЛ УУРХАЙ ЭРХЛЭГЧДИЙН
ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТ

БИЧИЛ УУРХАЙ ЭРХЛЭГЧДИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТ

Энэ бүлэгт бичил уурхайд ажиллаж буй нөхөрлөлийн зохион байгуулалтад орсон нөхөрлөлийн ахлагч, гишүүд, хувиараа/дангаараа ашигт малтмал олборлогчдын талаарх мэдээллийг тусгасан бөгөөд бичил уурхайн үйл ажиллагаанд туслах үйл ажиллагаа эрхлэгч, гэр бүлийн бизнест цалин хөлсгүй оролцогчийн талаарх мэдээлэл ороогүй болно.


Судалгааны асуулгад бичил уурхай эрхлэгчдийн үйл ажиллагаандаа ашиглаж буй тоног төхөөрөмж, газар, түүний ашиглалт, үйл ажиллагаанаас олсон орлого, зардал, татвар, хураамж, хөрөнгө оруулалт зэрэг эдийн засгийн голлох үзүүлэлтийг багтааж судалсан. Дээрх эдийн засгийн холбогдолтой үзүүлэлтүүдийг бүтэн жилээр тодорхойлох зорилгоор 2011 оны байдлаар тусгав.

4.1. ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ АШИГЛАЛТ

Бичил уурхай эрхлэгчдийн тоног төхөөрөмжийн төрөл, тэдгээрийн ашиглалтыг судлах зорилгоор судалгааны асуулгад тусгайлан бүлэг асуулга тусгаж, мэдээллийг цуглуулсан. Тоног төхөөрөмжийн ашиглалт нь бичил уурхайн эрхлэгчдийн бүтээмж, орлоготой шууд хамааралтай чухал үзүүлэлт юм.

Бичил уурхай эрхлэгчдийн 96.3 хувь нь ямар нэгэн багаж, тоног төхөөрөмж үйл ажиллагаандаа ашигладаг байна. Ашиглаж буй нийт тоног төхөөрөмжийн 74.2 хувь нь өөрийн эзэмшлийнх, 24.6 хувь нь хамтын эзэмшлийнх, 1.2 хувь нь түрээсийнх байна.

ЗУРАГ 4.1. ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН ЭЗЭМШЛИЙН ТӨРӨЛ, хувиар



Бичил уурхай эрхлэгчдийн ашиглаж буй тоног төхөөрөмжийн 65.4 хувийг гар багаж (алх, хүрз, жоотуу), 6.3 хувийг цохилтот өрөм, 4.0 хувийг цахилгаан үүсгүүр, 3.9 хувийг өргөх төхөөрөмж, 3.7 хувийг металл хайх төхөөрөмж, 2.9 хувийг насос, 2.0 хувийг агааржуулагч, 2.0 хувийг усан буу эзэлж байна.

ХҮСНЭГТ 4.1. БИЧИЛ УУРХАЙ ЭРХЛЭГЧДИЙН АШИГЛАЖ БУЙ ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН ТОО, төрлөөр

Тоног төхөөрөмжийн төрөл	Тоног төхөөрөмжийн тоо	Нийт дүнд эзлэх хувь
БҮГД	34 155	100.0
Гар багаж (алх, хүрз, жоотуу зэрэг)	22 354	65.4
Металл хайх төхөөрөмж	1 265	3.7
Цахилгаан үүсгүүр	1 375	4.0
Агааржуулагч	694	2.0
Цохилтот өрөм (молоток)	2 147	6.3
Өргөх төхөөрөмж (лебедка)	1 345	3.9
Усан буу (скруббер)	694	2.0
Насос	986	2.9
Бага оврын цохилтод өрөм (компрессор)	697	2.0
Бусад	2 598	7.6


Бүсээр авч үзвэл тоног төхөөрөмжийн 24.7 хувь нь баруун бүсэд, 26.8 хувь нь хангайн бүсэд, 30.3 хувь нь төвийн бүсэд, 4.1 хувь нь зүүн бүсэд, 14.1 хувь нь Улаанбаатар хотод ногдож байна.

ХҮСНЭГТ 4.2. БИЧИЛ УУРХАЙ ЭРХЛЭГЧДИЙН АШИГЛАЖ БУЙ ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН НИЙТ ДҮНД ЭЗЛЭХ ХУВЬ, тоног төхөөрөмжийн төрөл, бүсээр

Тоног төхөөрөмжийн төрөл	БҮГД	Бүс				
		Баруун бүс	Хангайн бүс	Төвийн бүс	Зүүн бүс	Улаанбаатар
БҮГД	100.0	24.7	26.8	30.3	4.1	14.1
Гар багаж (алх, хүрз, жоотуу зэрэг)	100.0	26.5	26.4	29.8	4.1	13.3
Металл хайх төхөөрөмж	100.0	33.3	39.4	26.4	-	0.9
Цахилгаан үүсгүүр	100.0	25.1	15.2	42.8	3.9	13.1
Агааржуулагч	100.0	7.9	4.2	27.4	2.0	58.5
Цохилтот өрөм (молоток)	100.0	12.5	14.0	37.0	5.8	30.7
Өргөх төхөөрөмж (лебедка)	100.0	8.6	15.9	29.2	7.7	38.7
Усан буу (скруббер)	100.0	34.9	29.0	33.6	0.7	1.9
Насос	100.0	17.3	52.5	23.2	5.7	1.2
Бага оврын цохилтод өрөм (компрессор)	100.0	15.4	26.8	46.9	9.8	1.1
Бусад	100.0	31.0	42.1	23.4	3.1	0.4

Нийт бичил уурхай эрхлэгчдийн 35.3 хувь нь ямар нэгэн хөдөлмөр хамгааллын хувцас хэрэглэдэг байна. Нүүрс олборлогчдын 86.1 хувь, жонш олборлогчдын 59.7 хувь, алт олборлогчдын 29.2 хувь, шохойн чулуу олборлогчдын 33.3 хувь нь хөдөлмөр хамгааллын хувцас хэрэглэдэг байна. Бичил уурхай эрхэлдэг эрэгтэйчүүдийн 36.3 хувь, эмэгтэйчүүдийн 29.5 хувь нь хөдөлмөр хамгааллын хувцас хэрэглэдэг байна.

ЗУРАГ 4.2. БИЧИЛ УУРХАЙ ЭРХЛЭГЧДИЙН ТОО, ХӨДӨЛМӨР ХАМГААЛЛЫН ХУВЦАС ХЭРЭГЛЭДЭГ ЭСЭХЭЭР (ХУВИАР), ашигт малтмалын төрлөөр



4.2. АШИГЛАЖ БҮЙ ТАЛБАЙ

Энэ хэсэгт бичил уурхай эрхлэгчдийн үйл ажиллагаа явуулж буй газрын зөвшөөрөл, талбайн хэмжээ, эвдрэл, нөхөн сэргээлттэй холбоотой мэдээлэл багтана.

2011 оны байдлаар нийтдээ 8319.3 га талбайг бичил уурхайн үйл ажиллагааны зориулалтаар ашиглаж байна. Энэ талбайн 2871.3 га буюу 34.5 хувь нь баруун бүсэд, 1584.8 га буюу 19.1 хувь нь хангайн бүсэд, 2113.2 буюу 25.4 хувь нь төвийн бүсэд, 558.9 га буюу 6.7 хувь нь зүүн бүсэд, 1191.0 га буюу 14.3 хувь нь Улаанбаатар хотод байна.


Судалгаанд хамрагдсан бичил уурхай эрхлэгчид ашигт малтмал олборлох хугацаанд нийт 8287.9 га талбайг эвдрэлд оруулсан бөгөөд 57.2 хувь нь баруун бүсэд, 9.7 хувь нь хангайн бүсэд, 14.7 хувь нь төвийн бүсэд, 6.3 хувь нь зүүн бүсэд, 12.1 хувь нь Улаанбаатар хотод ногдож байна.

ХҮСНЭГТ 4.3. БИЧИЛ УУРХАЙД АШИГЛАЖ БУЙ ГАЗРЫН ХЭМЖЭЭ, ЭВДРЭЛД ОРСОН ТАЛБАЙН ХЭМЖЭЭ, нөхөн сэргээлт хийсэн талбайн хэмжээ, бүсээр

Бүс	Ашиглаж байгаа талбайн хэмжээ	Олборлолт явуулж эхэлснээс хойш эвдрэлд орсон талбайн хэмжээ	Нөхөн сэргээлт хийсэн талбайн хэмжээ
БҮГД	8 319.3	8 287.9	594.3
Баруун бүс	2 871.3	4 741.0	78.6
Хангайн бүс	1 584.8	808.8	146.9
Төвийн бүс	2 113.2	1 217.0	4.3
Зүүн бүс	558.9	521.2	356.5
Улаанбаатар	1 191.0	1 000.0	8.0

Нийт бичил уурхай эрхлэгчдийн 22.7 хувь нь зөвшөөрөлтэй талбайд ажиллаж байна. Нийт шохойн чулуу олборлогчдын 83.3 хувь, нүүрс олборлогчдын 76.5 хувь, гянтболд олборлогчдын 60.2 хувь, жонш олборлогчдын 51.8 хувь, алт олборлогчдын 12.8 хувь нь зөвшөөрөлтэй талбайд ажиллаж байна.


ЗУРАГ 4.3. ЗӨВШӨӨРӨЛТЭЙ ТАЛБАЙД АЖИЛЛАЖ БАЙГАА БИЧИЛ УУРХАЙ ЭРХЛЭГЧДИЙН ТОО, хувиар, ашигт малтмалын төрлөөр



Алт олборлолтын үйл ажиллагаа явуулж буй зөвшөөрөлтэй талбайн 64.5 хувь нь орон нутгийн тусгай хэрэгцээний газар, 35.1 хувь нь аж ахуйн нэгжийн ашиглалтын лицензтэй газар, үлдсэн 0.4 хувь нь бусад төрлийн зөвшөөрөлтэй байна.

Харин нүүрс олборлолтын үйл ажиллагаа явуулж буй зөвшөөрөлтэй талбайн 90.8 хувь нь аж ахуйн нэгжийн ашиглалтын лицензтэй газар, 6.1 хувь нь орон нутгийн тусгай хэрэгцээний газар, үлдсэн 3.1 хувь нь бусад төрлийн зөвшөөрөлтэй байна.


ЗУРАГ 4.4. ЗӨВШӨӨРӨЛТЭЙ ТАЛБАЙН ЗӨВШӨӨРЛИЙН ТӨРӨЛ, хувиар



Нийт бичил уурхай эрхлэгчдийн 5.5 хувь нь тодорхой хэмжээгээр нөхөн сэргээлт хийсэн байна. Баруун бүсэд нөхөн сэргээлтийн хувь хамгийн өндөр буюу 13.3 хувь, төвийн бүсэд 4.8 хувь, зүүн бүсэд 2.8 хувь, хангайн бүсэд 0.7 хувь, Улаанбаатар хотод 0.5 хувь байна. Дээрх үзүүлэлтийг ашигт малтмалын төрлөөр нь авч үзвэл гянтболд олборлогчдын 27.6 хувь, шохойн чулуу олборлогчдын 16.7 хувь, цагаан тугалга олборлогчдын 9.8 хувь, жонш олборлогчдын 9.1 хувь, алт олборлогчдын 5.0 хувь, нүүрс олборлогчдын 0.4 хувь нь нөхөн сэргээлт хийжээ.

2011 онд бичил уурхай эрхлэгчид 594.3 га талбайд нөхөн сэргээлт хийсэн байна. Үүнээс 78.6 га буюу 13.2 хувь нь баруун бүсэд, 146.9 га буюу 24.7 хувь нь хангайн бүсэд, 4.3 га буюу 0.7 хувь нь төвийн бүсэд, 356.5 га буюу 60.0 хувь нь зүүн бүсэд, 8.0 га буюу 1.3 хувь нь Улаанбаатар хотод байна. Энэ нөхөн сэргээлт хийсэн талбайн хэмжээ нь олборлолт явуулж эхэлснээс хойш эвдрэлд орсон нийт талбайн 7.2 хувь болж байна. Бичил уурхай эрхлэгчдийн 58.4 хувь нь байгаль хамгааллын байцаагчид, 26.7 хувь нь сум, дүүргийн ЗДТГ-д нөхөн сэргээлт хийсэн талбайгаа хүлээлгэн өгсөн байна.

ЗУРАГ 4.5. БИЧИЛ УУРХАЙД АШИГЛАЖ БУЙ ГАЗРЫН ХЭМЖЭЭ, ЭВДРЭЛД ОРСОН ТАЛБАЙН ХЭМЖЭЭ, НӨХӨН СЭРГЭЭЛТ ХИЙСЭН ТАЛБАЙН ХЭМЖЭЭ, га-гаар



4.3. БИЧИЛ УУРХАЙ ЭРХЛЭГЧДИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ

Энэ хэсэгт бичил уурхай эрхлэгчдийн үйл ажиллагааны мөчлөг, орлого, зардал, татвар, хураамж, тэдний эдийн засагт оруулж буй нэмэр зэргийг дэлгэрэнгүйгээр харууллаа.


4.3.1. Бичил уурхай эрхлэгчдийн үйл ажиллагааны ерөнхий мэдээлэл

2011 оны байдлаар нийт бичил уурхай эрхлэгчдийн 77.9 хувь нь алт, 8.2 хувь нь нүүрс, 9.0 хувь нь жонш, 2.9 хувь нь гянтболд, үлдсэн 2.0 хувь нь бусад төрлийн ашигт малтмал олборлосон байна.

Нийт бичил уурхай эрхлэгчдийн 65.6 хувь нь ил, 34.4 хувь нь далд уурхайд ажиллаж байна. Үүнээс алт олборлогчдын 71.8 хувь нь ил, 28.2 хувь нь далд, нүүрс олборлогчдын 5.4 хувь нь ил, 94.6 хувь нь далд, жонш олборлогчдын 53.7 хувь нь ил, 46.3 хувь нь далд уурхайд ажиллаж байна.

Түүнчлэн гянтболд олборлогчдын 77.6 хувь нь ил, 22.4 хувь нь далд, цагаан тугалга олборлогчдын 69.6 хувь нь ил, 30.4 хувь нь далд, шохойн чулуу, үнэт чулуу, давс олборлогчид 100.0 хувь нь ил ашигт малтмалын илрэл бүхий, орд, газарт ажиллаж байна.


ЗУРАГ 4.6. АШИГТ МАЛТМАЛ АШИГЛАЛТЫН ХЭЛБЭР, төрлөөр, хувиар



Бичил уурхай эрхлэгчдийн үйл ажиллагааны идэвхжилтийн үеийг ашигт малтмалын төрлөөр авч үзвэл алт олборлолт 5 дугаар сараас 9 дүгээр сар хүртэл идэвхжиж, харин 12 дугаар сараас 3 дугаар саруудад үйл ажиллагааны идэвхжил буурдаг байна. Алт олборлогчдын үйл ажиллагааны идэвхжилийн үе буюу 8 дугаар сард нийт алт олборлогчдын 86.8 хувь нь үйл ажиллагаа явуулж, идэвхжилийн хамгийн бага үе болох 1 дүгээр сард 19.6 хувь нь үйл ажиллагаа явуулдаг байна.

Жонш олборлогчдын үйл ажиллагааны мөчлөг алтныхтай ижил буюу үйл ажиллагааны идэвхтэй үе нь 5 дугаар сараас 10 дугаар сарын хооронд байна. Нүүрс олборлогчдын үйл ажиллагааны хамгийн идэвхтэй үе 10 дугаар сараас 2 дугаар сар хүртлэх хугацаа байна. Идэвхжилтийн хамгийн оргил үе болох 11 дүгээр сард нийт нүүрс олборлогчдын 98.2 хувь нь үйл ажиллагаагаа явуулсан байна.

ЗУРАГ 4.7. БИЧИЛ УУРХАЙ ЭРХЛЭГЧДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ИДЭВХИ, голлох ашигт малтмалын төрлөөр




Судалгааны дүнгээр нийт бичил уурхай эрхлэгчид 354.6 кг алт, 142.0 мянган тонн нүүрс, 38.5 мянган тонн жонш, 108.3 тонн гянтболд, 5.5 тонн цагаан тугалга, 66.6 тонн шохойн чулуу, 14.7 тонн үнэт чулуу, 1062.3 тонн давс олборложээ.

ХҮСНЭГТ 4.4. БОРЛУУЛСАН АШИГТ МАЛТМАЛЫН ХЭМЖЭЭ, ашигт малтмалын төрлөөр

Ашигт малтмалын төрөл	Хэмжих нэгж	Борлуулалсан ашигт малтмалын хэмжээ
Алт	кг	354.6
Нүүрс	тонн	141 970.6
Жонш	тонн	38 482.7
Гянтболд	тонн	108.3
Цагаан тугалга	тонн	5.5
Шохойн чулуу	тонн	66.6
Үнэт чулуу	тонн	14.7
Давс	тонн	1 062.3


Бичил уурхай эрхлэгчид олборлосон ашигт малтмалынхаа 95.5 хувийг хувь хүнд, 4.5 хувийг аж ахуйн нэгжид борлуулдаг байна.

ЗУРАГ 4.8. БИЧИЛ УУРХАЙ ЭРХЛЭГЧДИЙН ГОЛ НИЙЛҮҮЛЭГЧ, бүс, хувиар



Дээрх борлуулсан ашигт малтмалаас нийтдээ 25389.6 сая төгрөгийн орлого олсон байна. Бүсээр авч үзвэл нийт борлуулалтын орлогын 4890.7 сая төг буюу 19.3 хувь нь баруун бүсэд, 7820.7 сая төг буюу 30.8 хувь нь хангайн бүсэд, 8903.5 сая төг буюу 35.1 хувь нь төвийн бүсэд, 735.4 сая төг буюу 2.9 хувь нь зүүн бүсэд, 3039.4 сая төг буюу 12.0 хувь нь Улаанбаатар хотод ногдож байна.

ЗУРАГ 4.9. БИЧИЛ УУРХАЙ ЭРХЛЭГЧДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ОРЛОГО, аймгаар



Бичил уурхай эрхлэгч нэг нэгжийн жилийн дундаж борлуулалтын орлого 3.5 сая төг, үүнээс баруун бүсийнх 2.5 сая төг, хангайн бүсийнх 3.6 сая төгрөг, төвийн бүсийнх 4.0 сая төг, зүүн бүсийнх 2.9 сая төг, Улаанбаатар хотынх 4.9 сая төгрөг тус тус байна. Уг үзүүлэлтийг аймгуудаар авч үзвэл 0.6-8.0 сая төг-ийн хооронд хэлбэлзэж байна. Дундговь, Дархан-Уул, Баян-Өлгий аймаг болон Улаанбаатар хотод бичил уурхай эрхлэгч нэг нэгжийн жилийн дундаж орлого хамгийн өндөр буюу 4.9-8.0 сая төгрөг байсан бол Сүхбаатар аймагт хамгийн бага буюу 0.6 сая төгрөг байна.

ХҮСНЭГТ 4.5. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ОРЛОГО, бүсээр

Бүс	Нийт орлого (сая төг)	1 нэгжийн жилийн дундаж орлого (мян.төг)	Нийт дүнд эзлэх хувь
БҮГД	25 389.6	3 490.9	100.0
Баруун бүс	4 890.7	2 467.5	19.3
Хангайн бүс	7 820.7	3 582.6	30.8
Төвийн бүс	8 903.5	3 981.9	35.1
Зүүн бүс	735.4	2 929.9	2.9
Улаанбаатар	3 039.4	4 894.4	12.0

Судалгаанд хамрагдсан иргэдийн 25.0 хувь нь 2011 онд улсад татвар, хураамж төлсөн байна. Нийт 195.5 сая төгрөгийн татвар, хураамж төлсний 70.2 сая төг буюу 35.9 хувийг авто болон өөрөө явагч тээврийн хэрэгслийн албан татварт, 103.3 сая төг буюу 52.8 хувийг орлогын тухай бүр тодорхойлох боломжгүй иргэдийн татварт, 10.9 сая төг буюу 5.6 хувийг гишүүнчлэлийн татварт, 11.1 сая төгрөг буюу 5.7 хувийг бусад төрлийн татвар, хураамжинд төлсөн байна.


Баруун бүсийн бичил уурхай эрхлэгчид 30.5 сая төг, хангайн бүсийнх 46.6 сая төг, төвийн бүсийнх 91.0 сая төг, зүүн бүсийнх 25.2 сая төг, Улаанбаатар хотынх 2.2 сая төгрөгийн татвар төлжээ.

ХҮСНЭГТ 4.6. БИЧИЛ УУРХАЙ ЭРХЛЭГЧДИЙН ТӨЛСӨН ТАТВАРЫН ХЭМЖЭЭ, бүс, зардлын төрлөөр

Бүс	2011 онд төлсөн нийт татвар, хураамж	Үүнээс:			
		Авто болон өөрөө явагч тээврийн хэрэгслийн албан татвар	Орлогын тухай бүр тодорхойлох боломжгүй иргэдийн татвар	Гишүүнч- лэлийн татвар	Бусад татвар
БҮГД	195.5	70.2	103.3	10.9	11.1
Баруун бүс	30.5	18.1	8.8	0.6	2.9
Хангайн бүс	46.6	11.5	31.9	1.2	2.1
Төвийн бүс	91.0	37.3	50.5	1.8	1.4
Зүүн бүс	25.2	2.8	11.4	7.3	3.6
Улаанбаатар	2.2	0.5	0.7	-	1.0

Бичил уурхай эрхлэгчдийн татвар төлөлтийн хувийг ашигт малтмалын төрлөөр нь авч үзвэл алт олборлогчдын 25.7 хувь, нүүрс олборлогчдын 5.8 хувь, жонш олборлогчдын 35.3 хувь, гянтболд олборлогчдын 52.8 хувь, цагаан тугалга олборлогчдын 36.6 хувь, шохойн чулуу олборлогчдын 66.7 хувь, үнэт чулуу олборлогчдын 5.0 хувь нь татвар төлжээ.

ЗУРАГ 4.10. БИЧИЛ УУРХАЙ ЭРХЛЭГЧДИЙН ТАТВАР ТӨЛӨЛТИЙН ХУВЬ, ашигт малтмалын төрлөөр



Бичил уурхай эрхлэгчдийн татвар төлөлтийн хувь улсын дунджаар 25.0% байгаа бөгөөд баруун бүсэд хамгийн өндөр буюу 35.7%, төвийн бүсэд 26.1%, хангайн бүсэд 21.9%, зүүн бүсэд 15.5%, Улаанбаатар хотод 1.9% байна.

2011 оны байдлаар бичил уурхай эрхлэгчид нийтдээ 8513.0 сая төгрөгийг үйл ажиллагаандаа зарцуулсан байна. Нийт зардлын 23.2 хувийг шатахуун, шатах тослох материалын зардал, 19.0 хувийг цалингийн зардал, 12.2 хувийг газар эзэмшигчид төлсөн төлбөр, 11.2 хувийг тээврийн зардал, 5.3 хувийг сэлбэг хэрэгсэл, 3.4 хувийг хөдөлмөр хамгааллын зардал, 2.7 хувийг түүхий эд, материалын зардал бүрдүүлж байна.

Ашигт малтмалын төрлөөр авч үзвэл алт олборлогчид 5711.2 сая төг, нүүрс олборлогчид 1420.5 сая төг, жонш олборлогчид 1144.7 сая төг, бусад ашигт малтмал олборлогчид 236.6 сая төгрөгийг үйл ажиллагаандаа зарцуулжээ. Алт олборлогчдын нийт зардлын 50.9 хувийг шатахуун, шатах тослох материалын зардал болон цалингийн зардал, нүүрс олборлогчдын нийт зардлын 72.1 хувийг газар эзэмшигчид төлсөн төлбөр бүрдүүлж байна.

ХҮСНЭГТ 4.7. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ, ашигт малтмалын төрөл, зардлын төрлөөр

Зардлын төрөл	БҮГД	Үүнээс:				сая.төг
		Алт	Нүүрс	Жонш	Бусад	Эзлэх хувь
Бүгд	8 513.0	5 711.2	1 420.5	1 144.7	236.6	100.0
Цалин	1 615.2	1 312.8	57.0	209.6	35.9	19.0
Ажиллагчлал мөнгөн ба биет хэлбэрээр өгсөн тусламж	176.8	97.3	3.7	72.1	3.8	2.1
Шатхуун, шатах тослох материал	1 977.6	1 593.0	14.3	298.6	71.7	23.2
Тээврийн зардал	952.6	693.5	17.7	216.3	25.1	11.2
Хөдөлмөр хамгааллын зардал	293.5	187.2	42.4	35.9	28.0	3.4
Цахилгаан эрчим хүч, дулаан	166.1	85.8	69.0	9.4	1.8	2.0
Сэлбэг хэрэгсэл	448.0	356.6	25.0	59.3	7.1	5.3
Түүхий эд, материал	233.5	158.0	46.6	23.5	5.5	2.7
Зээлийн хүүгийн зардал	99.2	72.9	0.5	25.1	0.7	1.2
Машин тоног төхөөрөмж түрээсэлсний зардал	96.9	82.0	0.0	14.9	0.0	1.1
Барилга, байшин түрээсэлсний зардал	36.7	32.3	2.1	2.3	0.0	0.4
Гамшгийн улмаас учирсан хохирлыг нөхөхөд	3.2	0.7	2.1	0.5	0.0	0.0
Газар эзэмшигчид төлсөн төлбөр	1 035.1	6.2	1 024.2	4.3	0.4	12.2
Байгаль орчныг нөхөн сэргээхтэй холбогдсон зардал	69.3	23.2	36.6	8.8	0.7	0.8
Бусад зардал	1 309.5	1 009.7	79.5	164.5	55.7	15.4

Нийт зардлын 750.1 сая төг буюу 8.8 хувь нь баруун бүсэд, 3300.6 сая төг буюу 38.8 хувь нь хангайн бүсэд, 2451.6 сая төг буюу 28.8 хувь нь төвийн бүсэд, 601.4 сая төг буюу 7.1 хувь нь зүүн бүсэд, 1409.4 сая төг буюу 16.6 хувь нь Улаанбаатар хотод ногдож байна. Улаанбаатар хотын нийт зардалд газар эзэмшигчид төлсөн төлбөр 72.7 хувийг эзэлж байна.

ХҮСНЭГТ 4.8. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ, бүсээр, зардлын төрлөөр

сая.төг

Зардлын төрөл	Нийт зардал	Үүнээс:				
		Баруун бүс	Хангайн бүс	Төвийн бүс	Зүүн бүс	Улаанбаатар
БҮГД	8 513.0	750.1	3 300.6	2 451.6	601.4	1 409.4
Цалин	1 615.2	32.9	1210.7	151.8	162.9	57.0
Ажиллагчдад мөнгөн ба биет хэлбэрээр өгсөн тусламж	176.8	32.0	63.5	62.2	15.5	3.5
Шатахуун, шатах тослох материал	1 977.6	262.0	761.3	795.1	150.6	8.6
Тээврийн зардал	952.6	115.4	252.3	424.9	146.8	13.1
Хөдөлмөр хамгааллын зардал	293.5	46.5	67.8	113.0	24.3	41.8
Цахилгаан эрчим хүч, дулаан	166.1	4.0	33.0	54.2	5.9	69.0
Сэлбэг хэрэгсэл	448.0	75.0	105.3	212.0	30.9	24.8
Түүхий эд, материал	233.5	46.5	49.8	67.6	23.2	46.6
Зээлийн хүүгийн зардал	99.2	27.8	14.3	38.7	17.9	0.5
Машин тоног төхөөрөмж түрээсэлсний зардал	96.9	8.1	17.9	65.9	5.1	0.0
Барилга, байшин түрээсэлсний зардал	36.7	1.0	27.1	5.1	1.4	2.1
Гамшгийн улмаас учирсан хохирлыг нөхөхөд	3.2	0.1	0.0	1.1	-	2.1
Газар эзэмшигчид төлсөн төлбөр	1 035.1	2.4	2.8	3.2	2.5	1 024.2
Байгаль орчныг нөхөн сэргээхтэй холбогдсон зардал	69.3	7.6	10.9	12.8	1.4	36.6
Бусад зардал	1309.5	88.9	683.9	444.0	13.2	79.5

4.3.2. НИЙТ ГАРГАЛТ, НЭМЭГДЭЛ ӨРТӨГ, ЗАВСРЫН ХЭРЭГЛЭЭ

Бичил уурхай эрхлэгчид жилдээ 19806.1 сая төгрөгийн нэмэгдэл өртгийг бий болгож, 5583.6 сая төгрөгийг завсрын хэрэглээнд зарцуулсан байна. Нийт нэмэгдэл өртгийн 21.4 хувийг баруун бүс, 29.3 хувийг хангайн бүс, 33.9 хувийг төвийн бүс, 1.7 хувийг зүүн бүс, 13.7 хувийг Улаанбаатар хот бүрдүүлж байна.

Эдийн засгийн үйл ажиллагааны үр ашгийн түвшинг илтгэн харуулах үзүүлэлтийн нэг нь нэмэгдэл өртөг, нийт үйлдвэрлэлтийн харьцаа байдаг бөгөөд бичил уурхай эрхлэгчдийн хувьд энэ үзүүлэлт харьцангуй өндөр буюу 78.0 хувьтай байна. Энэхүү үзүүлэлтийг аймгаар нь авч үзвэл Дорнод аймгийн хувьд хамгийн өндөр хувьтай буюу 95.9 хувь байна. Энэ нь 4.1 хувийн зардал гаргаж, 95.6 хувийн нэмэгдэл өртөг бий болгож байна гэсэн үг юм. Харин Хэнтий аймагт хамгийн доогуур буюу 37.3 хувь байна.

Бүтээж буй нэмэгдэл өртгийн хэмжээгээрээ Хөвсгөл аймаг 2885.3 сая төгрөг, Төв аймаг 2659.1 сая төгрөг, Баянхонгор аймаг 2029.3 сая төгрөг, Сэлэнгэ аймаг 1949.4 сая төгрөг, Улаанбаатар хот 2717.2 сая төгрөг байгаа нь бичил уурхайн үйл ажиллагаанаас хамгийн их нэмэгдэл өртгийг бий болгосон эхний 5 аймагт багтаж байна.

ХҮСНЭГТ 4.9. НИЙТ ҮЙЛДВЭРЛЭЛ, ЗАВСРЫН ХЭРЭГЛЭЭ, НЭМЭГДЭЛ ӨРТӨГ, бүс, аймаг, нийслэлээр

сая.төг					
Бүс, аймаг, нийслэл,	Нийт орлого	Завсрын хэрэглээ	Нэмэгдэл өртөг	Нийт нэмэгдэл өртгийн дүнд эзлэх хувь	Нийт үйлдвэрлэлт (орлого), нэмэгдэл өртгийн харьцаа
БҮГД	25 389.6	5 583.6	19 806.1	100.0	78.0
Баруун бүс	4 890.7	654.9	4 235.7	21.4	86.6
Баян-Өлгий	1 027.5	86.2	941.3	4.8	91.6
Говь-Алтай	1 277.3	135.6	1 141.7	5.8	89.4
Завхан	137.7	29.2	108.5	0.5	78.8
Увс	1 686.7	222.0	1 464.7	7.4	86.8
Ховд	761.4	181.9	579.5	2.9	76.1
Хангайн бүс	7 820.7	2 009.3	5 811.4	29.3	74.3
Архангай	106.2	6.0	100.2	0.5	94.3
Баянхонгор	3 080.6	1 051.3	2 029.3	10.2	65.9
Булган	331.4	117.4	213.9	1.1	64.6
Өвөрхангай	634.3	51.7	582.6	2.9	91.9
Хөвсгөл	3 668.2	782.9	2 885.3	14.6	78.7
Төвийн бүс	8 903.5	2 194.5	6 708.9	33.9	75.4
Дархан-Уул	844.3	178.4	665.9	3.4	78.9
Дорноговь	1 135.7	445.8	689.9	3.5	60.7
Дундговь	519.3	58.7	460.6	2.3	88.7
Өмнөговь	338.4	54.4	284.0	1.4	83.9
Сэлэнгэ	2 560.5	611.1	1 949.4	9.8	76.1
Төв	3 505.2	846.1	2 659.1	13.4	75.9
Зүүн бүс	735.4	402.6	332.8	1.7	45.3
Дорнод	86.6	3.5	83.1	0.4	95.9
Сүхбаатар	16.6	2.4	14.2	0.1	85.5
Хэнтий	632.2	396.7	235.5	1.2	37.3
Улаанбаатар	3 039.4	322.2	2 717.2	13.7	89.4

Нийт нэмэгдэл өртгийн бүрэлдэхүүн хэсгийн бүтцийг авч үзвэл цалин 1615.2 сая төгрөг буюу 8.2 хувь, ажиллагчдад мөнгөн ба биет хэлбэрээр өгсөн тусламж 176.8 сая төгрөг буюу 0.9 хувь, зээлийн хүүгийн зардал 99.2 сая төгрөг буюу 0.5 хувь, орлогын тухай бүр тодорхойлох боломжгүй иргэдийн татвар болон бусад татвар хураамж 195.5 сая төг буюу 1.0 хувийг бүрдүүлж, үлдсэн 16681.1 сая төгрөг буюу 84.2 хувь нь үйл ажиллагааны ашиг байна.

ХҮСНЭГТ 4.10. НЭМЭГДЭЛ ӨРТӨГ, бүрэлдэхүүн хэсгээр, бүсээр

							сая.төг	
Нэмэгдэл өртгийн бүрэлдэхүүн	БҮГД	Үүнээс:					Эзлэх хувь	
		Баруун бүс	Хангайн бүс	Төвийн бүс	Зүүн бүс	Улаанбаатар		
Нэмэгдэл өртөг	19 806.1	4 235.7	5 811.4	6 708.9	332.8	2 717.2	100.0	
Нэмэгдэл өртгийн бүрэлдэхүүн хэсэг	Цалин	1 615.2	32.9	1 210.7	151.8	162.9	57.0	8.2
	Авто болон өөрөө явагч тээврийн хэрэгслийн албан татвар	70.2	18.1	11.5	37.3	2.8	0.5	0.4
	Орлогын тухай бүр тодорхойлох боломжгүй иргэдийн татвар	103.3	8.8	31.9	50.5	11.4	0.7	0.5
	Гишүүнчлэлийн татвар	10.9	0.6	1.2	1.8	7.3	-	0.1
	Бусад татвар	11.1	2.9	2.1	1.4	3.6	1.0	0.1
	Ажиллагчлал мөнгөн ба биет хэлбэрээр өгсөн тусламж	176.8	32.0	63.5	62.2	15.5	3.5	0.9
	Зээлийн хүүгийн зардал	99.2	27.8	14.3	38.7	17.9	0.5	0.5
	Гамшгийн улмаас учирсан хохирлыг нөхөхөд	3.2	0.1	0.0	1.1	-	2.1	0.0
	Газар эзэмшигчид төлсөн төлбөр	1 035.1	2.4	2.8	3.2	2.5	1 024.2	5.2
	Тооцооны ашиг	16 681.1	4 110.1	4 473.4	6 360.9	108.8	1 627.9	84.2

Бичил уурхай эрхлэгчдийн нийт завсрын хэрэглээний 35.4 хувийг шатахуун, шатах тослох материалын зардал, 17.1 хувийг тээврийн зардал, 8.0 хувийг сэлбэг хэрэгсэлийн зардал, 5.3 хувийг хөдөлмөр хамгааллын зардал, 4.2 хувийг түүхий эд, материалын зардал, үлдсэн 30.1 хувийг бусад зардал бүрдүүлж байна.

Бүсээр авч үзвэл нийт завсрын хэрэглээний 11.7 хувь нь баруун бүсэд, 36.0 хувь нь хангайн бүсэд, 39.3 хувь нь төвийн бүсэд, 7.2 хувь нь зүүн бүсэд, 5.8 хувь нь Улаанбаатар хотод ногдож байна.

ХҮСНЭГТ 4.11. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАВСРЫН ХЭРЭГЛЭЭ, бүрэлдэхүүн хэсэг, бүсээр


		сая.төг					
Завсрын хэрэглээний бүрэлдэхүүн	БҮГД	Үүнээс:					Эзлэх хувь
		Баруун бүс	Хангайн бүс	Төвийн бүс	Зүүн бүс	Улаанбаатар	
Завсрын хэрэглээ	5 583.6	654.9	2 009.3	2 194.5	402.6	322.2	100.0
Завсрын хэрэглээний бүрэлдэхүүн хэсэг	Түүхий эд, материал	233.5	46.5	49.8	67.6	23.2	4.2
	Сэлбэг хэрэгсэл	448.0	75.0	105.3	212.0	30.9	8.0
	Цахилгаан эрчим хүч, дулаан	166.1	4.0	33.0	54.2	5.9	3.0
	Шатхуун, шатах тослох материал	1 977.6	262.0	761.3	795.1	150.6	35.4
	Барилга, байшин түрээсэлсний зардал	36.7	1.0	27.1	5.1	1.4	0.7
	Машин тоног төхөөрөмж түрээсэлсний зардал	96.9	8.1	17.9	65.9	5.1	0.9
		1.7	27.8	14.3	38.7	17.9	0.5
	Тээврийн зардал	952.6	115.4	252.3	424.9	146.8	17.1
	Хөдөлмөр хамгааллын зардал	293.5	46.5	67.8	113.0	24.3	5.3
	Байгаль орчныг нөхөн сэргээхтэй холбогдсон зардал	69.3	7.6	10.9	12.8	1.4	1.2
	Бусад зардал	1 309.5	88.9	683.9	444.0	13.2	23.5

4.4. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

Энэ бүлэгт тухайн бизнест 2011 онд оруулсан хөрөнгө оруулалт, хөрөнгө оруулалтын үндсэн эх үүсвэрийн талаарх мэдээллийг багтаасан.

2011 онд нийт бичил уурхай эрхлэгчдийн 11.0 хувь нь хөрөнгө оруулалт хийсэн байна. Энэ үзүүлэлт төвийн бүсэд 16.4 хувь, баруун бүсэд 10.5 хувь, зүүн бүсэд 10.4 хувь, хангайн бүсэд 8.7 хувь, Улаанбаатар хотод 1.6 хувь байна. Алт олборлогчдын 12.2 хувь нь, нүүрс олборлогчдын 1.7 хувь нь, жонш олборлогчдын 12.4 хувь нь, гянтболд олборлогчдын 8.7 хувь нь 2011 онд хөрөнгө оруулалт хийжээ.

ЗУРАГ 4.11. БИЧИЛ УУРХАЙ ЭРХЛЭГЧДИЙН 2011 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХУВЬ, бүсээр



Нийт бичил уурхай эрхлэгчид 2011 онд 2148.6 сая төгрөгийн хөрөнгө оруулалтыг хийснээс барилга байшинд 244.1 сая төг буюу 11.4 хувь, тээврийн хэрэгсэлд 1211.7 сая төг буюу 56.4 хувь, тоног төхөөрөмжид 654.0 сая төг буюу 30.4 хувь, бусад хөрөнгөд 38.9 сая төгрөг буюу 1.8 хувийн хөрөнгө оруулалтыг тус тус хийсэн байна. Баруун бүсийн бичил уурхай эрхлэгчид 488.0 сая төг, хангайн бүсийнх 376.5 сая төг, төвийн бүсийнх 921.4 сая төг, зүүн бүсийнх 321.5 сая төг, Улаанбаатар хотынх 41.1 сая төгрөгийн хөрөнгө оруулалтыг тус тус хийсэн байна.

**ХҮСНЭГТ 4.12. 2011 ОНД ХИЙСЭН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХЭМЖЭЭ,
хөрөнгийн төрөл, бүсээр**

сая.төг

Бүс	Нийт хөрөнгө оруулалт	Төрөл			Бусад
		Байшин барилга	Тээврийн хэрэгсэл	Тоног, Төхөөрөмж	
БҮГД	2 148.6	244.1	1 211.7	654.0	38.9
Баруун бүс	488.0	32.5	314.7	136.4	4.5
Хангайн бүс	376.5	62.1	152.4	148.8	13.3
Төвийн бүс	921.4	149.5	502.5	253.3	16.1
Зүүн бүс	321.5	-	230.1	86.4	5.0
Улаанбаатар	41.1	-	12.0	29.1	-
Нийт хөрөнгө оруулалтад эзлэх хувь	100.0	11.4	56.4	30.4	1.8

Алт олборлогчид 1455.5 сая төг, нүүрс олборлогчид 53.1 сая төг, жонш олборлогчид 589.2 сая төг, гянтболд 8.4 сая төг, бусад ашигт малтмал олборлогчид 42.4 сая төгрөгийн хөрөнгө оруулалтыг хийсэн байна. Алт олборлогчдын нийт хөрөнгө оруулалтын 53.8 хувь нь тээврийн хэрэгсэл, 32.0 хувь нь тоног төхөөрөмжийн, нүүрс олборлогчдын 45.2 хувь нь тээврийн хэрэгсэл, 54.8 хувь нь тоног төхөөрөмж, жонш олборлогчдын 62.0 хувь нь тээврийн хэрэгсэл, 25.2 хувь нь тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулалт эзэлж байна.

**ХҮСНЭГТ 4.13. 2011 ОНД ХИЙСЭН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХЭМЖЭЭ,
хөрөнгийн төрөл, ашигт малтмалын төрлөөр**

сая.төг

Ашигт малтмалын төрөл	Нийт хөрөнгө оруулалт	Төрөл			Бусад
		Байшин барилга	Тээврийн хэрэгсэл	Тоног, Төхөөрөмж	
БҮГД	2 148.6	244.1	1 211.7	654	38.9
Алт	1 455.5	172.7	783.6	465.6	33.7
Нүүрс	53.1	-	24	29.1	-
Жонш	589.2	71.4	365.5	148.7	3.6
Гянтболд	8.4	-	4.8	3.4	0.2
Бусад	42.4	-	33.8	7.2	1.5

ТАВДУГААР БҮЛЭГ

АШИГТ МАЛТМАЛЫН
ОЛБОРЛОЛТООС УЧИРСАН
ХОХИРОЛ, ОРОН НУТАГТ ОРУУЛСАН
ХУВЬ НЭМЭР, ТУЛГАРЧ БУЙ
ХҮНДРЭЛ, БЭРХШЭЭЛ

АШИГТ МАЛТМАЛЫН ОЛБОРЛОЛТООС УЧИРСАН ХОХИРОЛ, ОРОН НУТАГТ ОРУУЛСАН ХУВЬ НЭМЭР, ХҮНДРЭЛ БЭРХШЭЭЛ

5.1. АШИГТ МАЛТМАЛЫН ОЛБОРЛОЛТООС УЧИРСАН ХОХИРОЛ

Бичил уурхайн үйл ажиллагаа эрхэлж байгаа иргэд хөдөлмөр хамгааллын аюулгүй ажиллагааг хангаагүйгээс үүдэн осол аваарт өртөх явдал тохиолддог. Тиймээс энэ хэсэгт бичил уурхай эрхлэгчдийн үйл ажиллагаа эрхлэх явцад өртөж байсан осол гэмтэл, тэдэнд учирсан хохирол, өвчилж байсан өвчний төрөл, эмнэлгийн тусламжийн хүртээмж зэргийг тусгалаа.

Судалгааны дүнгээр судалгаанд хамрагдсан бичил уурхай эрхлэгчдийн 93.8 хувь нь үйл ажиллагаа эрхлэх явцдаа осол, аваарт өртөж байгаагүй гэж хариулсан байна. Харин үлдсэн 6.2 хувь нь ямар нэгэн осол, аваарт өртөж байсан бөгөөд давхардсан тоогоор тэдний 32.0 хувь нь нүхэнд унах, 29.3 хувь нь шороонд дарагдах, 28.0 хувь нь агааргүйтэх, 4.4 хувь нь хөлдөх, 1.9 хувь нь түлэгдэх, 4.4 хувь нь бусад төрлийн осолд өртөж байжээ.

ЗУРАГ 5.1. БИЧИЛ УУРХАЙ ЭРХЛЭГЧДИЙН ӨРТӨЖ БАЙСАН ОСОЛ, АВААРЫН ТӨРӨЛ, хувиар



Бичил уурхайн үйл ажиллагаа эрхлэх явцдаа ямар нэгэн осол, аваарт өртөж байсан хүмүүсийг бүсийн түвшинд авч үзэхэд агааргүйтэх осолд өртөгсдийн 53.1 хувь нь төвийн бүсийнх, 32.3 хувь нь хангайн бүсийнх бол шороонд дарагдах осолд өртөгсдийн 45.3 хувь нь төвийн бүсэд, 32.3 хувь нь хангайн бүсэд ногдож байна. Түлэгдэх осолд өртөгсдийн 61.5 хувь нь хангайн бүсийнх, 23.1 хувь нь төвийн бүсийнх, 15.4 хувь нь баруун бүсийнх байна.

ХҮСНЭГТ 5.1. БИЧИЛ УУРХАЙ ЭРХЛЭГЧДИЙН ӨРТӨЖ БАЙСАН ОСОЛ, аваарын төрөл, бүсээр, хувиар


Бүс	Агаар-гүйтэх	Шороонд дарагдах	Түлэгдэх	Хөлдөх	Нүхэнд унах	Бусад төрлийн осол
БҮГД	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
Баруун бүс	6.8	14.9	15.4	26.7	21.9	13.3
Хангайн бүс	32.3	32.3	61.5	43.3	43.4	36.7
Төвийн бүс	53.1	45.3	23.1	26.7	31.1	23.4
Зүүн бүс	-	0.5	-	3.3	0.9	3.3
Улаанбаатар	7.8	7.0	-	-	2.7	23.3

Харин хөлдөх осолд өртөгсдийн 43.3 хувь нь хангайн бүсийн бичил уурхай эрхлэгчид байгаа бол 26.7 хувь нь баруун бүсийнх, мөн 26.7 хувь нь төвийн бүсийн бичил уурхайчид байна. Нүхэнд унах осолд өртөгсдийн 43.4 хувь нь хангайн бүсийнх, 31.1 хувь нь төвийн бүсийнх, 21.9 хувь нь баруун бүсийнх байна.

Түүнчлэн бусад төрлийн осол, аварт өртсөн бичил уурхай эрхлэгчдийн 36.7 хувь нь хангайн бүсэд, 23.3 хувь нь Улаанбаатар хотод, 23.4 хувь нь төвийн бүсэд, 13.3 хувь нь баруун бүсэд тус тус ногдож байна. Эндээс хангайн болон төвийн бүсэд бичил уурхай эрхэлж байгаа хүмүүс осол, аварт их өртсөн нь харагдаж байна.

Уурхайн үйл ажиллагаанаас учирсан хохирлыг эрүүл мэндээр хохирсон, эд материалаар хохирсон гэж ангилдаг. Эрүүл мэндээрээ хохирсон бичил уурхайчдын 28.8 хувь нь агааргүйтэх ослоос, 30.2 хувь нь шороонд дарагдсанаас, 30.6 хувь нь нүхэнд унаснаас болж хохирсон бол эд материалын хохирол амссан бичил уурхай эрхлэгчдийн 22.8 хувь нь агааргүйтэх ослоос, 35.1 хувь нь шороонд дарагдсанаас, 34.5 хувь нь нүхэнд унаснаас шалтгаалж хохирсон байна.


ЗУРАГ 5.2. БИЧИЛ УУРХАЙ ЭРХЛЭГЧДЭД УЧИРСАН ХОХИРЛЫН ТӨРӨЛ, хувиар



Судалгааны дүнгээр судалгаанд хамрагдсан бичил уурхай эрхлэгчдийн 70.0 хувь нь бичил уурхайн үйл ажиллагаа эрхлэх явцдаа ямар нэгэн өвчин, эмгэг тусч байгаагүй бол үлдсэн 30.0 хувь нь өвчилж байжээ.

Бичил уурхайн үйл ажиллагаа эрхлэх явцад өвчин, эмгэг туссан иргэдийн 48.2 хувь нь ууц нурууны өвчин, 23.9 хувь нь амьсгалын тогтолцооны өвчин, 7.3 хувь нь яс, булчингийн тогтолцоо ба холбох эдийн өвчин, 6.2 хувь нь хоол боловсруулах замын өвчин, 4.9 хувь нь зүрх, судасны тогтолцооны өвчин, үлдсэн 9.5 хувь нь бусад төрлийн өвчин (арьс ба арьсан доорх эслэгийн өвчин, шээс бэлгийн тогтолцооны эмгэг, гэмтэл хордлого ба гадны шалтгаант бусад тодорхой эмгэг, мэдрэлийн тогтолцооны өвчин, халдварт ба шимэгчит зарим өвчин) туссан байна.

ЗУРАГ 5.3. БИЧИЛ УУРХАЙ ЭРХЛЭГЧДИЙН ТУССАН ӨВЧИН, өвчний төрлөөр, хувиар



Өвчний төрлийг хүйсээр нь авч үзвэл амьсгалын тогтолцооны өвчнөөр өвчилсөн бичил уурхай эрхлэгчдийн 84.4 хувь нь эрэгтэйчүүд, 15.6 хувь нь эмэгтэйчүүд байгаа бол ууц нурууны өвчнөөр өвчлөгсөдийн 81.4 хувь нь эрэгтэйчүүд, 18.6 хувь нь эмэгтэйчүүд байна. Цаашилбал, хоол боловсруулах замын өвчнөөр өвчлөгсөдийн 75.0 хувь нь эрэгтэйчүүд, 25.0 хувь нь эмэгтэйчүүд, зүрх, судасны тогтолцооны өвчнөөр өвчлөгсөдийн 68.6 хувь нь эрэгтэйчүүд, 31.4 хувь нь эмэгтэйчүүд, арьс ба арьсан доорх эслэгийн өвчнөөр өвчлөгсөдийн 85.8 хувь нь эрэгтэйчүүд, 14.2 хувь нь эмэгтэйчүүд байна.

Түүнчлэн яс, булчингийн тогтолцоо болон холбох эдийн өвчнөөр өвчлөгсөдийн 76.9 хувь нь эрэгтэйчүүд, 23.1 хувь нь эмэгтэйчүүд, шээс бэлгийн тогтолцооны эмгэг өвчнөөр өвчлөгсөдийн 65.0 хувь нь эрэгтэйчүүд, 35.0 хувь нь эмэгтэйчүүд, гэмтэл хордлого болон гадны шалтгаант бусад тодорхой эмгэг өвчнөөр өвчлөгсөдийн 89.1 хувь нь эрэгтэйчүүд, 10.9 хувь нь эмэгтэйчүүд, мэдрэлийн тогтолцооны өвчнөөр өвчлөгсөдийн 65.1 хувь нь эрэгтэйчүүд, 34.9 хувь нь эмэгтэйчүүд, халдварт ба шимэгчит зарим өвчнөөр өвчлөгсөдийн 63.6 хувь нь эрэгтэйчүүд, 36.4 хувь нь эмэгтэйчүүд тус тус байна.

ХҮСНЭГТ 5.2. БИЧИЛ УУРХАЙ ЭРХЛЭГЧДИЙН ӨВЧИЛСӨН ӨВЧИН, төрлөөр, ажилласан жилээр, хувиар

Өвчний төрөл	Ажилласан жилийн бүлэг							БҮГД
	Нэг хүртэлх жил	2-3	4-5	6-7	8-9	10-11	12 ба түүнээс дээш жил	
Амьсгалын тогтолцооны өвчин	14.4	28.2	18.2	10.4	6.6	11.1	11.1	100.0
Ууц нурууны өвчин	11.7	27.0	18.0	9.9	8.4	12.9	12.1	100.0
Хоол боловсруулах замын өвчин	17.4	21.3	21.2	8.7	8.3	12.1	11.0	100.0
Зүрх, судасны тогтолцооны өвчин	15.9	19.9	16.4	7.2	7.7	17.4	15.5	100.0
Арьс ба арьсан доорх эслэгийн өвчин	21.6	40.5	14.2	3.8	5.7	10.4	3.8	100.0
Яс, булчингийн тогтолцоо ба холбогдох эдийн өвчин	10.6	17.9	14.1	8.3	12.5	16.7	19.9	100.0
Шээс бэлгийн тогтолцооны эмгэг	12.9	24.9	17.8	10.0	7.9	17.9	8.6	100.0
Гэмтэл хордлого ба гадны шалтгаант бусад тодорхой эмгэг	20.3	10.9	10.9	12.5	10.9	12.5	22.0	100.0
Мэдрэлийн тогтолцооны өвчин	9.3	15.1	15.1	2.3	4.7	44.2	9.3	100.0
Халдварт ба шимэгчит зарим өвчин	27.2	27.3	9.1	18.2	-	9.1	9.1	100.0

Бичил уурхай эрхлэгчдийн үйл ажиллагаа эрхлэх явцдаа өвчилж байсан өвчний төрлийг бичил уурхайд ажилласан жилээр нь авч үзвэл амьсгалын тогтолцооны өвчнөөр өвчлөгсөдийн 28.2 хувь нь 2-3 жил, 18.2 хувь нь 4-5 жил ажилласан бол ууц нурууны өвчнөөр өвчлөгсөдийн 27.0 хувь нь 2-3 жил, 18.0 хувь нь 4-5 жил ажилласан хүмүүс байна.

Хоол боловсруулах замын өвчнөөр өвчлөгсөдийн 21.3 хувь нь 2-3 жил, 21.2 хувь нь 4-5 жил, зүрх, судасны тогтолцооны өвчнөөр өвчлөгсөдийн 19.9 хувь нь 2-3 жил, 17.4 хувь нь 10-11 жил, шээс бэлгийн тогтолцооны эмгэгээр өвчлөгсөдийн 24.9 хувь нь 2-3 жил, 17.9 хувь нь 10-11 жил ажилласан хүмүүс байна.

Цаашлаад гэмтэл хордлого ба гадны шалтгаант бусад тодорхой эмгэгээр өвчлөгсөдийн 22.0 хувь нь 12 ба түүнээс дээш жил, 20.3 хувь нь нэг хүртэлх жил ажилласан хүмүүс байна. Мөн мэдрэлийн тогтолцооны өвчнөөр өвчлөгсөдийн 44.2 хувь нь 10-11 жил, 15.1 хувь нь тус тус 2-3 болон 4-5 жил, халдварт ба шимэгчит зарим өвчнөөр өвчлөгсөдийн 27.3 хувь нь 2-3 жил, 27.2 хувь нь нэг хүртэлх жил ажилласан хүмүүс байна. Үүнээс үзэхэд бичил уурхайд 2-5 жил ажилласан хүмүүс бүх төрлийн өвчнөөр илүү их өвчилжээ гэж хэлж болохоор байна.

ХҮСНЭГТ 5.3. БИЧИЛ УУРХАЙ ЭРХЛЭГЧДИЙН ӨВЧЛӨЛТ, өвчний төрөл, бүс, хувиар

Өвчний төрөл	Бүс					БҮГД
	Баруун бүс	Хангайн бүс	Төвийн бүс	Зүүн бүс	Улаанбаатар	
Амьсгалын тогтолцооны өвчин	15.1	31.6	39.6	1.3	12.4	100.0
Ууц нурууны өвчин	16.0	33.1	44.1	1.8	5.0	100.0
Хоол боловсруулах замын өвчин	8.0	45.8	39.4	1.9	4.9	100.0
Зүрх, судасны тогтолцооны өвчин	8.2	37.7	47.9	1.9	4.3	100.0
Арьс ба арьсан доорх эслэгийн өвчин	32.1	32.0	30.2	1.9	3.8	100.0
Яс, булчингийн тогтолцоо ба холбогдох эдийн өвчин	9.9	25.3	57.8	1.9	5.1	100.0
Шээс бэлгийн тогтолцооны эмгэг	9.3	43.6	43.5	2.9	0.7	100.0
Гэмтэл хордлого ба гадны шалтгаант бусад тодорхой эмгэг	14.1	40.5	29.7	1.6	14.1	100.0
Мэдрэлийн тогтолцооны өвчин	7.0	68.6	20.9	2.3	1.2	100.0
Халдварт ба шимэгчит зарим өвчин	18.2	54.5	27.3	-	-	100.0

Бичил уурхай эрхлэгчдийн үйл ажиллагаа эрхлэх явцдаа өвчилж байсан өвчний төрлийг бүсээр нь авч үзвэл хангайн болон төвийн бүсэд нийт өвчлөгчдийн дийлэнх нь байна.

Тухайлбал, амьсгалын тогтолцооны өвчнөөр өвчлөгсөдийн хамгийн их буюу 39.6 хувь нь төвийн бүсэд бол ууц нурууны өвчнөөр өвчлөгсөдийн 44.1 хувь нь төвийн бүсэд, хоол боловсруулах замын өвчнөөр өвчлөгсөдийн 45.8 хувь нь хангайн бүсэд, 39.4 хувь нь төвийн бүсэд, зүрх, судасны тогтолцооны өвчнөөр өвчлөгсөдийн 47.9 хувь нь төвийн бүсэд, 37.7 хувь нь хангайн бүсэд, арьс ба арьсан доорх эслэгийн өвчнөөр өвчлөгсөдийн 32.1 хувь нь баруун бүсэд, 32.0 хувь нь хангайн бүсэд, 30.2 хувь нь төвийн бүсэд, яс, булчингийн тогтолцоо ба холбогдох эдийн өвчнөөр өвчлөгсөдийн 57.8 хувь нь төвийн бүсэд, 25.3 хувь нь хангайн бүсэд тус тус ногдож байна.

Түүнчлэн шээс бэлгийн тогтолцооны эмгэгээр өвчлөгсөдийн 43.6 хувь нь хангайн бүсэд, 43.5 хувь нь төвийн бүсэд, гэмтэл хордлого ба гадны шалтгаант бусад тодорхой эмгэгээр өвчлөгсөдийн 40.5 хувь нь хангайн бүсэд, 29.7 хувь нь төвийн бүсэд, мэдрэлийн тогтолцооны өвчнөөр өвчлөгсөдийн 68.6 хувь нь хангайн бүсэд, 20.9 хувь нь төвийн бүсэд, халдварт ба шимэгчит зарим өвчнөөр өвчилсөн бичил уурхайчдын 54.5 хувь нь хангайн бүсэд, 27.3 хувь нь төвийн бүсэд харьяалагдаж байна.

Судалгаанд хамрагдсан бичил уурхай эрхлэгчдээс эмнэлгийн тусламж авах боломжийн талаарх асуулгыг асууж үр дүнг тусгалаа. Нийт 8702 бичил уурхай эрхлэгчдийн 8014 хүн буюу 92.1 хувь нь үйл ажиллагаа эрхэлж буй сум, дүүргийнхээ эмнэлгийн тусламж авах боломжтой гэж үзжээ.

Бичил уурхай эрхлэгчдийн хувьд хамгийн хол зайтай эмнэлэг 200 км-т байрладаг бол хамгийн ойр зайтай эмнэлэг 1 км-т байрладаг ажээ. Бичил уурхайн үйл ажиллагаа явуулж буй орд, газраас эмнэлэг хүрэх дундаж зай улсын хэмжээнд 33.8 км байна.

**ХҮСНЭГТ 5.4. БИЧИЛ УУРХАЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БҮЙ СУМ,
ДҮҮРГИЙН ЭМНЭЛГИЙН ЗАЙ, км-ээр**

Бүс, аймаг, нийслэл,	Хамгийн хол зай	Хамгийн ойр зай	Дундаж зай
Улсын дундаж	200.0	1.0	33.8
Баруун бүс	200.0	1.0	42.8
Баян-Өлгий	58.0	5.0	27.0
Говь-Алтай	95.0	7.0	40.8
Завхан	55.0	50.0	50.3
Увс	85.0	1.0	40.2
Ховд	200.0	15.0	55.8
Хангайн бүс	130.0	2.0	40.1
Архангай	30.0	2.0	12.5
Баянхонгор	114.0	10.0	29.0
Булган	55.0	15.0	40.9
Өвөрхангай	47.0	7.0	18.1
Хөвсгөл	130.0	70.0	116.8
Төвийн бүс	120.0	1.0	29.7
Дархан-Уул	75.0	5.0	16.8
Дорноговь	59.0	2.0	26.3
Дундговь	70.0	4.0	28.8
Өмнөговь	120.0	11.0	56.9
Сэлэнгэ	120.0	3.0	42.3
Төв	70.0	1.0	23.6
Зүүн бүс	50.0	1.0	22.8
Дорнод	42.0	14.0	33.8
Сүхбаатар	45.0	45.0	45.0
Хэнтий	50.0	1.0	17.7
Улаанбаатар	45.0	1.0	6.8

Бичил уурхай эрхэлж буй иргэдийн үйл ажиллагаа явуулж байгаа газраас тухайн сум, дүүргийн эмнэлэг орох зайг бүсийн түвшинд авч үзвэл баруун бүсийн хувьд хамгийн хол эмнэлэг нь Ховд аймагт (200 км) байдаг бол хамгийн ойр зайтай эмнэлэг нь Увс аймагт (1 км) байдаг ажээ. Харин хангайн бүсийн хувьд хамгийн хол зайтай эмнэлэг нь Хөвсгөл аймагт (130 км) байдаг бол хамгийн ойр зайтай эмнэлэг нь Архангай аймагт (2 км) байдаг байна.

Төвийн бүсийн бичил уурхай эрхлэгчдийн хувьд хамгийн хол эмнэлэг нь Өмнөговь, Сэлэнгэ аймагт тус тус (120 км) байдаг бол хамгийн ойр зайтай эмнэлэг нь Төв аймагт (1 км) байдаг байна. Зүүн бүсийн хувьд хамгийн хол эмнэлэг нь Хэнтий аймагт (50 км) байдаг бол хамгийн ойр зайтай эмнэлэг нь мөн л тус аймагт (1 км) байдаг байна. Улаанбаатар хотын бичил уурхай эрхлэгчид хувьд хамгийн хол зайтай эмнэлэг 45 км-т оршдог бол хамгийн ойрхон нь 1 км-т оршиж байна.

Харин судалгаанд хамрагдсан бичил уурхай эрхлэгчдийн 7.9 хувь нь үйл ажиллагаа эрхэлж буй орд газрынхаа сум, дүүргээс бусад сум, дүүргийн эмнэлгийн тусламжийг авдаг гэж хариулжээ. Улсын хэмжээнд бичил уурхайчдын хувьд бусад сум, дүүргийн эмнэлэг орох хамгийн хол зай 130 км байгаа бол хамгийн ойр зай 3 км, дундаж зай 57.6 км байна.


Төвийн бүсийн хувьд Дорноговь, Сэлэнгэ, Төв аймгийн зарим бичил уурхайчид өөр сумын эмнэлгийн тусламжийг авдаг гэж хариулсан бөгөөд хамгийн хол зайтай эмнэлэг (45 км) нь Сэлэнгэ аймагт, ойр зайтай эмнэлэг (8 км) нь Төв аймагт байдаг байна. Зүүн бүсийн хувьд зөвхөн Хэнтий аймагт үйл ажиллагаа явуулж байгаа зарим бичил уурхайчид өөр сумын эмнэлэгт үзүүлдэг бөгөөд хамгийн хол зайтай эмнэлэг нь 18 км-т, ойр зайтай эмнэлэг нь 3 км-т байрлаж байна.

5.2. НИЙГЭМ, ОРОН НУТАГТ ОРУУЛСАН ХУВЬ НЭМЭР

Энэ хэсэгт бичил уурхай эрхлэгчдийн 2011 онд нийгмийн болон эрүүл мэндийн даатгалд хамрагдсан байдал, бичил уурхайн үйл ажиллагаа эрхэлснээр тэдний амьдралд гарсан өөрчлөлт, цаашилбал тэдний тухайн сум, дүүрэг, орон нутгийн хөгжилд оруулсан хувь нэмэр, төрийн болон төрийн бус байгууллагаас тэдэнд үзүүлсэн дэмжлэг, туслалцаа ямар байдаг талаар авч үзнэ.

Судалгаанд хамрагдсан бичил уурхай эрхлэгчдийн 67.5 хувь 2011 онд даатгалд хамрагдсан гэж хариулсан байна.

ЗУРАГ 5.4. БИЧИЛ УУРХАЙ ЭРХЛЭГЧДИЙН ДААТГАЛД ХАМРАГДСАН БАЙДАЛ, даатгалын төрлөөр, хувиар



Нийт даатгалд хамрагдсан иргэдийн 76.8 хувь нь эрүүл мэндийн даатгал, 20.8 хувь нь нийгмийн даатгалд, 1.4 хувь нь ажилгүйдлийн даатгал, 0.9 хувь бусад төрлийн даатгал байна.

Эрүүл мэндийн даатгалд хамрагдсан бичил уурхай эрхлэгчдийн 37.2 хувь нь төвийн бүсэд, 32.6 хувь нь хангайн бүсэд, 23.2 хувь нь баруун бүсэд харьяалагдаж байгаа бол нийгмийн даатгалын шимтгэл төлсөн бичил уурхай эрхлэгчдийн 55.7 хувь нь төвийн бүсэд, 18.2 хувь нь хангайн бүсэд, 15.8 хувь нь баруун бүсэд тус тус ногдож байна.


Ажилгүйдлийн даатгалд хамрагдсан бичил уурхай эрхлэгчдийн 45.3 хувь нь төвийн бүсэд, хангайн болон баруун бүсэд 24.1 хувь нь тус бүр харьяалагдаж байгаа бол бусад төрлийн даатгалд хамрагдсан бичил уурхайчдын 78.4 хувь нь төвийн бүсэд, 10.1 хувь нь баруун бүсэд ногдож байна.

ХҮСНЭГТ 5.5. БИЧИЛ УУРХАЙ ЭРХЛЭГЧДИЙН 2011 ОНД ДААТГАЛД ХАМРАГДСАН БАЙДАЛ, даатгалын төрлөөр, бүсээр, хувиар

Бүс	Эрүүл мэндийн даатгал	Нийгмийн даатгал	Ажилгүйдлийн даатгал	Бусад
БҮГД	100.0	100.0	100.0	100.0
Баруун бүс	23.2	15.8	24.1	10.1
Хангайн бүс	32.6	18.2	24.1	7.2
Төвийн бүс	37.2	55.7	45.3	78.4
Зүүн бүс	3.3	5.9	5.6	4.3
Улаанбаатар	3.7	4.4	0.9	-

Бичил уурхай эрхэлснээр давхардсан тоогоор 4996 иргэн өрхийн амьжиргааны орлогын эх үүсвэртэй болсон бол 1454 иргэн байнгын ажлын байртай болжээ. Түүнчлэн 1122 иргэн хувийн тээврийн хэрэгсэлтэй болж, 1092 иргэн сургалтын төлбөр төлжээ. Харин 346 иргэн хувийн сууцтай болсон байна.

ЗУРАГ 5.5. БИЧИЛ УУРХАЙ ЭРХЛЭГЧДИЙН АМЬЖИРГААНД ГАРСАН ӨӨРЧЛӨЛТ, хүйсээр, хувиар




Байнгын ажлын байртай болсон бичил уурхай эрхлэгчдийн 82.2 хувь нь, өрхийн амьжиргааны орлогын эх үүсвэртэй болсон бичил уурхай эрхлэгчдийн 83.4 хувь нь, хувийн сууцтай болсон бичил уурхай эрхлэгчдийн 84.1 хувь нь, хувийн тээврийн хэрэгсэлтэй болсон бичил уурхай эрхлэгчдийн 86.1 хувь нь, сургалтын төлбөрөө төлсөн бичил уурхай эрхлэгчдийн 79.2 хувь нь эрэгтэйчүүд байна.

Бичил уурхай эрхлэгчдийн амьжиргаанд гарсан өөрчлөлтийг насны бүлгээр нь авч үзвэл байнгын ажлын байртай болсон бичил уурхай эрхлэгчдийн 96.9 хувь нь, өрхийн амьжиргааны орлогын эх үүсвэртэй болсон бичил уурхай эрхлэгчдийн 97.0 хувь нь, хувийн сууцтай болсон бичил уурхай эрхлэгчдийн 98.6 хувь нь, хувийн тээврийн хэрэгсэлтэй болсон бичил уурхай эрхлэгчдийн 98.8 хувь нь, сургалтын төлбөр төлсөн бичил уурхай эрхлэгчдийн 94.9 хувь нь 20-59 насны хүмүүс байна.


Бичил уурхай эрхлэгчдээс нийгэм, орон нутагт оруулсан хувь нэмрийнх нь талаар судлахад тэдний 81.6 хувь нь ямар нэгэн хувь нэмэр оруулаагүй байна. Харин үлдсэн 18.4 хувь нь тодорхой хэмжээний хувь нэмэр оруулсан гэж хариулжээ.

ЗУРАГ 5.6. БИЧИЛ УУРХАЙ ЭРХЛЭГЧДИЙН ОРОН НУТАГТАА ОРУУЛСАН ХУВЬ НЭМЭР, төрлөөр, хувь, хүний тоогоор



Нийгэм, орон нутагт хувь нэмэр оруулсан гэж хариулсан бичил уурхай эрхлэгчдийн орон нутагтаа оруулсан хувь нэмрийг ашигт малтмалын төрлөөр нь авч үзвэл давхардсан тоогоор байнгын ажлын байр бий болсон гэж хариулсан бичил уурхай эрхлэгчдийн 65.0 хувь нь алт олборлогчид, 29.8 хувь нь жонш олборлогчид, 4.3 хувь нь бусад ашигт малтмал олборлогчид, 0.9 хувь нь нүүрс олборлогчид байна. Түүнчлэн орон нутагт мөнгөн хандив өгсөн болон орон нутгийн тохижуулалтад биечлэн оролцсон бичил уурхай эрхлэгчдийн 68.5 болон 79.3 хувь нь алт олборлогчид, 27.0 болон 13.9 хувь нь жонш олборлогчид байна.

ЗУРАГ 5.7. БИЧИЛ УУРХАЙ ЭРХЛЭГЧДИЙН НИЙГЭМ, ОРОН НУТАГТ ОРУУЛСАН ХУВЬ НЭМЭР, ашигт малтмалын төрлөөр, хувиар



Байнгын ажлын байр бий болгосон гэж хариулсан бичил уурхай эрхлэгчдийн 56.5 хувь нь төвийн бүсийн, 20.8 хувь нь хангайн бүсийн, 14.4 хувь нь баруун бүсийн бичил уурхай эрхлэгчид байна. Орон нутагт мөнгөн хандив өгсөн гэж хариулсан бичил уурхай эрхлэгчдийн 38.5 хувь нь хангайн бүсэд, 32.7 хувь нь төвийн бүсэд, 21.0 хувь нь баруун бүсэд ногдож байна. Орон нутгийн тохижуулалтад биечлэн оролцсон гэж хариулсан бичил уурхай эрхлэгчдийн 53.8 хувь нь төвийн бүсэд, 18.6 хувь нь баруун бүсэд, 17.5 хувь нь хангайн бүсэд үйл ажиллагаа явуулдаг байна.

Судалгаанд хамрагдсан бичил уурхай эрхлэгчдээс үйл ажиллагаа явуулахдаа авч байсан тусламж, дэмжлэгийн талаарх асуусан асуултанд тэдний 1568 нь буюу 18.0 хувь нь ямар нэгэн тусламж, дэмжлэг авч байсан бол харин 7134 нь буюу 82.0 хувь нь авч байгаагүй гэж хариулсан байна.

ХҮСНЭГТ 5.6. БИЧИЛ УУРХАЙ ЭРХЛЭГЧДИЙН ТӨРИЙН БОЛОН ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГААС ТУСЛАМЖ, ДЭМЖЛЭГ АВСАН БАЙДАЛ, бүсээр

Бүс	Дэмжлэг авсан хүн		Дэмжлэг аваагүй хүн		Нийт хүн	
	Тоо	%	Тоо	%	Тоо	%
БҮГД	1 568	18.0	7 134	82.0	8 702	100.0
Баруун бүс	206	10.0	1 845	90.0	2 051	100.0
Хангайн бүс	564	21.4	2 069	78.6	2 633	100.0
Төвийн бүс	770	25.1	2 301	74.9	3 071	100.0
Зүүн бүс	25	7.7	301	92.3	326	100.0
Улаанбаатар	3	0.5	618	99.5	621	100.0

Судалгааны дүнгээр төвийн бүсээс 770 бичил уурхайчин, хангайн бүсээс 564, баруун бүсээс 206, зүүн бүсээс 25, Улаанбаатар хотоос 3 бичил уурхайчин тус тус төрийн болон төрийн бус байгууллагын тусламж, дэмжлэгт хамрагдсан байна.

Судалгааны дүнгээр төрийн болон төрийн бус байгууллагаас ямар нэгэн тусламж, дэмжлэг авч байсан бичил уурхай эрхлэгчдээс давхардсан тоогоор 1054 хүн мэргэжлийн зөвлөгөө авч, 1328 хүн сургалтад хамрагджээ. Түүнчлэн 9 хүн буцалтгүй тусламж, 5 хүн хөнгөлөлттэй үнээр тоног төхөөрөмж, 5 хүн хөнгөлөлттэй зээл авчээ.

ХҮСНЭГТ 5.7. БИЧИЛ УУРХАЙ ЭРХЛЭГЧДИЙН ТӨРИЙН БОЛОН ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГААС АВСАН ТУСЛАМЖ, ДЭМЖЛЭГИЙН ХЭЛБЭР, бүсээр

Тусламж, дэмжлэгийн төрөл	Бүс					БҮГД
	Баруун бүс	Хангайн бүс	Төвийн бүс	Зүүн бүс	Улаанбаатар	
Мэргэжлийн зөвлөгөө өгсөн	17.0	36.8	44.2	1.8	0.2	100.0
Сургалтанд хамруулсан	8.8	37.5	53.2	0.5	-	100.0
Тоног төхөөрөмжийг хөнгөлөлттэй үнээр өгсөн	-	20.0	80.0	-	-	100.0
Хөнгөлөлттэй зээл олгосон	-	-	60.0	40.0	-	100.0
Буцалтгүй тусламж олгосон	11.1	22.2	44.5	11.1	11.1	100.0
Бусад	-	-	-	100.0	-	100.0

Мэргэжлийн зөвлөгөө авсан бичил уурхай эрхлэгчдийн 44.2 хувь нь төвийн бүсэд, 36.8 хувь нь хангайн бүсэд, 17.0 хувь нь баруун бүсэд харьяалагдаж байгаа бол сургалтад хамрагдсан бичил уурхай эрхлэгчдийн 53.2 хувь нь төвийн бүсэд, 37.5 хувь нь хангайн бүсэд, 8.8 хувь нь баруун бүсэд ногдож байна. Буцалтгүй тусламж авсан бичил уурхай эрхлэгчдийн 44.5 хувь нь төвийн бүсийн бичил уурхай эрхлэгчид байгаа бол 22.2 нь хангайн бүсийнх байна.

5.3. БИЧИЛ УУРХАЙ ЭРХЛЭГЧДЭД ТУЛГАРЧ БУЙ ХҮНДРЭЛ, БЭРХШЭЭЛ

Энэ хэсэгт бичил уурхай эрхлэгчдэд үйл ажиллагаагаа явуулахад болон засаг, захиргааны байгууллагуудтай харьцахад тулгардаг хүндрэл, бэрхшээл, тэдгээр хүндрэлүүдийг шийдвэрлэсэн байдал, түүнчлэн олборлосон ашигт малтмалаа борлуулахад гардаг хүндрэлтэй асуудлууд, ашигт малтмал олборлох газрын зөвшөөрлийг шийдвэрлэсэн байдал, бичил уурхай эрхлэгчдийн төрийн болон төрийн бус байгууллагаас авахыг хүсдэг тусламж, дэмжлэгийн талаар тодорхойлно.

Судалгаанд хамрагдсан бичил уурхай эрхлэгчдийн 1616 нь буюу 18.6 хувь нь ямар нэгэн хүндрэл, бэрхшээл тулгардаггүй гэж хариулсан байна.

Харин үлдсэн 7086 бичил уурхай эрхлэгчид буюу 81.4 хувь нь хамгийн их тохиолддог хүндрэл, бэрхшээлүүдээ нэрлэсэн байна. Судалгааны дүнгээр хууль эрх зүйн орчин боломжийн түвшинд бүрдээгүй гэж 2517 (давхардсан тоогоор) уурхайчин үзсэн бөгөөд тэдний 40.8 хувь нь төвийн бүсэд, 35.0 хувь нь хангайн бүсэд, 20.3 хувь нь баруун бүсэд тус тус харьяалагдаж байна. Ашигт малтмалын гарц муу байдаг гэж 3586 (давхардсан тоогоор) уурхайчин үзсэн бөгөөд тэдний 36.3 хувь нь төвийн бүсэд, 31.3 хувь нь хангайн бүсэд, 26.9 хувь нь баруун бүсэд ногдож байна.

ХҮСНЭГТ 5.8. БИЧИЛ УУРХАЙ ЭРХЛЭГЧДЭД ТУЛГАРДАГ ХҮНДРЭЛ, БЭРХШЭЭЛ, бүсээр, хувиар

Хүндрэл, бэрхшээлийн төрөл	Бүс					БҮГД
	Баруун бүс	Хангайн бүс	Төвийн бүс	Зүүн бүс	Улаанбаатар	
Хүндрэл, бэрхшээл тулгардаггүй	27.7	33.1	19.2	5.0	15.0	100.0
Хууль эрх зүйн орчин боломжийн түвшинд бүрдээгүй	20.3	35.0	40.8	3.1	1.0	100.0
Ашигт малтмалын гарц муу	26.9	31.3	36.3	4.4	1.1	100.0
Үйл ажиллагаа явуулах газар хязгаарлагдмал	18.8	31.8	43.9	3.7	1.8	100.0
Санхүүгийн асуудал хүндрэлтэй (зээл авах)	25.3	21.6	37.8	3.4	11.9	100.0
Тоног төхөөрөмж дутагдалтай, хүчин чадал муу	34.1	25.0	24.2	3.0	13.6	100.0
Зохион байгуулалтын асуудал хүндрэлтэй	23.3	24.5	46.4	3.5	2.3	100.0
Хяналт шалгалт, дарамт ихтэй	24.8	16.4	54.4	1.6	2.9	100.0
Татварын асуудал хүндрэлтэй	17.2	8.3	71.8	1.7	1.1	100.0
Бусад	9.8	4.9	31.7	12.2	41.5	100.0

Үйл ажиллагаа явуулах газар хязгаарлагдмал байдаг гэж 3436 уурхайчин (давхардсан тоогоор) үзсэн бөгөөд 43.9 хувь нь төвийн бүсэд, 31.8 хувь нь хангайн бүсэд, 18.8 хувь нь баруун бүсэд ногдож байна. Түүнчлэн санхүүгийн асуудал хүндрэлтэй буюу зээл авахад хүндрэлтэй байдаг гэж 994 уурхайчин (давхардсан тоогоор) тодорхойлсон бөгөөд тэдний 37.8 хувь нь төвийн бүсэд, 25.3 хувь нь баруун бүсэд, 21.6 хувь нь хангайн бүсэд тус тус ногдож байна.

Тоног төхөөрөмж дутагдалтай, хүчин чадал муу байдаг гэж 1629 уурхайчин (давхардсан тоогоор) хариулсан бөгөөд 34.1 хувь нь баруун бүсэд, 25.0 хувь нь хангайн бүсэд, 24.2 хувь нь төвийн бүсэд ногдож байна. Зохион байгуулалтын асуудал хүндрэлтэй байдаг гэж 711 уурхайчин (давхардсан тоогоор) хариулсны 46.4 хувь нь төвийн бүсийнх, 24.5 хувь нь хангайн бүсийнх, 23.3 хувь нь баруун бүсийнх байна.

Хяналт шалгалт, дарамт ихтэй байдаг гэж 2296 уурхайчин (давхардсан тоогоор) тодорхойлсон бөгөөд 54.4 хувь нь төвийн бүсийнх, 24.8 хувь нь баруун бүсийнх, 16.4 хувь нь хангайн бүсийнх тус тус байна. Татварын асуудал хүндрэлтэй гэж 471 уурхайчин (давхардсан тоогоор) үзсэн бөгөөд 71.8 хувь нь төвийн бүсэд, 17.2 хувь нь баруун бүсэд ногдож байна.

ХҮСНЭГТ 5.9. БИЧИЛ УУРХАЙ ЭРХЛЭГЧДЭД ТУЛГАРДАГ ХҮНДРЭЛ, БЭРХШЭЭЛ, ашигт малтмалын төрлөөр, хувиар

Хүндрэл, бэрхшээлийн төрөл	БҮГД	Ашигт малтмалын төрөл							
		Алт	Нүүрс	Жонш	Гянт-болд	Цагаан тугалга	Шохойн чулуу	Үнэт чулуу	Давс
БҮГД	100.0	80.7	5.7	8.6	3.5	0.4	0.1	1.0	0.1
Хүндрэл, бэрхшээл тулгардаггүй	100.0	67.8	16.9	9.5	1.1	0.6	0.1	3.2	0.7
Хүндрэл, бэрхшээл тулгардаг	100.0	82.0	4.5	8.5	3.7	0.4	0.1	0.8	0.1
Хууль эрх зүйн орчин боломжийн түвшинд бүрдээгүй	100.0	86.7	1.2	7.9	2.7	-	0.1	1.4	-
Ашигт малтмалын гарц муу	100.0	81.9	1.9	10.2	4.8	0.4	-	0.7	0.1
Үйл ажиллагаа явуулах газар хязгаарлагдмал	100.0	87.1	2.5	7.5	1.8	0.6	-		100.0

ХҮСНЭГТ 5.9-ийн үргэлжлэл

Хүндрэл, бэрхшээлийн төрөл	БҮГД	Ашигт малтмалын төрөл							
		Алт	Нүүрс	Жонш	Гянт- болд	Цагаан тугалга	Шохойн чулуу	Үнэт чулуу	Давс
Санхүүгийн асуудал хүндрэлтэй (зээл авах)	100.0	69.3	13.1	13.5	3.1	0.3	0.1	0.4	0.2
Тоног төхөөрөмж дутагдалтай, хүчин чадал муу	100.0	64.5	16.3	9.7	7.4	1.1	0.2	0.6	0.2
Зохион байгуулалтын асуудал хүндрэлтэй	100.0	89.0	3.5	5.5	1.4	-	-	0.6	-
Хяналт шалгалт, дарамт ихтэй	100.0	87.3	3.6	4.1	4.6	0.1	0.1	0.2	-
Татварын асуудал хүндрэлтэй	100.0	74.7	1.1	17.2	1.9	0.4	0.0	4.7	-
Бусад	100.0	29.3	41.5	17.1	2.4	-	-	9.8	-

Бичил уурхай эрхлэгчдэд тулгардаг нийт хүндрэл, бэрхшээлийг ашигт малтмалын төрлөөр нь авч үзвэл хүндрэл, бэрхшээлүүдийн 82.0 хувь нь алт олборлогчдод тулгардаг бол 4.5 хувь нь нүүрс олборлогчдод, 8.5 хувь нь жонш олборлогчдод, 3.7 хувь нь гянтболд олборлогчдод тулгарч байгаа нь судалгаанаас харагдаж байна.


Судалгааны дүнгээр нийт бичил уурхай эрхлэгчдийн 6403 нь буюу 73.6 хувь нь засаг захиргааны байгууллагуудтай харьцахад хүндрэлгүй байдаг гэж хариулсан бол 2299 нь буюу 26.4 хувь нь хүндрэлтэй байдаг гэж хариулжээ. Давхардсан тоогоор орон нутгийн засаг захиргааны байгууллагатай харьцахад хүндрэлтэй байдаг гэж 1351 бичил уурхайчин үзсэн бол 736 хүн мэргэжлийн хяналтын байгууллагыг харьцахад хүндрэлтэй байгууллага гэж тодорхойлжээ. Харин татварын байгууллагыг 174 уурхайчин нэрлэсэн бол хууль, хяналтын байгууллагыг 858 уурхайчин харьцахад хүндрэлтэй байгууллагаар тодорхойлсон байна.

ХҮСНЭГТ 5.10. БИЧИЛ УУРХАЙ ЭРХЛЭГЧДИЙН ХАРЬЦАХАД ХҮНДРЭЛТЭЙ БАЙДАГ БАЙГУУЛЛАГЫН ТӨРӨЛ, хувиар, бүсээр

Байгууллагын төрөл	Бүс					БҮГД
	Баруун бүс	Хангайн бүс	Төвийн бүс	Зүүн бүс	Улаанбаатар	
Орон нутгийн засаг захиргааны байгууллага	32.2	18.2	44.0	4.4	1.1	100.0
Мэргэжлийн хяналтын байгууллага	25.8	23.5	42.1	6.8	1.8	100.0
Татварын байгууллага	23.6	32.8	42.0	-	1.7	100.0
Хууль, хяналтын байгууллага	16.2	18.8	63.5	1.0	0.5	100.0
Ашигт малтмалын газар	15.3	29.1	46.0	7.3	2.2	100.0
Бусад	22.6	9.7	67.7	-	-	100.0

Засаг захиргааны байгууллагатай харилцахад хүндрэлтэй байдаг гэж хариулсан иргэдийн 45.1 хувь нь газрын зөвшөөрөлтэй холбоотой асуудал, 18.7 хувь нь ашигт малтмалын тусгай зөвшөөрөлтэй холбоотой асуудал, 18.6 хувь нь дүрэм, журамтай холбоотой асуудал, 16.7 хувь нь төрийн байгууллагын ажилтны хүнд сурталтай холбоотой асуудал хүндрэлтэй байдаг гэж хариулжээ.

ЗУРАГ 5.8. ОРОН НУТГИЙН ЗАСАГ, ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГАТАЙ ХАРИЛЦАХАД ХҮНДРЭЛТЭЙ БАЙДАГ АСУУДЛЫН ТӨРӨЛ, хувиар



Судалгаанд хамрагдсан бичил уурхай эрхлэгчдийн дээр дурдсан хүндрэлтэй асуудлуудыг шийдвэрлэсэн байдлыг бүсийн түвшинд авч үзэхэд хууль эрх зүйн дагуу шийдвэрлэсэн 151 асуудлын 37.8 хувь нь төвийн бүсэд, 30.5 хувь нь баруун бүсэд, 26.5 хувь нь хангайн бүсэд ногдож байна. Гэрээ, хэлцэл хийж шийдвэрлэсэн 142 асуудлын 57.0 хувь нь төвийн бүсэд, 28.2 хувь нь баруун бүсэд хамаарч байна.

Торгууль, төлбөр төлж шийдвэрлэсэн 425 асуудлын 79.1 хувь нь төвийн бүсэд, 16.5 хувь нь баруун бүсэд ногдож байгаа бол бэлэг, шан харамж, хахууль өгч шийдвэрлэсэн 32 асуудлын 71.9 хувь нь төвийн бүсэд, 15.6 хувь нь баруун бүсэд, 12.5 хувь нь хангайн бүсэд тус тус ногдож байна. Түүнчлэн хүч хэрэглэн шийдвэрлэсэн 60 асуудлын 63.4 хувь нь төвийн бүсэд, 33.3 хувь нь баруун бүсэд ногдож байна.

Харин 1595 бичил уурхай эрхлэгчийн асуудал шийдвэрлэгдээгүй байгаагаас 38.4 хувь нь төвийн бүсийнх, 28.8 хувь нь хангайн бүсийнх, 27.5 хувь нь баруун бүсийнх байна.

ХҮСНЭГТ 5.11. БИЧИЛ УУРХАЙ ЭРХЛЭГЧДЭД ТУЛГАРДАГ ХҮНДРЭЛ, БЭРХШЭЭЛТЭЙ АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭСЭН БАЙДАЛ, бүсээр

Шийдвэрлэсэн байдал	Баруун бүс		Хангайн бүс		Төвийн бүс		Зүүн бүс		Улаанбаатар		БҮГД	
	тоо	%	тоо	%	тоо	%	тоо	%	тоо	%	тоо	%
Хууль эрх зүйн дагуу шийдвэрлэсэн	46	30.5	40	26.5	57	37.7	4	2.6	4	2.6	151	100.0
Гэрээ, хэлцэл хийгдсэн	40	28.2	19	13.4	81	57.0	1	0.7	1	0.7	142	100.0
Торгууль, төлбөр төлсөн	70	16.5	16	3.8	336	79.0	2	0.5	1	0.2	425	100.0
Бэлэг, шан харамж, хахууль өгсөн	5	15.6	4	12.5	23	71.9	-	-	-	-	32	100.0
Хүч хэрэглэн шийдвэрлэсэн	20	33.3	2	3.3	38	63.4	-	-	-	-	60	100.0
Бусад	9	32.1	-	-	19	67.9	-	-	-	-	28	100.0
Шийдвэрлээгүй	438	27.5	460	28.8	613	38.4	63	3.9	21	1.3	1 595	100.0

Судалгаанд хамрагдсан бичил уурхай эрхлэгчдийн олборлосон ашигт малтмалаа борлуулахад гардаг хүндрэл, бэрхшээлийн талаар судлан үзэхэд бичил уурхайчдын олборлосон ашигт малтмалыг чэнжүүд зах зээлийн үнээс доогуур худалдан авдаг явдал нь тэдний хувьд хамгийн том хүндрэл болж байна. Энэ хүндрэлийг судалгаанд хамрагдсан 8702 бичил уурхайчдын 6158 (давхардсан тоогоор) нь буюу 70.8 хувь нь нэрлэсэн байна.

Үүний дараах хүндрэлд орон нутгийн банкинд тушаах боломжгүй байгаа явдал орж байгаа бөгөөд энэ хүндрэлийг 1943 (давхардсан тоогоор) хүн нэрлэсэн байна. Харин 944 бичил уурхайчин буюу 10.8 хувь нь ашигт малтмалаа борлуулахад ямар нэгэн хүндрэлтэй асуудал гардаггүй хэмээн хариулсан байна.

ХҮСНЭГТ 5.12. АШИГТ МАЛТМАЛ БОРЛУУЛАХАД ТУЛГАРДАГ ХҮНДРЭЛ, БЭРХШЭЭЛ, ашигт малтмалын төрлөөр

Ашигт малтмалын төрөл	Худалдан авах цэг байхгүй		Борлуулалтын цэг хол		Орон нутгийн банкинд тушаах боломжгүй	
	тоо	%	тоо	%	тоо	%
БҮГД	1 563	100.0	1106	100.0	1 943	100.0
Алт	1 128	72.2	779	70.4	1 854	95.4
Нүүрс	142	9.1	15	1.4	3	0.2
Жонш	123	7.9	240	21.7	69	3.6
Гянтболд	93	6	47	4.2	7	0.4
Цагаан тугалга	6	0.4	3	0.3	8	0.4
Шохойн чулуу	3	0.2	-	-	1	0.1
Үнэт чулуу	55	3.5	17	1.5	1	0.1
Давс	13	0.8	5	0.5	-	-

ХҮСНЭГТ 5.12-ын үргэлжлэл


Ашигт малтмалын төрөл	Чэнжүүд зах зээлээр үнээс доогуур үнээр худалдан авдаг		Бусад		Хүндрэлгүй	
	тоо	%	тоо	%	тоо	%
БҮГД	6 158	100.0	43	100.0	944	100.0
Алт	5 229	84.9	9	20.9	431	45.7
Нүүрс	107	1.7	20	46.5	435	46.1
Жонш	473	7.7	8	18.6	75	7.9
Гянтболд	248	4	1	2.3	-	-
Цагаан тугалга	31	0.5	1	2.3	1	0.1
Шохойн чулуу	3	-	1	2.3	-	-
Үнэт чулуу	59	1	2	4.7	2	0.2
Давс	8	0.1	1	2.3	-	-

Чэнжүүд зах зээлийн үнээс доогуур худалдан авдаг хүндрэлийн 84.9 хувь нь алт олборлогч, 7.7 хувь нь жонш олборлогчид хариулсан байна. Орон нутгийн банкинд тушаах боломжгүйн хүндрэлийн 95.4 хувь нь алт олборлогчид хариулсан байна.

Харин худалдан авах цэг байхгүйн хүндрэлийн 72.2 хувийг алт олборлогчид, 9.1 хувийг нүүрс олборлогчид, 7.9 хувийг жонш олборлогчид нэрлэжээ. Борлуулалтын цэг хол байх хүндрэлийн 70.4 хувь нь алт олборлогчдод, 21.7 хувь нь жонш олборлогчдод тулгарч байна.

Бичилуурхайэрхлэгчдийнашигтмалтмалолборлолтынгазрыгшийдвэрлэсэн байдлыг судлан үзэхэд 68.7 хувь нь газрын асуудлыг шийдвэрлээгүй, 31.3 хувь нь дараах байдлаар шийдвэрлэсэн байна.

ЗУРАГ 5.9. АШИГТ МАЛТМАЛ ОЛБОРЛОЖ БҮЙ ГАЗРЫН АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭСЭН БАЙДАЛ, төрлөөр, хувиар



Бичил уурхай эрхлэгчдийн ашигт малтмал олборлолтын газрыг шийдвэрлэсэн байдлыг ашигт малтмалын төрлөөр авч үзвэл алт олборлогчдын 78.0 хувь нь, нүүрс олборлогчдын 19.6 хувь нь, жонш олборлогчдын 26.3 хувь нь, гянтболд олборлогчдын 84.3 хувь нь, цагаан тугалга олборлогчдын 78.0 хувь нь, шохойн чулуу олборлогчдын 83.3 хувь нь, үнэт чулуу олборлогчдын 80.2 хувь нь, давс олборлогчдын 38.9 хувь нь тус тус газрын асуудлаа шийдвэрлээгүй байна.

Жонш олборлогчдын 66.1 хувь, давс олборлогчдын 55.6 хувь нь сум, дүүргийн засаг даргатай бичгээр гэрээ байгуулж газрын асуудлаа шийдвэрлэсэн бол шохойн чулуу олборлогчдын 16.7 хувь, алт олборлогчдын 5.0 хувь нь сум, дүүргийн засаг даргатай аман гэрээ байгуулж газрын асуудлаа шийдвэрлэсэн байна.

Харин нүүрс олборлогчдын 9.7 хувь нь ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй бичгэн гэрээ байгуулж, харин 64.3 хувь нь аман гэрээ байгуулж ашигт малтмал олборлолтын газрын асуудлаа шийдвэрлэжээ. Түүнчлэн цагаан тугалга олборлогчдын 19.5 хувь, гянтболд олборлогчдын 13.8 хувь, жонш олборлогчдын 5.1 хувь, нүүрс олборлогчдын 4.4 хувь, алт олборлогчдын 4.1 хувь нь тус тус аж ахуйн нэгжийн талбай дээр гэрээгүй ажилладаг байна.

**ХҮСНЭГТ 5.13. БИЧИЛ УУРХАЙ ЭРХЛЭГЧДИЙН АШИГТ МАЛТМАЛ
ОЛБОРЛОЛТЫН ГАЗРЫГ ШИЙДВЭРЛЭСЭН БАЙДАЛ, ашигт малтмалын
төрлөөр**

Төрөл	Ашигт малтмалын төрөл							
	Алт	Нүүрс	Жонш	Гянт-болд	Цагаан тугалга	Шохойн чулуу	Үнэт чулуу	Давс
БҮГД	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
Шийдвэрлээгүй	78.0	19.6	26.3	84.3	78.0	83.3	80.2	38.9
Шийдвэрлэсэн	22.0	80.4	73.7	15.7	22.0	16.7	19.8	61.1
Сум/дүүргийн даргатай бичгээр гэрээ байгуулсан	9.7	1.1	66.1	0.4	2.4	-	19.8	55.6
Сум/дүүргийн даргатай аман гэрээ байгуулсан	5.0	0.1	0.9	0.4	-	16.7	-	-
Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй бичгэн гэрээ	0.1	9.7	-	0.4	-	-	-	-
Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй аман гэрээ	0.4	64.2	0.5	-	-	-	-	-
Засаг дарга, тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй гурвалсан гэрээ	2.5	0.8	1.0	0.8	-	-	-	5.6
Аж ахуйн нэгжийн талбай дээр гэрээгүй ажилладаг	4.1	4.4	5.1	13.8	19.5	-	-	-
Бусад	0.1	-	0.1	-	-	-	-	-

Судалгаагаар бичил уурхай эрхлэгчдээс үйл ажиллагаагаа явуулахад төрийн болон төрийн бус байгууллагаас ямар төрлийн тусламж, дэмжлэг авахыг хүсдэг талаар асуухад давхардсан тоогоор тэдний 27.6 хувь нь үйл ажиллагаа явуулах газрын асуудлаа шийдвэрлүүлэхийг, 13.9 хувь нь хууль, эрх зүйн орчныг сайжруулахыг, 10.8 хувь нь байгаль орчныг нөхөн сэргээхийг, 10.4 хувь нь зээл, санхүүгийн тусламж авахыг, 10.2 хувь нь хөдөлмөр хамгаалал, аюулгүй байдлыг сайжруулахыг хүсдэг байна.

Түүнчлэн 9.9 хувь нь техник, технологийн тусламж, дэмжлэг авахыг, 9.6 хувь нь хариуцлагатай нөхөрлөлийн системийг нэвтрүүлэхийг, 7.5 хувь нь албан ёсны бүртгэлтэй болохыг хүссэн байна.

Харин судалгаанд хамрагдсан 8702 иргэдийн 0.7 хувь нь ямар нэгэн тусламж авахыг хүсээгүй байна.

ХАВСРАЛТ

АСУУЛГЫН ХУУДАС

Үндэсний статистикийн хорооны даргын 2012 оны
07-р сарын 06-ны өдрийн 184 тоот тушаалын II
хавсралтаар батлав.

Маягт БУС-1

Мэдээллийн нууцыг Монгол Улсын Хувь хүний нууцын тухай болон Статистикийн тухай
хуулийн 22 дугаар зүйлийн 3 дугаар заалтын дагуу нууцлан хадгална.

БИЧИЛ УУРХАЙН СУДАЛГАА 2012

БҮЛЭГ 1. ХАЯГИЙН ХЭСЭГ

Ашигт малтмал олборлож буй засаг, захиргаа, нутаг дэвсгэрийн мэдээлэл

Д/д	Асуулт	Хариулт
		Код
1.1	Аймаг/нийслэл	
1.2	Сум/дүүрэг	
1.3	Баг/хороо	
1.4	Байршил (нийслэл-1, аймгийн төв-2, сумын төв-3, хөдөө-4)	
1.5	Ашигт малтмалын ордын нэр	
1.6	Тоологч	
1.7	Шивэгч	
1.8	Асуулгын хуудасны дугаар	
1.9	Холбоо барих утас	

БҮЛЭГ 2. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Д/д	Асуулт	Хариулт	Алхам
		КОД	
2.1	Та засаг, захиргааны харьяаллаа хэлнэ үү. (албан ёсны бүртгэлд бүртгэгдсэнээр)	Аймаг/нийслэлийн нэр Сум/дүүргийн нэр Баг/хорооны нэр	
2.2	Эцэг/эх-ийн нэр		
2.3	Өөрийн нэр		
2.4	Регистрийн дугаар		
2.5	Хүйс	Эрэгтэй 1 Эмэгтэй 2	
2.6	Нас (бүтэн жилээр)		
2.7	Танай өрхийн ам бүлийн тоо хэд вэ?	1. Ам бүлийн тоо 2. Үүнээс бичил уурхайд ажиллаж байгаа хүний тоо	
2.8	Та эзэмшсэн боловсролын дээд түвшингээ хэлнэ үү.	Боловсролгүй 1 Бага 2 Суурь 3 Бүрэн дунд 4 Техникийн болон мэргэжлийн 5 Тусгай мэргэжлийн дунд 6 Дээд 7	
2.9	Та эзэмшсэн мэргэжлээ хэлнэ үү.	Мэргэжил	
2.1	Та бичил уурхайн үйл ажиллагааг хэдэн жил эрхэлж байна вэ?	Жил	

Хуудас 2

Д/д	Асуулт	Хариулт	Алхам
2.1	Та ажил эрхлэлтийн байдлаа хэлнэ үү. *	Нөхөрлөлийн ахлагч/ажил олгогч 1 Нөхөрлөлийн гишүүн 2 Хувиараа (дангаараа) бичил уурхайн үйл ажиллагаа эрхлэгч 3 Бичил уурхайн туслах үйл ажиллагаа эрхлэгч 4 Гэр бүлийн бизнест цалин хөлсгүй оролцогч 5	2.13 2.17 Асуулт 2.16
2.1	Танай нөхөрлөлийн гишүүдийн тоо хэд вэ?	1. Нийт 2. Үүнээс эмэгтэй	
2.1	Та нөхөрлөлийн нэрээ хэлнэ үү.		
